Хүснэгт 9. Стандартаас хэтэрсэн бактерлогийн үзүүлэлтийн хэмжээ.....	21
Хүснэгт 10. Шимт хөрсний овоолгуудын үржил шимийн үзүүлэлт.....	21
Хүснэгт 11. Шимт хөрсний овоолгуудын ширхэгийн бүрэлдэхүүн	21
Хүснэгт 12. Хөрсөн дэх нефть бүтээгдэхүүний агууламж.....	22
Хүснэгт 13. агаарын чанарын хэмжилтийн хуудас.....	25
Хүснэгт 14. агаарын чанарын хэмжилтийн хуудас.....	26


Зургийн жагсаалт

Зураг 1. Өмнөговь аймгийн Мандал-Овоо сум “Бурхан Дэл”-ийн уурхайн байршил	5
Зураг 2. Мониторингийн цэгүүдийн байршил	6
Зураг 3. Газрын доорх усны дээжлэлт /3 дугаар улирал/	9
Зураг 4. Кемпийн ундны усны худаг, уурхай орчмын малчны худаг	9
Зураг 5. Ундны усны дээжлэлт /3 дугаар улирал/	9
Зураг 6. Усны дээжүүдийн лац битүүмжлэл /3 дугаар улирал/	10
Зураг 7. Уурхайн усны хяналт шинжилгээний цэгүүдийн байршил	10
Зураг 8. Газрын доорх усны цооногуудын усны түвшин хэмжилт /3 дугаар улирал/	14
Зураг 10. Хөрсний дээжлэлт /3 дугаар улирал/	18
Зураг 11. Агаарын чанарын хэмжилт /3 дугаар улирал/	23

1. БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ГЭРЭЭТ АЖЛЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

“Мандал Ресурс” ХХК нь Өмнөговь аймгийн Мандал-Овоо сумын нутаг дэвсгэрт “Бурхан дэл” алтны үндсэн ордыг ашиглах төслийг хэрэгжүүлэн ажиллаж эхэлж байгаа бөгөөд батлагдсан Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан (БОННУ), 2024 онд батлагдсан тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-г тус тус үндэслэн байгаль орчны мэргэжлийн эрх бүхий байгууллага “Өлзий Энвайронментал” ХХК тус төслийн байгаль орчны хяналт шинжилгээний ажлыг гүйцэтгэх гэрээ байгуулан ажиллаж байна.

Энэхүү гэрээт ажлын хүрээнд “Бурхан Дэл” уурхайн 2024 оны батлагдсан байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу “Өлзий Энвайронментал” ХХК-ийн мэргэжилтнүүд уурхайн талбайд 2024 оны 7 дугаар сард төслийн талбай орчимд тогтоосон цэгүүдэд агаарын чанарын хэмжилт, дуу шуугианы хэмжилт, газрын доорх усны түвшин хэмжилт, усны чанарын дээжлэлт, ажилчдын кемпийн ундны ус микробиологийн шинжилгээний дээжлэлт болон хөрсний чанарын шинжилгээний дээжлэлтүүдийн ажлыг гүйцэтгэн дээжүүдийг итгэмжлэгдсэн лабораториудад шинжлүүлэн үр дүнгүүдийг нэгтгэн боловсрууллаа.



Зураг 1. Өмнөговь аймгийн Мандал-Овоо сум “Бурхан Дэл”-ийн уурхайн байршил


1.1. Байгаль орчны хяналт шинжилгээний ажлын зорилго, хамрах хүрээ

Төлөвлөгөөт байгаль орчны хяналт шинжилгээний ажлын үндсэн зорилго нь “Бурхан Дэл” уурхайн үйл ажиллагааны явцад байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг илрүүлж тухайн сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд оршино.

ОХШХ-ийг хэрэгжүүлснээр төсөл хэрэгжүүлэгчийн үйл ажиллагаа нь Монгол улсын Усны тухай, Газрын хэвлийн тухай, Агаарын тухай, Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, Ашигт малтмалын тухай хуулиуд болон бусад холбогдох хууль, журам, стандартуудад нийцэж байгаа эсэхийг баталгаажуулах юм.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд “Бурхан Дэл” төслийн талбайд болон талбайн орчимд хийгдсэн агаар, ус, хөрсний чанарын хэмжилт дээжлэлтийн үр дүнг дараах асуудлуудыг тодорхойлох, үнэлэхэд ашигласан. Үүнд:

- Уурхайн бүх үе шатуудын явцад агаарын, хөрсний, усны шинж чанарт өөрчлөлт орж байгаа эсэхийг тогтмол хянах;
- Орон нутгийн иргэдийн санал, гомдолтой холбогдуулан бохирдол, хомсдолын талаар баталгаат мэдээллээр хангах;
- Хэмжилт, дээжлэлт, шинжилгээний үр дүнгүүд Монгол улсын холбогдох стандартуудын шаардлагыг хангахгүй буюу стандартад заасан хүлцэх хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд бохирдлыг арилгах, нөлөөллийг багасгах залруулах болон орчны бохирдлоос сэргийлэх үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх;
- Байгаль орчны хяналт шинжилгээний сар тутмын, улирал тутмын, жил тутмын мэдээллийн санг бий болгож урт хугацаанд тодорхой давтамжит хэмжилт, шинжилгээний дүнгүүдийг харьцуулан өөрчлөлтийг тасралтгүй хянах.



Зураг 2. Мониторингийн цэгүүдийн байршил

1.2. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт холбогдох Монгол улсын хууль тогтоомж, (MNS) стандартууд

- a) Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10.3 дахь заалт
- b) Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9.7 дахь заалт
- c) Ашигт малтмалын тухай хуулийн 38.1.2 дахь заалт, 39.1.3 даахь заалт
- d) Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29 –ний өдрийн А/618 тоот тушаалын хавсралт “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”
- e) Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн А/20 дугаар тушаалын хавсралт “Ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагааны журам”

“Бурхан Дэл” уурхайн төслийн талбайн байгаль орчны хяналт шинжилгээний ажлын үр дүнгүүдийг Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа дараах стандартуудтай харьцуулан өөрчлөлтүүдийг хянаж байна. Үүнд:

- Агаарын чанарын стандарт: Агаарын чанар, техникийн ерөнхий шаардлага. MNS 4585:2016
- Усны чанарын стандарт: Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ. MNS 0900:2018, Газрын доорх усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ. MNS 6148:2010, Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага. MNS 4586:1998
- Хөрсний чанарын стандарт: Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ. MNS 5850:2019

2. УСНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ

2.1. Усны чанарын хяналт шинжилгээний дээжлэлт

Усны хяналт шинжилгээний ажлын үндсэн зорилго нь уурхайн бүхий л үйл ажиллагааны явцад төслийн талбай орчимд гадаргын болон газрын доорх усанд физик болон химийн сөрөг нөлөөлөл үзүүлж байгаа эсэхэд хяналт тавих, оролцогч талуудыг болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлүүлэхэд оршино. Усанд үзүүлэх физик нөлөөлөлд усны түвшин орж байгаа бол химийн нөлөөлөлд усны химийн найрлага өөрчлөгдөх, тухайн усны өнгө, үнэр, амтанд өөрчлөлт орох зэрэг үзүүлэлтүүд ордог.

“Бурхан Дэл”-ийн уурхайн төслийн 2024 оны батлагдсан БОМТ-д тусгагдсаны дагуу уурхайн талбайд болон уурхайн талбайн эргэн тойронд 2 км хүртэлх радиус доторх нийт 10 уст цэгээс (гидрогеологийн цооног, малчны гар худаг, ажилчдын хотхоны худаг) дээжлэлтийн ажлыг гүйцэтгэлээ. 2024 оны 3 дугаар улирлын усны чанарын хяналт шинжилгээний усны чанарын дээжлэлтийн мэдээллийг Хүснэгт 1-т үзүүлэв.

Орчны хяналт шинжилгээний ажлын усны дээжлэлтийн ажлын хүрээнд 2024 оны 07 дугаар сарын байдлаар гүний усны 6 ширхэг, ундны усны 2 ширхэг, микробиологийн 2 ширхэг нийт 11 ширхэг усны дээжүүдийг авч шинжилгээг итгэмжлэгдсэн “ХанЛаб” лабораторид гүйцэтгүүлж гарсан үр дүнг нэгтгэн боловсруулсан.

“Бурхан Дэл”-ийн уурхайн талбайн орчмын малчны худаг нь хур тунадасны усаар тэжээгддэг учир хур тунадасны хэмжээнээс шалтгаалж дээжлэлт гүйцэтгэх боломжгүй байсан.

Хүснэгт 1. 2024 оны 3 дугаар улирлын усны дээжлэлтийн ажлын тэмдэглэл

№	Дээжлэлтийн цэгийн нэр	Дээжийн дугаар	Дээжлэлт хийгдсэн эсэх
			7-р сар
1	Гүний усны цооног	УХЦ-01	Тийм
2	Гүний усны цооног	УХЦ-02	Тийм
3	Гүний усны цооног	УХЦ-03	Тийм
4	Гүний усны цооног	УХЦ-04	Тийм
5	Гүний усны цооног	УХЦ-05	Тийм
6	Гүний усны цооног	УХЦ-06	Тийм
7	Малчны худаг-1	УХЦ-07	Үгүй
8	Кемпийн усны худаг-2	УХЦ-08	Тийм
9	Кемп гал тогоо	УХЦ-09	Тийм
10	Хяналтын цэвэр ус (Blank)	УХЦ-10	Тийм
11	Кемпийн усны худаг-2 (Микробиологи)	УХЦ-08	Тийм
12	Кемп гал тогоо (Микробиологи)	УХЦ-09	Тийм

Хүснэгт 2. 2024 оны 3 дугаар улирлын усны дээжүүдийн төрөл, хэмжээ

№	Сар	Дээжийн төрөл					
		Гүний ус	Хяналтын дээж	Ундны ус	Микробиологи	Бохир ус	Нийт
1	7-р сар	6	1	2	2	0	11
	Нийт	6	1	2	2	0	11



Зураг 3. Газрын доорх усны дээжлэлт /3 дугаар улирал/




Зураг 4. Кемпийн ундны усны худаг, уурхай орчмын малчны худаг



Зураг 5. Ундны усны дээжлэлт /3 дугаар улирал/



Зураг 6. Усны дээжүүдийн лац битүүмжлэл /3 дугаар улирал/



Зураг 7. Уурхайн усны хяналт шинжилгээний цэгүүдийн байршил

2.2. Усны дээжүүдийн лабораторийн шинжилгээний үр дүн

“Бурхан Дэл”-ийн төсөл хэрэгжиж буй талбай орчмын усны хяналт шинжилгээний цэгүүдээс 2024 оны 07 дугаар сарын байдлаар гүний усны 6 ширхэг, ундны усны 2 ширхэг, микробиологийн 2 ширхэг, хяналтын 1 ширхэг нийт 11 ширхэг усны дээжүүдийг авч шинжилгээг итгэмжлэгдсэн “ХанЛаб” лабораторид тус бүр холбогдох үзүүлэлтүүдийг тодорхойлуулж, шинжилгээний үр дүнг MNS 6148:2010, MNS 0900:2018, MNS 4586:1998, MNS 4943:2015 стандартуудтай тус тус харьцуулсан.

“Бурхан Дэл”-ийн уурхайн 2024 оны 3 дугаар улирлын усны хяналт шинжилгээний цэгүүдээс авсан дээжүүдийн лабораторийн шинжилгээний үр дүнгүүдийн холбогдох стандартаас хэтэрсэн үзүүлэлтүүдийг хяналт шинжилгээний үзүүлэлтийг доорх хүснэгтүүдээс харна уу.

2.2.1. Газрын доорх усны шинжилгээний үр дүн

Газрын доорх усны дээжүүдийн шинжилгээний үр дүнгүүдийг холбогдох стандартуудтай харьцуулахад УХЦ-10 нь цэвэр ус буюу цооногийн усны шинж чанарыг харьцуулах зорилгоор шинжлүүлсэн бөгөөд УХЦ-01, УХЦ-02, УХЦ-03, УХЦ-04, УХЦ-05, УХЦ-06 дугаартай уурхайг тойрсон гүний усны цооногийн дээжүүдэд эрдэсжилтийн агууламж стандартаас зарим үзүүлэлт нь хэтрээгүй ч хлорид, сульфат, бор, төмөр, манганы хэмжээ стандартын хүлцэх хэмжээнээс их байгаа нь тухайн ус нь эрдэсжилт ихтэй, хатуу чанарын ус болохыг илэрхийлж байна. Мөн хлорид, сульфат, бор, төмөр, манган зэрэг элементүүд дээжүүдэд илэрсэн нь тухайн хяналтын цэгүүд дэх уст давхарга нь урт хугацаанд хөдөлгөөнд ороогүй болон тухайн орчны хөрс болон усны байгалийн өгөгдөлд нь стандартад заасан зөвшөөрөгдөх дээд агууламжаас их хэмжээнд агуулагдаж байдагтай холбоотой хэмээн үзэж байна.

Хүснэгт 3. Газрын доорх усны шинжилгээний үр дүн /2024 оны 7-р сар/

Гүний усны цооногийн шинжилгээний үр дүн										
№	Үзүүлэлт	Нэгж	УХЦ-01	УХЦ-02	УХЦ-03	УХЦ-04	УХЦ-05	УХЦ-06	УХЦ-10	MNS 6148:2010
1	pH	-	5.92	5.12	5.30	7.63	5.65	9.66	7.94	6.5-8.5
2	Кали (K ⁺)	мг/л	10.01	16.62	20.24	14.11	20.01	0.98	0.23	-
3	Натри (Na ⁺)	мг/л	4350	6890	9244	9989	10921	190.1	2.23	-
4	Аммони, (NH ₄ ⁺)	мг/л	3.00	3.50	4.00	<0.10	<0.10	1.00	0.25	-
5	Кальци (Ca ²⁺)	мг/л	196.1	545.9	626.9	378.9	466.4	3.08	11.57	-
6	Магни (Mg ²⁺)	мг/л	195.4	494.9	725.3	554.4	651.4	1.29	0.63	-
7	Хлорид, (Cl ⁻)	мг/л	4628	7980	11940	11494	12560	98.69	8.51	350.0
8	Сульфат (SO ₄ ²⁻)	мг/л	4024	6786	7272	8232	9264	135.8	<5.0	1.00
9	Нитрит (NO ₂)	мг/л	<0.05	<0.05	<0.05	0.06	<0.05	<0.05	<0.05	1.00
10	Нитрат, (NO ₃ ⁻)	мг/л	<0.01	<0.01	<0.01	<0.01	<0.01	<0.01	0.03	50.00
11	Карбонат (CO ₃ ²⁻)	мг/л	<1.5	<1.5	<1.5	<1.5	<1.5	30.00	<1.5	-
12	Гидрокарбонат (HCO ₃ ²⁻)	мг/л	70.17	109.8	112.9	118.9	195.2	118.9	30.51	-
13	Нийт хатуулаг	мг-экв/л	25.87	67.97	90.98	64.54	76.89	0.26	0.63	-

14	Хуурай үлдэгдэл, TDS	мг/л	13494	22902	30006	30824	34078	522.0	39.00	-
15	Цахилгаан дамжуулах чанар, EC	μS/cm	19810	34880	48120	46200	53680	764.0	65.89	-
17	Мөнгө, Ag	мг/л	<0.01	<0.01	<0.01	<0.01	<0.01	<0.01	<0.01	-
18	Хөнгөнцагаан, Al	мг/л	<0.025	<0.025	<0.025	<0.025	<0.025	0.39	<0.025	0.50
19	Мышьяк, As	мг/л	<0.01	<0.01	<0.01	<0.01	<0.01	<0.01	<0.01	0.01
20	Бари, Ba	мг/л	0.05	0.05	0.07	0.07	0.03	<0.01	<0.01	2.00
21	Бор, B	мг/л	2.00	2.25	2.27	2.18	2.90	0.34	0.01	1.00
22	Берелли, Be	мг/л	<0.001	<0.001	<0.001	<0.001	<0.001	<0.001	<0.001	0.001
23	Висмут, Bi	мг/л	<0.005	<0.005	<0.005	<0.005	0.05	0.008	<0.005	
24	Кадми, Cd	мг/л	<0.001	0.001	0.001	<0.001	0.025	<0.001	<0.001	0.003
25	Кобальт, Co	мг/л	<0.001	<0.001	0.001	<0.001	0.015	0.001	<0.001	-
26	Хром, Cr	мг/л	<0.005	<0.005	<0.005	<0.005	<0.005	<0.005	<0.005	0.07
27	Зэс, Cu	мг/л	<0.02	<0.02	<0.02	<0.02	<0.02	<0.02	<0.02	1.00
28	Төмөр, Fe	мг/л	1.74	49.63	44.92	0.27	832.6	0.90	0.04	0.30
29	Марганец, Mn	мг/л	3.03	7.11	7.65	2.57	23.60	0.03	<0.01	0.10
30	Молибден, Mo	мг/л	<0.005	<0.005	<0.005	0.005	<0.005	0.008	<0.005	0.04
31	Никель, Ni	мг/л	<0.005	<0.005	<0.005	<0.005	<0.005	<0.005	<0.005	0.10
32	Фосфор, P	мг/л	<0.05	<0.05	<0.05	<0.05	0.13	0.13	<0.05	-
33	Хартугалга, Pb	мг/л	0.01	0.03	0.01	0.02	0.02	<0.01	<0.01	0.05
34	Сурьма, Sb	мг/л	<0.01	<0.01	<0.01	<0.01	<0.01	<0.01	<0.01	0.006
35	Селен, Se	мг/л	<0.01	<0.01	<0.01	<0.01	<0.01	0.02	<0.01	0.04
36	Титаниум, Ti	мг/л	<0.005	<0.005	<0.005	<0.005	<0.005	<0.005	<0.005	-
37	Ванади, V	мг/л	<0.01	<0.01	<0.01	<0.01	<0.01	<0.01	<0.01	0.06
38	Цайр, Zn	мг/л	0.01	0.02	0.01	0.01	0.08	0.01	0.01	5.00
37	Цианид, CN _{total}	мг/л	<0.002	<0.002	<0.002	<0.002	<0.002	<0.002	<0.002	0.10
37	Цианид, CN _{free}	мг/л	<0.002	<0.002	<0.002	<0.002	<0.002	<0.002	<0.002	0.005
39	Цианид, CN _{wad}	мг/л	<0.05	<0.05	<0.05	<0.05	<0.05	<0.05	<0.05	-

Нуруулдан уусгалтын талбай орчмын хяналтын цооногуудын усны дээжид шинжилгээгээр хүнцэл болон цианид илрээгүй болно.

Нуруулдан уусгалтын талбай орчмын хяналтын цооногуудын усны дээжүүдийн рН үзүүлэлт нь стандартад заасан хэмжээнээс хэтэрсэн тохиолдлууд тогтмол ажиглаж, цаашид уг үзүүлэлт НУ-ын хяналтын цооногуудын усны шинжилгээний үр дүнд стандартад заасан хэмжээнээс хэтэрсэн тохиолдол ажиглагдсаар байвал нарийвчилсан судалгааг хийх шаардлагатай.

Усны урвалын орчин нь хүчиллэг, сул шүлтлэг болон шүлтлэг гарсан нь усанд агуулагдах элементүүдтэй шууд холбоотой бөгөөд хөдөлгөөнгүй хуримтлагдаж шинж чанар нь өөрчлөгдсөн цооногийн усыг шавхалт хийж дахин дээжилж шинжлэх хэрэгтэй.

2.2.2. Ундны усны болон микробиологийн шинжилгээний үр дүн

Ундны усны чанарын шаардлага болон эрүүл ахуйн микробиологийн үзүүлэлтийг тодорхойлох дээжийг ажилчдын хотхоныг зөвхөн усаар хангах худгийн ус болон гал тогооны уснаас дээж авч шинжлүүлсэн.

Ундны усны үзүүлэлтүүд нь ундны усны стандартад заасан хэмжээнд байна.

Хүснэгт 4. Ундны усны шинжилгээний үр дүн /2024 оны 7-р сар/

Ундны усны шинжилгээний үзүүлэлт					
№	Үзүүлэлт	Нэгж	УХЦ-08	УХЦ-09	MNS 0900:2018
1	pH	-	8.06	8.28	6.5-8.5
2	Кали (K ⁺)	мг/л	0.87	0.82	-
3	Натри (Na ⁺)	мг/л	287.7	278.6	200.0
4	Аммони, (NH ₄ ⁺)	мг/л	<0.10	<0.10	1.50
5	Кальци (Ca ²⁺)	мг/л	44.50	48.16	100.0
6	Магни (Mg ²⁺)	мг/л	23.74	23.40	30.00
7	Хлорид, (Cl ⁻)	мг/л	168.4	166.7	350.0
8	Сульфат (SO ₄ ²⁻)	мг/л	340.8	333.6	500.0
9	Нитрит (NO ₂ ⁻)	мг/л	<0.05	<0.05	1.00
10	Нитрат, (NO ₃ ⁻)	мг/л	2.52	2.18	50.00
11	Карбонат (CO ₃ ²⁻)	мг/л	1.50	6.00	-
12	Гидрокарбонат (HCO ₃ ²⁻)	мг/л	286.8	274.6	-
13	Нийт хатуулаг	мг-экв/л	4.17	4.33	7.00
14	Хуурай үлдэгдэл, TDS	мг/л	1018	1004	1000
15	Цахилгаан дамжуулах чанар, EC	µS/cm	1492	1476	-
16	Мөнгө, Ag	мг/л	<0.01	<0.01	0.1
17	Хөнгөнцагаан, Al	мг/л	<0.025	0.03	0.50
18	Мышьяк, As	мг/л	<0.01	<0.01	0.01
19	Бари, Ba	мг/л	0.01	0.01	0.70
20	Бор, B	мг/л	0.75	0.74	2.40
21	Берелли, Be	мг/л	<0.001	<0.001	0.0002
22	Висмут, Bi	мг/л	<0.005	<0.005	-
23	Кадми, Cd	мг/л	<0.001	<0.001	0.003
24	Кобальт, Co	мг/л	<0.001	<0.001	-
25	Хром, Cr	мг/л	<0.005	<0.005	0.05
26	Зэс, Cu	мг/л	<0.02	<0.02	2.00
27	Төмөр, Fe	мг/л	0.07	0.10	0.30
28	Марганец, Mn	мг/л	0.02	<0.01	0.10
29	Молибден, Mo	мг/л	0.02	0.02	0.07
30	Никель, Ni	мг/л	<0.005	<0.005	0.02
31	Фосфор, P	мг/л	<0.05	<0.05	-
32	Хартугалга, Pb	мг/л	<0.01	<0.01	0.01
33	Сурьма, Sb	мг/л	<0.01	<0.01	0.02
34	Селен, Se	мг/л	<0.01	<0.01	0.04

35	Титаниум, Ti	мг/л	<0.005	<0.005	-
36	Ванади, V	мг/л	<0.01	<0.01	-
37	Цайр, Zn	мг/л	0.31	0.19	5.00
38	Уран, U	мг/л	<0.01	<0.01	0.03

Дээрх хүснэгтээс харахад натри нь ундны усанд зөвшөөрөгдөх хэмжээнээс их гарсан байгаа тул түүнтэй уялдаж хуурай үлдэгдэл нэмэгдсэн байна. Иймд ундны уснаас натрийг шүүх шүүлтүүрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх хэрэгтэй.

Ундны усны микробиологийн үзүүлэлтүүд нь ундны усны эрүүл ахуйн шаардлагын стандартад заасан хэмжээнд байна.

2.2.3. Бохир усны шинжилгээний үр дүн

Ажилчдын хотхоны ахуйн бохир усыг цэвэршүүлэх байгууламжгүй тул зөвхөн хуримтлуулж, Мандал-Овоо сумын Ахуйн бохир ус цэвэршүүлэх байгууламж руу тээвэрлэж, хүргүүлдэг байна. Иймд уурхайн талбай дээрх ахуйн бохир усыг цэвэршүүлж, үйл ажиллагаанд ашигладаггүй тул ахуйн бохир усны дээжлэлт хийгээгүй болно.

2.3. Газрын доорх усны түвшин хэмжилт

“Бурхан Дэл”-ийн уурхайн талбай орчмын газрын доорх усны түвшнийг хянах зорилгоор газрын доорх усны хяналтын нийт 6 цооногийн цэгт 2024 онд гүний усны түвшний өөрчлөлт байгаа эсэхийг хянах зорилгоор уурхай талбай дах гүний усны хяналтын цооногуудад хэмжилтийг хийж гүйцэтгэсэн.



Зураг 8. Газрын доорх усны цооногуудын усны түвшин хэмжилт /3 дугаар улирал/

Газрын доорх усны түвшин 2024 оны 7-р сарын 19-ний байдлаар уурхай орчмын хяналтын цооногуудад хийсэн хэмжилтээр 3.65-9.63м хооронд байв. Харин малчны худаг, кемпийн усны худагт түвшин хэмжих амсар байхгүй тул хэмжилт хийх боломжгүй байлаа.

Уурхайн үйл ажиллагаа усны нөлөө үзүүлж буй эсэх байдалд бодит хяналт хийхийн тулд малчны худаг, кемпийн усны худагт түвшин хэмжих амсар эсвэл нэмэлт хяналтын цооног гаргах хэрэгтэй.


Хүснэгт 5. Газрын доорх усны түвшин /2024 оны 7-р сар/

№	Цэгийн/Дээжийн дугаар, код/ Sample Point name ID	Цэгийн/Дээжийн нэр/ Sample Point name	Усны түвшин/ Water level ,m	Тайлбар/ Comments
			2024.07.19	
1	УХЦ-01	Хяналтын цооног-1	8.79	
2	УХЦ-02	Хяналтын цооног-2	8.56	
3	УХЦ-03	Хяналтын цооног-3	6.23	
4	УХЦ-04	Хяналтын цооног-4	5.16	
5	УХЦ-05	Хяналтын цооног-5	9.63	
6	УХЦ-06	Хяналтын цооног-6	3.65	
7	УХЦ-07	Малчны худаг	-	Хэмжих боломжгүй
8	УХЦ-08	Кемпийн усны худаг	-	Хэмжих боломжгүй

3. ХӨРСНИЙ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ

3.1. “Бурхан Дэл”-ийн уурхайн төслийн талбай орчмын хөрсний хэв шинж

“Бурхан Дэл” төслийн талбай орчим нь Монгол орны хөрсний бүс бүслүүрийн ангиллаар говийн элсэнцэр бор хөрсний хэв шинжид хамаарагдана. Хойшоо харсан хажууд чулуурхаг бор хөрс, урагшаа харсан хажууд элсэн хучаастай бор хөрс голлоно.



Зураг 9. Хөрсний хяналт шинжилгээний цэгүүдийн байршил

3.2. Хөрсний чанарын хяналт шинжилгээний дээжлэлт

Хөрсний чанарын шинжилгээний дээжлэлтийн гол зорилго нь “Бурхан Дэл”-ийн алтны үндсэн орд ашиглах төслийн батлагдсан БОННУ болон тухайн жилийн батлагдсан БОМТ-өөр орчны хяналт шинжилгээ хийхээр тогтоосон тул төслийн үйл ажиллагааны улмаас үүдэлтэй хөрсний чанарын өөрчлөлт, эвдрэл, бохирдол үүсэж байгаа эсэхийг улирал тутам тодорхойлох замаар сөрөг нөлөөллийг тогтмол хянах болно.

Төслийн нөлөөлөлд өртөх байдал дээр үндэслэж сонгосон 14 цэгээс 7 дугаар сард хөрсний дээжлэлтийг гүйцэтгэж тухайн хөрсний дээжүүдэд харгалзах үзүүлэлтүүд болох химийн найрлага болон хүнд металл, микробиологи, нефтийн бүтээгдэхүүн, хими, физик (агрохими) зэрэг үзүүлэлтүүдийг итгэмжлэгдсэн Инженер Геодези ХХК-ийн хөрсний

лаборатори, ХанЛаб, Байгаль орчин, хэмжил зүйн төв лабораториудад тодорхойлуулсан болно.

Хүснэгт 6. 2024 оны хөрсний дээжлэлт гүйцэтгэсэн тэмдэглэл

№	Цэгийн/Дээжийн дугаар, код/ Sample Point name ID	Цэгийн/Дээжийн нэр/ Sample Point name	Дээжлэлт хийгдсэн эсэх	Шинжилгээний төрөл
1	ХХЦ-01	Бутлуур, Баяжуулах үйлдвэр	Тийм	Хүнд металл, Микро үзүүлэлт, CN _{total}
2	ХХЦ-02	Химийн бодисын агуулах	Тийм	Хүнд металл, Микро үзүүлэлт, CN _{total}
3	ХХЦ-03	Баян, ядуу уусмалын сан	Тийм	Хүнд металл, Микро үзүүлэлт, CN _{total}
4	ХХЦ-04	Нуруулдан уусгах далан	Тийм	Хүнд металл, Микро үзүүлэлт, CN _{total}
5	ХХЦ-05	Хүдрийн овоолго	Тийм	Хүнд металл, Микро үзүүлэлт
6	ХХЦ-06	Засварын газар, ШТС	Тийм	Нефтийн бүтээгдэхүүн, Хүнд металл, Микро үзүүлэлт, CN _{total}
7	ХХЦ-07	Уурхайн ам (карьер)	Тийм	Хүнд металл, Микро үзүүлэлт
8	ХХЦ-08	Кемп-Уурхай хоорондын зам	Тийм	Хүнд металл, Микро үзүүлэлт
9	ХХЦ-09	Ажиллагсадын хотхон (Кемп)	Тийм	Хүнд металл, Микро үзүүлэлт
10	ХХЦ-10	Тэсрэх материалын агуулах	Тийм	Хүнд металл, Микро үзүүлэлт
11	ХХЦ-11	Харьцуулах хяналтын цэг	Тийм	Хүнд металл, Микро үзүүлэлт, CN _{total}
12	ХХЦ-12	Шимт хөрсний овоолго-1	Тийм	Хими, Физик (Агрохими)
13	ХХЦ-13	Шимт хөрсний овоолго-2	Тийм	Хими, Физик (Агрохими)
14	ХХЦ-14	Кемп-ахуйн бохирын цэг	Тийм	Эрүүл ахуй (Микробиологи)



Зураг 10. Хөрсний дээжлэлт /3 дугаар улирал/

3.3. Хөрсний дээжүүдийн лабораторийн шинжилгээний үр дүн

“Бурхан Дэл”-ийн уурхайн 2024 оны хөрсний хяналт шинжилгээний хүрээнд батлагдсан байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 3 дугаар улирлын байдлаар 14 ширхэг дээж авч хөрсний химийн шинж чанар болон хүнд металл, микробиологийн үзүүлэлтүүдийг “ХанЛаб” лаборатори, нефтийн бүтээгдэхүүний үзүүлэлтийг Байгаль Орчин, Хэмжил зүйн Төв лабораторид, шимт хөрсний овоолгоос авсан хөрсний дээжийн агрохимийн үзүүлэлтийг “Инженер Геодези” хөрсний итгэмжлэгдсэн лабораторид тус тус тодорхойлуулж хөрсний шинжилгээний үр дүнгүүдийг Хөрс. Хот суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм MNS 3297-91, Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ. MNS 5850:2019 стандартуудтай харьцуулсан.

Хөрсний лабораторийн шинжилгээний 3-р улирлын үр дүнд MNS 5850:2019 стандартад заасан зөвшөөрөгдөх агууламжаас хэтэрсэн үзүүлэлт байхгүй байна. Мөн хөрсний дээжид цианид илрээгүй болно.

Хүснэгт 7. Хөрсний шинжилгээний үзүүлэлтийн үр дүн

№	Дээж дугаар	Үзүүлэлт, %					Үзүүлэлт, мг/кг							
		Ca	Mg	Na	K	Fe _{нийт}	As	Ba*	Be	Bi	Cd	Co	Cr	Cu
1	XXЦ-01	3.39	1.30	1.52	2.28	3.07	18.21	573.6	1.11	<10.0	<1.0	16.90	60.30	21.75
2	XXЦ-02	2.58	0.90	1.82	2.56	2.36	18.54	666.1	<1.0	<10.0	<1.0	14.01	43.32	15.56
3	XXЦ-03	2.08	0.82	1.41	1.91	2.49	15.15	573.0	<1.0	<10.0	<1.0	13.55	31.96	16.84
4	XXЦ-04	1.30	0.63	1.53	1.94	2.06	8.73	538.9	<1.0	<10.0	<1.0	10.85	24.61	9.71
5	XXЦ-06	2.54	1.03	1.84	2.13	2.82	8.50	581.4	<1.0	<10.0	<1.0	15.99	45.20	16.13
6	XXЦ-11	4.67	1.51	1.86	2.85	3.65	14.67	736.3	1.05	<10.0	<1.0	20.36	64.53	29.82
7	XXЦ-05	2.59	0.94	1.71	2.17	2.65	16.29	576.3	<1.0	<10.0	<1.0	15.09	38.61	16.02
8	XXЦ-07	1.51	0.61	1.54	1.91	1.85	16.52	519.3	<1.0	<10.0	<1.0	10.84	31.79	10.23
9	XXЦ-08	3.51	1.02	1.68	2.32	2.59	16.28	618.9	<1.0	<10.0	<1.0	14.68	40.34	17.53
10	XXЦ-09	3.66	0.99	1.60	2.35	2.71	13.88	622.8	<1.0	<10.0	<1.0	14.79	42.72	17.46
11	XXЦ-10	1.75	0.76	1.73	2.34	2.09	9.45	631.6	<1.0	<10.0	<1.0	10.89	33.69	12.84
MNS5850:2019		-	-	-	-	-	20.00	-	-	-	3.00	50.00	150.0	100.0

Хүснэгт 8. Хөрсний шинжилгээний үзүүлэлтийн үр дүн

№	Дээж дугаар	Үзүүлэлт, мг/кг															
		La	Li	Mn	Mo	Ni	P	Pb	Sb	Se	Sr*	Ti	V	Y	Zn	Zr*	CN _{tot}
1	XXЦ-01	35.2	35.5	674.1	<5.0	38.83	324.4	14.47	<10.0	<5.0	380.8	2709	76.54	27.6	66.27	89.77	<0.50
2	XXЦ-02	24.2	23.2	527.1	<5.0	31.86	256.1	18.09	<10.0	<5.0	292.5	3180	59.96	20.1	49.85	75.89	<0.50
3	XXЦ-03	17.7	23.4	539.4	<5.0	31.25	233.2	13.85	<10.0	<5.0	237.8	2693	84.91	5.1	50.29	54.52	<0.50
4	XXЦ-04	17.1	15.4	459.7	<5.0	18.81	233.6	13.55	<10.0	<5.0	220.2	2330	52.54	13.1	37.13	47.31	<0.50
5	XXЦ-06	24.1	21.7	643.0	<5.0	22.59	316.5	10.11	<10.0	<5.0	289.1	3363	83.11	21.0	49.59	59.02	<0.50
6	XXЦ-11	36.6	35.1	786.7	<5.0	42.94	560.1	16.67	<10.0	<5.0	369.0	3788	91.41	31.1	77.05	82.18	<0.50
7	XXЦ-05	23.6	21.0	586.9	<5.0	22.85	397.3	18.90	<10.0	<5.0	267.9	3374	76.48	20.4	50.58	66.99	-
8	XXЦ-07	17.4	15.1	448.2	<5.0	16.73	307.6	13.22	<10.0	<5.0	225.9	2482	49.08	15.1	35.85	52.56	-
9	XXЦ-08	26.4	24.3	600.4	<5.0	24.53	558.4	14.14	<10.0	<5.0	304.7	3218	68.63	23.5	55.37	75.52	-
10	XXЦ-09	23.5	24.0	579.3	<5.0	21.64	439.0	14.95	<10.0	<5.0	305.4	3327	74.51	22.7	53.10	73.66	-
11	XXЦ-10	24.0	18.6	492.1	<5.0	20.63	510.6	18.87	<10.0	<5.0	258.8	1946	50.45	16.8	44.09	53.64	-
MNS5850:2019		-	-	-	5.0	150.0	-	100.0	-	10.00	800.0	-	150.0	-	300.0	-	25.0

3.3.1. Хөрсний микробиологийн шинжилгээний үр дүн

Тус дээжийн бактерлогийн шинжилгээний дүнгээс харахад нийт 4 үзүүлэлтээс Колиформ гэдэсний бүлгийн нян, кластридиум перфрингс болон гэдэсний бүлгийн эмгэг төрөгч илрээгүй. Харин бактерийн ерөнхий тоо илэрсэн байна. Дээрх үзүүлэлт нь тухайн ахуйн бохир ус хадгалах цэгийн хөрс бохирдолтой байгааг илэрхийлэх бөгөөд энэ нь дараах шалтгаантай байж болно.

- ❖ Ахуйн бохирыг соруулах үед хөрс дээр асгарсан.
- ❖ Тухайн орчинд бохирдол тархсан.
- ❖ Тухайн дээж авсан цэг гаднын бохирдолд өртсөн.

Иймд төсөл хэрэгжүүлэгч нь ажилчдын хотхоны бохир ус хадгалах цэг орчмын хөрсийг цэвэрлэн ариутгах ажлыг гүйцэтгэх шаардлагатай.

Хүснэгт 9. Стандартаас хэтэрсэн бактерлогийн үзүүлэлтийн хэмжээ

Дээжлэлтийн цэгийн нэр	Үзүүлэлт	Тэмдэглэгээ	Нэгж	Стандарт MNS 5850:2019	Үр дүн
3-р улирал					
ХХЦ-14	Бактерийн ерөнхий тоо	1.8*10 ⁵	-	Илрэхгүй	илрэв

3.3.2. Үржил шимт хөрсний хими, физикийн (Агрохими) шинжилгээний үр дүн

Үржил шимт өнгөн хөрсний овоолгоос дээжлэлт хийж “Инженер Геодези” хөрсний итгэмжлэгдсэн лабораторид хөрсний хими, физик үзүүлэлтийг тодорхойлуулсан юм.

Хүснэгт 10. Шимт хөрсний овоолгуудын үржил шимийн үзүүлэлт

Дээжний дугаар	Гүн, см	Хээрийн чийг, %	pH	Давс, %	ЦДЧ, dsm	Ялзмаг, %	Нийт азот, %	NO ₃ , мг/100гр	CaCO ₃ , %	Шингээгдсэн сууриуд мг-экв/100гр		Шим тэжээлийн элементүүд мг/100гр	
										Ca	Mg	P ₂ O ₅	K ₂ O
ХХЦ-12	0-15	4.30	8.8	0.31	0.628	0.13	0.01	0.37	1.15	7.6	5.0	1.4	12
ХХЦ-13	0-15	3.84	8.7	0.07	0.148	0.20	0.01	0.62	0.16	5.7	2.9	1.2	12

Хөрсний шинж чанарын үзүүлэлтийг товч дүгнэвэл:

Хөрсний урвалын орчин нь сул шүлтлэг, сул давсархаг, ялмагийн агууламж ялмаг, үржил шимийн үзүүлэлт болох азот, фосфор дутагдалтай, сул карбонатлаг шингээгдсэн сууриуд болох кальци, магни болон хөдөлгөөнт кали дундаж агууламжтай байна.

Хүснэгт 11. Шимт хөрсний овоолгуудын ширхэгийн бүрэлдэхүүн

Дээжний дугаар	Гүн, см	Хувийн жин, гр/см ³	Механик ширхэгүүд %, ширхэгийн хэмжээ, мм						
			1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	<0.01
ХХЦ-12	0-15	2.70	25.5	52.0	2.2	4.5	9.4	6.5	20.4
ХХЦ-13	0-15	2.71	35.1	48.6	2.1	0.8	12.9	0.5	14.3

Хөрсний ширхгийн бүрэлдэхүүн нь ХХЦ-12 цэгт хөнгөн шавранцар, ХХЦ-13 цэг нь элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй, эрдэс хэсгийн нягт буюу хувийн жин нь нягтавтарт байна.

3.3.3. Хөрсөн дэх нефт бүтээгдэхүүний шинжилгээний үр дүн

Уурхайн шатахуун түгээх станц, засварын газар орчмоос авсан дээжийн шинжилгээний үр дүн нь хөрсний чанарын стандарт MNS 5850:2019 стандартад заасан утгаас хэтрээгүй байна. Уурхайн засварын газар болон шатахуун түгээх станц орчмын газрын гадарга дээр материал дэвссэн байгаа тул хөрс бохирдох эрсдэлээс бүрэн хамгаалсан байна.

Хүснэгт 12. Хөрсөн дэх нефть бүтээгдэхүүний агууламж

Дээжлэлтийн цэгийн нэр	Үзүүлэлт	Тэмдэглэгээ	Нэгж	MNS 5850:2019		Үр дүн
				Хүлцэх дээд агууламж	Хортой дээд агууламж	
3-р улирал						
ХХЦ-06	Нефть бүтээгдэхүүн	ТРН	г/кг	2	8	0.3

4. АГААРЫН ЧАНАРЫН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ


“Бурхан Дэл” алтны үндсэн орд ашиглах төслийн талбайд 2024 оны батлагдсан БОМТ-д тусгагдсаны дагуу нийт 11 цэгт (ил уурхайн ам, баяжуулах үйлдвэр, ажилчдын хотхон, засварын газар, шатахуун түгээх станц, уурын зуух гэх мэт) орчны агаарын чанарын хяналт хэмжилт, дээжлэлтийн ажлыг 2024 оны 7-р сарын 19-20 өдрүүдэд нэг удаа гүйцэтгэлээ.

4.1. Агаарын чанарын хяналт шинжилгээний хэмжилт, үр дүн

“Бурхан Дэл” алтны үндсэн орд ашиглах төслийн талбайд агаарын чанарын хэмжилтийг AEROQUAL RANGER маркийн орчны тоосжилт болон агаар дах зарим хорт хийг хэмжигч багаж ашиглан гүйцэтгэсэн. Тоосны хэмжилт хийхдээ хэмжилтийн цэг бүр дээр тухайн үеийн салхины хурд, салхины чиглэл, агаарын хэм, агаарын харьцангуй чийгшил, орчны дуу чимээ зэрэг үзүүлэлтүүдийг хэмжиж тэмдэглэл хийлээ.



Зураг 11. Агаарын чанарын хэмжилт /3 дугаар улирал/



Зураг 12. Агаарын хяналт шинжилгээний цэгүүдийн байршил

Хүснэгт 13. агаарын чанарын хэмжилтийн хуудас

	Цэгийн дугаар, код/ Point name ID	Цэгийн нэр/ Point name	Цэгийн координат/ Coordinate		Агаарын чанар-гоосонцор/ Air quality- particulate matter dust				Цаг агаарын нөхцөл/ Weather condition				
					PM1.0	PM2.5	PM10.0	TSP	Temperature	RH	WS	Wind direction	Sound level
					50	50	100	500	-	-	-	-	60
N	E	мкг/м ³ (ppm)	мкг/м ³ (ppm)	мкг/м ³ (ppm)	мкг/м ³ (ppm)	°C	%	m/s	-	db/дБА			
1	АХЦ-01	Баяжуулах үйлдвэр	44°22'42.8"	104°05'07.6"	0.9	22	11.5	15.6	40.6	17.7	3	NW	25.6
2	АХЦ-02	Химийн бодисын агуулах	44°22'43.8"	104°04'50.3"	1.1	4.1	16.4	22.1	32.4	28.5	2	NW	26.1
3	АХЦ-03	Баян, ядуу уусмалын сан	44°22'51.8"	104°04'56.3"	1.3	4.4	23.6	30.3	38.3	22.7	2.1	NW	26.6
4	АХЦ-04	Нуруулдан уусгах далан	44°22'44.4"	104°05'28.8"	1	3.2	12.4	19.1	37.4	21.4	2.2	NW	35.2
5	АХЦ-05	Үйлдвэрийн халаатын зуух	44°22'33.9"	104°05'25.7"	1	3.2	11.7	15.8	38.3	21.5	1.9	NW	26.1
6	АХЦ-06	Засварын газар, ШТС	44°22'34.9"	104°05'03.3"	0.8	2.7	9.3	12.8	38.4	20.3	2.1	NW	42
7	АХЦ-07	Уурхайн ам (карьер)	44°22'14.0"	104°04'45.5"	1.1	4.4	18.7	23.9	32.1	30.4	1.8	NW	22.4
8	АХЦ-08	Тэсрэх материалын агуулах	44°21'52.0"	104°03'34.9"	1.2	5.5	22.5	30.8	29.1	35.8	2.1	NW	35.7
9	АХЦ-09	Кэмп-Уурхай хоорондын зам	44°22'34.8"	104°03'51.0"	1.4	6.6	32.2	40.7	30.8	34.9	1.9	NW	39.4
10	АХЦ-10	Ажиллагсадын хотхон (кэмп)	44°22'25.1"	104°03'16.6"	1.4	6.7	39.4	44.7	29.2	42	2.3	NW	42.4
11	АХЦ-11	Харьцуулах хяналтын цэг	44°23'13.2"	104°04'57.0"	1.2	4	17.5	21.4	37.5	24.1	2.1	NW	26.4

Хүснэгт 14. агаарын чанарын хэмжилтийн хуудас

	Цэгийн дугаар, код/ Point name ID	Цэгийн нэр/ Point name	Цэгийн координат/ Coordinate		Цаг агаарын нөхцөл/ Weather condition									
					O3	H2S	NO ₂	SO ₂	CO	Temperature	RH	WS	Wind direction	Sound level
					100		200	450	60000	-	-	-	-	60
N	E	мкг/м ³	мкг/м ³	мкг/м ³	мкг/м ³	мкг/м ³	°C	%	m/s	-	db/дБА			
1	АХЦ-01	Баяжуулах үйлдвэр	44°22'42.8"	104°05'07.6"	999600	179000	22560	4936080	36969100	40.6	17.7	3	NW	25.6
2	АХЦ-02	Химийн бодисын агуулах	44°22'43.8"	104°04'50.3"	258720	716000	7520	1438380	12215000	32.4	28.5	2	NW	26.1
3	АХЦ-03	Баян, ядуу уусмалын сан	44°22'51.8"	104°04'56.3"	533120	633660	5640	1467200	14882000	38.3	22.7	2.1	NW	26.6
4	АХЦ-04	Нуруулдан уусгах далан	44°22'44.4"	104°05'28.8"	556640	195110	31960	2103860	27766900	37.4	21.4	2.2	NW	35.2
5	АХЦ-05	Үйлдвэрийн халаатын зуух	44°22'33.9"	104°05'25.7"	523320	562060	45120	269860	34073200	38.3	21.5	1.9	NW	26.1
6	АХЦ-06	Засварын газар, ШТС	44°22'34.9"	104°05'03.3"	491960	594280	43240	2300360	40411700	38.4	20.3	2.1	NW	42
7	АХЦ-07	Уурхайн ам (карьер)	44°22'14.0"	104°04'45.5"	276360	361580	1880	374660	13494600	32.1	30.4	1.8	NW	22.4
8	АХЦ-08	Тэсрэх материалын агуулах	44°21'52.0"	104°03'34.9"	23520	443920	20680	387760	6449100	29.1	35.8	2.1	NW	35.7
9	АХЦ-09	Кэмп-Уурхай хоорондын зам	44°22'34.8"	104°03'51.0"	137200	343680	5640	919620	7807100	30.8	34.9	1.9	NW	39.4
10	АХЦ-10	Ажиллагсадын хотхон (кэмп)	44°22'25.1"	104°03'16.6"	0	488670	69560	683820	7557900	29.2	42	2.3	NW	42.4
11	АХЦ-11	Харьцуулах хяналтын цэг	44°23'13.2"	104°04'57.0"	415520	479720	60160	2855800	25484900	37.5	24.1	2.1	NW	26.4

ХАВСРАЛТ

1. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ЦЭГИЙН ЗУРАГ
2. ХЭЭРИЙН ХЭМЖИЛТИЙН ТЭМДЭГЛЭЛ ФОРМ
3. ЛАБОРАТОРЫН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮНГҮҮД ЭХ ХУВЬ



ӨМНӨГОВЬ АЙМАГ МАНДАЛ-ОВОО СУМ “БУРХАН ДЭЛ” АЛТНЫ ҮНДСЭН ОРД (MV-016759) АШИГЛАХ ТӨСӨЛ



2024 ОНЫ 8 ДУГААР САРЫН УРГАМАЛ, АМЬТНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖЛЫН ТАЙЛАН

Хүлээн авсан:

.....

“Мандал Ресурс” ХХК
Байгаль орчны мэргэжилтэн Г.Нарангоо



Тайлан боловсруулсан:

.....

“Өлзий Энвйронментал” ХХК
Байгаль орчны ахлах мэргэжилтэн Ш.Дэлгэрсайхан

Агуулга

Агуулга.....	2
Хүснэгтийн жагсаалт	3
Зургийн жагсаалт	5
Хавсралтын жагсаалт.....	5
1. УРГАМАЛ, АМЬТНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ГЭРЭЭТ АЖЛЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	6
1.1. Байгаль орчны хяналт шинжилгээний ажлын зорилго, хамрах хүрээ.....	7
1.2. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт холбогдох Монгол улсын хууль тогтоомж, (MNS) стандартууд	7
2. УРГАМЛЫН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ.....	8
2.1. Ургамлын хяналт шинжилгээний арга зүй.....	8
2.1.1. Хээрийн судалгааны материал.....	8
2.1.2. Ургамлын судалгааны арга зүй.....	8
2.2. Ургамалжлын мониторинг судалгааны үр дүн	11
2.2.1. Ургамлан нөмрөгийн өнөөгийн төлөв байдал.....	11
2.2.2. Ургамлын мониторинг бичиглэл.....	14
2.3. Ургамлын аймаг ба ургамлын зүйлийн жагсаалт	30
2.3.1. Зүйлийн бүрэлдэхүүн.	30
2.3.2. Ургамлын ангиллын үндсэн бүлгийн бүтэц.....	37
2.3.3. Ургамлын амьдралын хэлбэр.....	38
2.3.4. Ургамлын ашиглалтад өртөмтгий байдал	38
2.3.5. Ургамлын зүйл хамгаалал	39
2.4. Ургамлын хяналт шинжилгээний дүгнэлт	41
2.5. Ашигласан материал.....	42
3. АМЬТНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ	43
3.1. Амьтны хяналт шинжилгээний арга зүй.....	43
3.2. Амьтны хяналт шинжилгээний үр дүн	44
3.2.1. BD01 (Burkhan Del 01) талбай	44
3.2.2. BD02 талбай.....	44
3.2.3. BD03 талбай.....	44
3.2.4. BD04 талбай.....	44
3.2.5. BD05 талбай.....	45
3.3. Санал, зөвлөмж.....	60
3.4. Иш татсан бүтээлийн жагсаалт	60

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Друдегийн үнэлгээ	8
Хүснэгт 2. Ургамлан нөмрөгийн төлөв байдал.....	10
Хүснэгт 3. Ургамлан нөмрөгийн бичиглэл.....	12
Хүснэгт 4. Мандал Ресурс ХХК-ын уурхайн тусгай зөвшөөрлийн талбайн ургамалжлын судалгааны талбайн хэмжээ, га.....	13
Хүснэгт 5. Монгол өвс –боролзой-тостот, Монгол-харгана-тэсэгт, Боролзой-шивэлзэт ургамлан нөмрөгийн төлөв байдлын бичиглэл.....	15
Хүснэгт 6. Монгол өвс –боролзой-тостот, Монгол-харгана-тэсэгт, Боролзой-шивэлзэт бүлгэмдлийн ургацын бичиглэл	16
Хүснэгт 7. Холимог сөөгт ургамлан нөмрөгийн төлөв байдлын бичиглэл.....	17
Хүснэгт 8. Холимог сөөгт бүлгэмдлийн ургацын бичиглэл.....	17
Хүснэгт 9. Монгол өвс-боролзой-шавагт, Монгол өвс-бударганат хотирт ургамлан нөмрөгийн төлөв байдлын бичиглэл	18
Хүснэгт 10. Монгол өвс-боролзой-шавагт, Монгол өвс-бударганат хотирт бүлгэмдлийн ургацын бичиглэл.....	19
Хүснэгт 11. Монгол өвс-баглуурт, Монгол өвс-боролзойт, Монгол өвс-тэсэг-хотирт уулын ургамлан нөмрөгийн төлөв байдлын бичиглэл.....	19
Хүснэгт 12. Монгол өвс-баглуурт, Монгол өвс-боролзойт, Монгол өвс-тэсэг-хотирт уулын бүлгэмдлийн ургацын бичиглэл	20
Хүснэгт 13. Холимог сөөгт нам хотосын ургамлан нөмрөгийн төлөв байдлын бичиглэл.....	21
Хүснэгт 14. Холимог сөөгт бүлгэмдлийн ургацын бичиглэл.....	21
Хүснэгт 15. Монгол баглуур, Монгол боролз ургамлан нөмрөгийн төлөв байдлын бичиглэл.....	22
Хүснэгт 16. Монгол баглуур, Монгол боролз бүлгэмдлийн ургацын бичиглэл.....	22
Хүснэгт 17. Монгол -тэсэг, Монгол-баглуурт ургамлан нөмрөгийн төлөв байдлын бичиглэл	23
Хүснэгт 18. Монгол -тэсэг, Монгол-баглуурт бүлгэмдлийн ургацын бичиглэл	24
Хүснэгт 19. Хармагт ургамлан нөмрөгийн төлөв байдлын бичиглэл.....	24
Хүснэгт 20. Хармагт бүлгэмдлийн ургацын бичиглэл.....	25
Хүснэгт 21. Монгол өвс-шавагт, Монгол өвс-баглуур-тост-хотирт ургамлан нөмрөгийн мониторинг бичиглэл	25
Хүснэгт 22. Монгол өвс-шавагт, Монгол өвс-баглуур-тост-хотирт бүлгэмдлийн хашааны доторх ургацын бичиглэл.....	26
Хүснэгт 23. Монгол -шаваг-сэдэргэнэ-холимог сөөгт ургамлан нөмрөгийн төлөв байдлын бичиглэл.....	26
Хүснэгт 24. Монгол -шаваг-сэдэргэнэ-холимог сөөгт бүлгэмдлийн ургацын бичиглэл.....	27
Хүснэгт 25. Таана-бударгана, Монгол-баглуурт ургамлан нөмрөгийн төлөв байдлын бичиглэл	28
Хүснэгт 26. Таана-бударгана, Монгол-баглуурт бүлгэмдлийн ургацын бичиглэл.....	28
Хүснэгт 27. Монгол-шаваг-сэдэргэнэт, холимог сөөгт ургамлан нөмрөгийн төлөв байдлын бичиглэл.....	29
Хүснэгт 28. Монгол-шаваг-сэдэргэнэт, холимог сөөгт бүлгэмдлийн ургацын бичиглэл	29
Хүснэгт 29. Мандал Ресурс ХХК-ны уурхайн тусгай зөвшөөрлийн талбайн ургамлын бүтэц бүрэлдэхүүний баялаг.....	30
Хүснэгт 30. Мандал Ресурс ХХК-ны уурхайн тусгай зөвшөөрлийн талбайд бүртгэсэн ургамлуудын ангиллын үндсэн бүлгийн бүтэц.....	37
Хүснэгт 31. Мандал Ресурс ХХК-ны “Бурхан дэл” уурхайн орчмын талбайд бүртгэсэн ургамлын ангиллын бүтэц.....	38
Хүснэгт 32. “Бурхан Дэл” уурхайн тусгай зөвшөөрөлтэй талбай дахь зүйлийн бүрдлийн онцлог.....	38

Хүснэгт 33. Мандал Ресурс ХХК-ны “Бурхан Дэл” уурхайн тусгай зөвшөөрлийн талбай дахь зүйл хамгаалал.....	40
Хүснэгт 34. Амьтны мониторингийн сонгосон талбайн мэдээлэл	45
Хүснэгт 35. Тусгай зөвшөөрлийн талбай болон түүний нөлөөллийн бүс дэхь мөлхөгчдийн зүйлийн жагсаалт.	45
Хүснэгт 36. Судалгааны талбайн мөлхөгчийн нягтшил	45
Хүснэгт 37. Шувуудын зүйлийн жагсаалт.	46
Хүснэгт 38. Жижиг хөхтөн амьтдын зүйлийн жагсаалт.	46
Хүснэгт 39.....	46
Хүснэгт 40. Ангууч болон туруутан амьтдын зүйлийн жагсаалт.	47
Хүснэгт 41. Тусгай зөвшөөрлийн талбай болон түүний нөлөөллийн бүсийн гуурст ургамлын зүйлийн жагсаалт	47

Зургийн жагсаалт

Зураг 1. Өмнөговь аймгийн Мандал-Овоо сум “Бурхан Дэл”-ийн уурхайн байршил.....	6
Зураг 2. Хээрийн хэмжилт, дээжлэлт гүйцэтгэсэн цэгүүдийн байршил	8
Зураг 3. Хээрийн хэмжилт, фотомониторинг дата цуглуулсан мэдээ	9
Зураг 4. Ургамлан нөмрөгийн нийт бүрхэц.....	10
Зураг 5. Samplepoint программын үр дүн excel программ дээр гарсан.....	10
Зураг 6. Мандал Ресурс ХХК-ны уурхайн тусгай зөвшөөрлийн талбайн ургамалжлын зураг	13
Зураг 7. Ургамалжлын мониторинг бичиглэл 1. Монгол өвс –боролзойт бүлгэмдэл.....	15
Зураг 8. Ургамлын бичиглэл 2. Холимог сөөгт бүлгэмдэл.....	17
Зураг 9. Ургамлын бичиглэл 3. Монгол өвс-боролзой-шавагт, Монгол өвс-бударганат хотирт бүлгэмдэл.....	18
Зураг 10. Ургамлын бичиглэл 4. Монгол өвс-баглуурт, Монгол өвс-боролзойт, Монгол өвс- тэсэг-хотирт уулын бүлгэмдэл.....	20
Зураг 11. Ургамлын бичиглэл 5. Холимог сөөгт нам хотосын бүлгэмдэл.....	21
Зураг 12. Ургамлын бичиглэл 6. Монгол баглуур, Монгол боролз бүлгэмдэл.....	22
Зураг 13. Ургамлын бичиглэл 7. Монгол -тэсэг, Монгол-баглуурт бүлгэмдэл	23
Зураг 14. Ургамлын бичиглэл 8. Хармагт бүлгэмдэл.....	24
Зураг 15. Ургамлын бичиглэл 9. Монгол өвс-шавагт, Монгол өвс-баглуур-гост-хотирт бүлгэмдэл.....	25
Зураг 16. Ургамлын бичиглэл 10. Монгол -шаваг-сэдэргэнэ-холимог сөөгт бүлгэмдэл.....	27
Зураг 17. Ургамлын бичиглэл 11. Таана-бударгана, Монгол-баглуурт бүлгэмдэл.....	27
Зураг 18. Ургамлын бичиглэл 12. Монгол-шаваг-сэдэргэнэт, холимог сөөгт бүлгэмдэл	29
Зураг 19. Ургамлын амьдралын хэлбэр.	38
Зураг 20. Гүрвэл популяцийн нягтшилийг үнэлэх хээрийн дата цуглуулах загвар	51
Зураг 21. Шерман амьд баригч байршуулсан байдал.....	51
Зураг 22. BD01 талбайн загтай хотгорын өвөрмөц экосистем.	52
Зураг 23. BD02 талбайн Баянхошууны задгай устай газрын хайлааст сайр.	52
Зураг 24. BD03 талбайн шувуу, том хөхтний ажиглалтын цэгийн орчны харагдах байдал ...	53
Зураг 25. BD04 талбайн цөлжүү хээрийн хэв шинж бүхий экосистем.....	53
Зураг 26. BD05 талбайн шувуу, том хөхтний ажиглалтын цэгийн орчны харагдах байдал ...	54
Зураг 27. Бамбай хоншоорт могой (<i>Gloydus halys</i>).....	54
Зураг 28. Нарийн могой (<i>Coluber spinalis</i>)	55
Зураг 29. Хонин гүрвэл (<i>Phrynocephalus versicolor</i>)	55
Зураг 30. Говийн гүрвэл (<i>Eremias przewalskii</i>)	56
Зураг 31. Шөнийн идэвхитэй төмөр гүрвэл чулуу сөхөж илрүүлж буй байдал	56
Зураг 32. Төмөр гүрвэл (<i>Alsophylax pipiens</i>)	57
Зураг 33. Элсч савагдаахай (<i>Dipus sagitta</i>).....	57
Зураг 34. Өөхөн сүүлт атигдаахай (<i>Salpingotus crassicauda</i>).....	58
Зураг 35. BD02 талбайн сайрын элсэнд үлдсэн саарал чонын мөр.....	58
Зураг 36. BD02 талбайд ажиглагдсан янгирын ихэр ишиг	59


Хавсралтын жагсаалт

Хавсралт 1. “Бурхан Дэл” уурхайн 2024 оны 8 дугаар сарын ургамлын хяналт шинжилгээний фотомониторингийн дата	62
Хавсралт 2. Мандал Ресурс ХХК-ны уурхайн тусгай зөвшөөрлийн талбайд бүртгэсэн ховор, реликт, эндемик, субэндемик зүйл ургамал, 2024	65
Хавсралт 3. Мандал Ресурс ХХК-ын талбайд бүртгэсэн элбэг зүйл ургамал, 2024	79

1. УРГАМАЛ, АМЬТНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ГЭРЭЭТ АЖЛЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

“Мандал Ресурс” ХХК нь Өмнөговь аймгийн Мандал-Овоо сумын нутаг дэвсгэрт “Бурхан дэл” алтны үндсэн ордыг ашиглах төслийг хэрэгжүүлэн ажиллаж эхэлж байгаа бөгөөд батлагдсан Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан (БОННУ), 2024 онд батлагдсан тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-г тус тус үндэслэн байгаль орчны мэргэжлийн эрх бүхий байгууллага “Өлзий Энвайронментал” ХХК тус төслийн байгаль орчны хяналт шинжилгээний ажлыг гүйцэтгэх гэрээ байгуулан ажиллаж байна.

Энэхүү гэрээт ажлын хүрээнд “Бурхан Дэл” уурхайн 2024 оны батлагдсан байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу “Өлзий Энвайронментал” ХХК-ийн мэргэжилтнүүд уурхайн талбайд 2024 оны 8 дугаар сард төслийн талбай орчимд тогтоосон цэгүүдэд ургамал, амьтны хяналт шинжилгээний ажлыг гүйцэтгэн үр дүнгүүдийг нэгтгэн боловсрууллаа.



Зураг 1. Өмнөговь аймгийн Мандал-Овоо сум “Бурхан Дэл”-ийн уурхайн байршил

1.1. Байгаль орчны хяналт шинжилгээний ажлын зорилго, хамрах хүрээ

Төлөвлөгөөт байгаль орчны хяналт шинжилгээний ажлын үндсэн зорилго нь “Бурхан Дэл” уурхайн үйл ажиллагааны явцад байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг илрүүлж тухайн сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд оршино. ОХШХ-ийг хэрэгжүүлснээр төсөл хэрэгжүүлэгчийн үйл ажиллагаа нь Монгол улсын Усны тухай, Газрын хэвлийн тухай, Агаарын тухай, Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, Ашигт малтмалын тухай хуулиуд болон бусад холбогдох хууль, журам, стандартуудад нийцэж байгаа эсэхийг баталгаажуулах юм.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд “Бурхан Дэл” төслийн талбайд болон талбайн орчимд хийгдсэн агаар, ус, хөрсний чанарын хэмжилт дээжлэлтийн үр дүнг дараах асуудлуудыг тодорхойлох, үнэлэхэд ашигласан. Үүнд:

- a) Уурхайн бүх үе шатуудын явцад агаарын, хөрсний, усны шинж чанарт өөрчлөлт орж байгаа эсэхийг тогтмол хянах;
- b) Орон нутгийн иргэдийн санал, гомдолтой холбогдуулан бохирдол, хомсдолын талаар баталгаат мэдээллээр хангах;
- c) Хэмжилт, дээжлэлт, шинжилгээний үр дүнгүүд Монгол улсын холбогдох стандартуудын шаардлагыг хангахгүй буюу стандартад заасан хүлцэх хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд бохирдлыг арилгах, нөлөөллийг багасгах залруулах болон орчны бохирдлоос сэргийлэх үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх;
- d) Байгаль орчны хяналт шинжилгээний сар тутмын, улирал тутмын, жил тутмын мэдээллийн санг бий болгож урт хугацаанд тодорхой давтамжит хэмжилт, шинжилгээний дүнгүүдийг харьцуулан өөрчлөлтийг тасралтгүй хянах.

1.2. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт холбогдох Монгол улсын хууль тогтоомж, (MNS) стандартууд

- a) Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10.3 дахь заалт
- b) Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9.7 дахь заалт
- c) Ашигт малтмалын тухай хуулийн 38.1.2 дахь заалт, 39.1.3 даахь заалт
- d) Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29 –ний өдрийн А/618 тоот тушаалын хавсралт “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”
- e) Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн А/20 дугаар тушаалын хавсралт “Ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагааны журам”

“Бурхан Дэл” уурхайн төслийн талбайн байгаль орчны хяналт шинжилгээний ажлын үр дүнгүүдийг Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа дараах стандартуудтай харьцуулан өөрчлөлтүүдийг хянаж байна.

2. УРГАМЛЫН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ

2.1. Ургамлын хяналт шинжилгээний арга зүй

2.1.1. Хээрийн судалгааны материал

Өмнөговь аймгийн Мандал-Овоо сумын нутагт орших “БУРХАН ДЭЛ”-ийн алтны үндсэн ордыг ашиглах төслийн 2024 оны батлагдсан байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу “Өлзий Энвайронментал” ХХК-ийн ургамал судлаач мэргэжилтнүүд төслийн талбайд 2024 оны 8-р сарын 24-26-ны өдрүүдэд хээрийн хэмжилт, дээжлэлтийн ажлыг гүйцэтгэлээ.

ОХШХ-ийг хэрэгжүүлэг нэг удаагийн хээрийн ажлаар төслийн талбай орчимд тогтоосон цэгүүдэд ургамлын хэмжилт нийт 14 цэгт (Х-1), фотомониторинг дата нийт 126 цэгт (Хавсралт 1) цуглуулж, 1080 sample, 240 ургацын тоон материал боловсруулав.



Зураг 2. Хээрийн хэмжилт, дээжлэлт гүйцэтгэсэн цэгүүдийн байршил

2.1.2. Ургамлын судалгааны арга зүй

Ургамлын зүйлийн бүрэлдэхүүн тогтоох: Ургамлын зүйлийн бүрэлдэхүүнийг тодорхойлохдоо 100 ам метр /10м x 10м/ газрын дөрвөн өнцөгт нь ялгах тэмдэг тавьж, нэг өнцгөөс нөгөө өнцгийг чиглэн диагналдан явж тохиолдох бүх ургамлыг флорын баялаг тодорхойлох аргаар бүртгэж, зүйлийн нэршлийг Монгол орны гуурст дээд ургамлын бүртгэл бичигт (Губанов И.А х210 , 1996) болон ургамал таних бичигт (Грубов В.И х.410, 2008) зааснаар нэрлэж, олон улсын СИ системийн нэршлээр филогенетик системийн дагуу жагсаан бичиж, арвийг Друде-ийн үнэлгээгээр гаргав.

Хүснэгт 1. Друдегийн үнэлгээ

Бүрхцийн хэмжээ		Зүйлийн баялгийн онцлог	Хоорондын зай, см
Кодоор	Хувь		
Cop ²⁻³	30 дээш	Нэн арвин	<20
Cop ¹	10-25	Арвин	20-40
Sp	5-10	Тармагдуу	40-100
Sol	1-5	Дунд зэрэг	100-150
R	1	Нэн ховор	>150











Ургамлан нөмрөгийн төлөв байдлыг Монгол орны ургамалжлын фитотопологи ангилааг баримтлан анги, дэд анги, бүлэг төрөл, төрлөөр ялган нийт 25 төрлийн бүлгэмдэлд ангилан зүйлийн бүрэлдэхүүний тоо, (10м² талбайд), 1 м² талбайд тохиолдох зүйлийн тоо, ургамлын бүрхэц, үүнээс олшрогч ургамлын бүрхэц, газрын гадаргын нийт бүрхцэд халцгай газар, хад, хайрга чулуу, хагдны эзлэх хувийг олон улсын фотомониторинг аргаар бичиглэл хийж (Швейцарын хөгжлийн агентлаг Бэлчээрийн ногоон алт хөтөлбөр х.22, 2014), бэлчээрийн зуны дээд ургац зэрэг 8-н үзүүлэлтээр гаргаж, ургамлын аймгийн зүйлийн бүрдэл, түүний онцлог, ургамлан нөмрөгийн төрх байдал, төлөв байдал, талхлагдлын өнөөгийн байдлыг гаргав [2].

Ургамлын тусгаг бүрхэц, халцгай газар, хагд, хад чулууны хэмжээг тодорхойлох: Газрын гадарга дээрх ургамлан нөмрөгийн бүрхэц, халцгай газар, хайрга чулуу, хагдны хэмжээг тодорхойлохдоо: олон улсын фотомониторингийн түргэвчилсэн аргыг хэрэглэсэн.

Фотомониторингийн ажлыг дараах дарааллын дагуу гүйцэтгэв. Үүнд:

1. Ажлын талбарыг бэлтгэх
2. Орчны ерөнхий зураг авах
3. Гадаргын бүрхцийн зураг авах
4. Ургамлан нөмрөгөөс авсан зургийг хадгалах
5. Мэдээлэл боловсруулалт

Фото-мониторингийн мэдээлэл боловсруулалт. Гадаргуугийн бүрхцийн зургийг мониторингийн цэг тус бүрээр нэгтгэж боловсруулалтын Sample point (Terry Booth and Sam Cox, 2009) программ ашиглан ургамлын бүрхцийн нийт хувь болон аж ахуйн бүлгээр ангилан тодорхойлдог. Уг программын анхны хувилбарыг 2004 онд хэрэглэж эхэлсэн бөгөөд 2002 оноос хойш Terry Booth-ийн судалгааны ажлын бүрэлдэхүүнд ургамлан нөмрөгийн бүрхцийн анализыг хийх зорилгоор хэрэглэж байна. Энэхүү Sample point программ нь маш өргөн хүрээнд тархсан программ бөгөөд 2006 оноос хойш дэлхийн олон орны хэрэглэгч татаж авч хэрэглэсэн байна. Ихэнх хэрэглэгчид уг программыг ургамлан нөмрөгийн бүрхцийг үнэлэхэд хэрэглэдэг боловч **Samplepoint** программ нь зураг дээрээс нүдэнд харагдах янз бүрийн объектийн бүрхцийг үнэлж чаддаг юм. Мониторингийн цэг дээрээс авсан зургаа **Samplepoint** программд оруулж боловсруулалт хийсэн.

Төлөв байдлын зураг	1-р шугамын 1 метр	1-р шугамын 5 метр-т	1-р шугамын 10 метр-т	1-р шугамын 15 метр-т
				
1-р шугамын 20 метр-т	1-р шугамын 25 метр-т	1-р шугамын 30 метр-т	1-р шугамын 35 метр-т	1-р шугамын 40 метр-т
				

Зураг 3. Хээрийн хэмжилт, фотомониторинг дата цуглуулсан мэдээ

Дээрх газрын гадаргуугийн бүрхцийн фото зургийг программд оруулсны дараа компьютерын дэлгэцэн дээр тодруулж томруулах боломжтой бөгөөд зураг нэг бүр дээр 100 цэгийн мэдээлэл авч бичиглэлийн мэдээллийг үетэн, улалж, алаг өвс, сонгино, харгана, сөөг,


нэг наст, хагд, хайрга чулуу, халцгай газар гэсэн бүлгүүдэд ангилж тус бүрийн эзлэх хувийг тодорхойлсон.

Ургамлан нөмрөгийн нийт бүрхэц тодорхойлох 100 цэг өгөгдөж, улаан +тэмдэг бүхий цэгт ургамал таарвал аж ахуйн бүлгээр юмуу зүйлээр, халгай газар, чулуу тааралдвал тэр өгөгдлөөр нь дарсан.



Зураг 4. Ургамлан нөмрөгийн нийт бүрхэц

Дээрх зургийн дагуу улаан цэг дээр тохиолдсон ургамлыг үетэн, хялгана, улалж, сөөг, алаг өвс, шарилж, агь, нэг наст, хагд, чулуу, халцгай газар гэсэн ангиллын дагуу бүлэглэн тэмдэглэсэн. Энэ үйлдэл 100 удаа давагдсаны даар Sample point программ нь зураг дээрх ургамлан нөмрөгийн бүрхцийн мэдээллийг Excel программ дээр файл үүсгэн хадгалдаг.



Зураг 5. Samplepoint программын үр дүн excel программ дээр гарсан

Дээрх excel программ дээрх мэдээллийг доорх хүснэгтэд бичиж, дундаж тоон мэдээллээр газрын гадарга дээрх бүрхэц ба ургамлын бүрхцийг гаргав.

Хүснэгт 2. Ургамлан нөмрөгийн төлөв байдал

Бүлгэмдэл	Үзүүлэлт							
	Ургамлын бүрхэц, %	Зүйлийн бүрэлдэхүүний тоо		Олшрогч ургамлын бүрхэц, %	Халцгай газрын хэмжээ, %	Хад, чулууны хэмжээ, %	Хагдны хэмжээ, %	Ургац ц/га
	1 м ² талбайд,	1 м ² талбайд,	100 м ² талбайд					
Давталт 1								
Давталт 2								
Давталт 3								
Давталт 4								
Дундаж								

Ургац тодорхойлсон арга. Ургацын дээжийг бүрхэц тодорхойлсон цэгээс (1 м² талбай) ургамлыг газрын хөрснөөс 0 см-ийн түвшинд хагд, ногоог аж ахуйн бүлгээр ялган, хайчлан авч сүүдэр газар тавьж хатаан 0,01 нарийвчлалтай жингээр хуурай жинг жигнэж тогтоов. 5 давталтын тоог дундажлан талбайн ургацын тон мэдээг гаргасан. Хэмжилтийг хүснэгтэд нэгтгэн давталтын дундаж гр-аар хэмжигдсэн ургацыг ц/га гэсэн нэгжид шилжүүлэн тооцож тэмдэглэсэн (Буян-Орших Х. х.110, 2005)

Газрын доройтол Газрын доройтлыг ургамлан нөмрөгийн зүйлийн бүрэлдэхүүний өөрчлөлт ба ургамлын тусгац бүрхэц болон ургацаар тодорхойлсон. Ургамлын зүйлийн бүрэлдэхүүний өөрчлөлтийг Друдегийн аргаар, ургамлын тусгац бүрхэвчийг Л.Г.Раменскийн аргаар тус тус тодорхойлж, газрын доройтлыг доройтоогүй эрүүл газар ба доройтлын сул, дунд, хүчтэй 3-н зэрэглэлд хуваасан. Үүнд:

1. Доройтоогүй газар
2. Сул талхлагдан доройтсон
3. Дунд талхлагдан доройтсон
4. Хүчтэй талхлагдан доройтсон

Сул талхлагдан доройтсон газар: Ургамлан нөмрөгийн үндсэн бүлгэмдлийн зонхилогч, дэд зонхилогч нь ценоз /бүлгэмдэл/ үүсгэх үүрэг өөрчлөгдөхгүй боловч зүйлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт бага зэрэг орж, үетний тоо буурч, алаг өвсний тоо ихсэх хандлагатай.

Дунд зэрэг талхлагдан доройтсон газар: Ургамлан нөмрөгийн зонхилогч ургамлын ариг багасаж, нэг наст шарилжууд ариг ихтэй ургасан, зүйлийн бүрэлдэхүүний тоо мэдэгдэхүйц цөөрч, ургамлын бүрхэц багасаж, бүрхцэд олшрогч ургамлын арви ихэссэн.

Их талхлагдан доройтсон газар: Ургамлан нөмрөгийн үндсэн бүлгэмдэл зонхилогч ургамлууд цөөрөн ганц нэг болон сийрэгжиж оронд нь хамхуул, үслэг манана хамхаг, лууль, шарилж зэрэг мал иддэггүй хог ургамлын ариг нэмэгдэж, зүйлийн бүрэлдэхүүний тоо эрс цөөрч, тухайн бүлгэмдэлд 2-3 олшрогч ургамал зонхилогч болсон байх.

2.2. Ургамалжлын мониторинг судалгааны үр дүн

2.2.1. Ургамлан нөмрөгийн өнөөгийн төлөв байдал

“Мандал ресурс” ХХК-ын уурхайн тусгай зөвшөөрлийн талбайд ургамлан нөмрөгийг 12 үндсэн бүлгэмдэлд ургамалжлын бичиглэл гүйцэтгэхэд дараах үр дүнгүүд гарч байна.

У- УУЛЫН БҮЛГЭМДЭЛ

Монгол өвс –боролзой-тостот, Монгол-харгана-тэсэгт, Боролзой-шивэлзэт (60-63-70 /У-VI-1-3; У-VI-1-6; У-VI-2-3), Монгол өвс-боролзой-шавагт, Монгол өвс-бударганат хотирт (59-65/У-VI-1-2; У-VI-1-8), Монгол өвс-баглуурт, Монгол өвс-боролзойт, Монгол өвс-тэсэг-хотирт (66-60-64/У-VI-1-9; У-VI-1-3; У-VI-1-7), Монгол өвс-шавагт, Монгол өвс-баглуур-тост-хотирт (62-66а/У-VI-1-5; У-VI-1-9), Монгол баглуур, Монгол боролз (66-68/У-VI-1-9; У-VI-2-1), Монгол -тэсэг, Монгол-баглуурт (64-66/У-VI-1-7; У-VI-1-9) үндсэн бүлгэмдлийн 100 м² талбайд 10-49 зүйл, 1м² талбайд 5 -10 зүйл бүртгэж, ургамлан нөмрөгийн газрын гадарга дээрх нийт бүрхцэд ургамлын тусгагын бүрхэц 23.0-38.1%, хад чулуу 33.11-64.22%, эзэлж га –ийн биологийн ургац 2.304- 3.802 цн байна.


ЦХ-ЦӨЛИЙН ХЭЭРИЙН БҮЛГЭМДЭЛ

Цөлийн хээрийн Монгол -шаваг-сэдэргэнэ-холимог сөөгт (145 а/ЦХ -I-1-4), Таана-бударгана, Монгол-баглуурт (148-149/ЦХ-I-1-7; ЦХ-I-1-8), Монгол-шавагт, холимог сөөгт (145-243/ЦХ-I-1-4; Н-V-3-1) үндсэн бүлгэмдлийн 100 м² талбайд 10 -20 зүйл, 1м² талбайд 4 -10 зүйл бүртгэж, ургамлан нөмрөгийн газрын гадарга дээрх нийт бүрхцэд ургамлын тусгагын бүрхэц 24.33-34.33%, хайрга чулуу 7.2%, эзэлж га –ийн биологийн ургац 3.31-4.292 цн байна.

Нам хотосын Холимог сөөгт (243/Н-V-3-1), Хармагт (238/Н-IV-3-1) үндсэн бүлгэмдлийн 100 м² талбайд 9-10 (29) зүйл, 1м² талбайд 4 -8 зүйл бүртгэж, ургамлан нөмрөгийн газрын гадарга дээрх нийт бүрхцэд ургамлын тусгагын бүрхэц 45.44-62.0% эзэлж, га –ийн биологийн ургац 5.112-6.18 цн байна.

Хүснэгт 3. Ургамлан нөмрөгийн бичиглэл

№	Бүлгэмдэл	Бэлчээрийн ургамалжлын шалгуур үзүүлэлт							
1	Монгол өвс –боролзой-тостот, Монгол-харгана-тэсэгт, Боролзой-шивэлзэгт (60-63-70 /У-VI-1-3; У-VI-1-6; У-VI-2-3)	10-30 (49)	6-10	25.44	0.33	41.44	33.11	-	2.304
2	Холимог сөөгт (76/У-VII-2-3)	10 -26 (40)	5-8	20.44	5.44	30.33	49.22	-	2.486
3	Монгол өвс-боролзой-шавагт, Монгол өвс-бударганат хотирт (59-65/У-VI-1-2; У-VI-1-8)	15-35	12 - 18	29.2	0.4	25.0	45.8	-	3.706
4	Монгол өвс-баглуурт, Монгол өвс-боролзойт, Монгол өвс-тэсэг-хотирт (66-60-64/У-VI-1-9; У-VI-1-3; У-VI-1-7)	10-23	5 -8	38.1	21.11	21.33	42.11	-	3.242
5	Холимог сөөгт (243/Н-V-3-1)	10 -15 (29)	4-8	45.44	10.44	28.33	45.11	-	5.112
6	Монгол баглуур, Монгол боролз (66-68/У-VI-1-9; У-VI-2-1)	8 –12 (22)	5-7	23.0	15.44	12.78	64.22	-	2.992
7	Монгол -тэсэг, Монгол-баглуурт (64-66/У-VI-1-7; У-VI-1-9)	10-19	5-7	37.33	25.89	12.0	50.67	-	3.802
8	Хармагт (238/Н-IV-3-1)	9	4-6	62.0	23.33	57.22	3.78	-	6.18
9	Харганат (161/ЦХ-I-3-1) Монгол өвс-шавагт, Монгол өвс-баглуур-тост-хотирт (62-66а/У-VI-1-5; У-VI-1-9)	8-20	5 -8	20.22	7.44	44.78	35.0	-	2.342
10	Монгол -шаваг-сэдэргэнэ-холимог сөөгт (145 а/ЦХ -I-1-4)	10-17	6-10	40.00	15.89	39.67	20.33	-	3.882
11	Таана-бударгана, Монгол-баглуурт (148-149/ЦХ-I-1-7; ЦХ-I-1-8)	9-12 (20)	6 -10	42.22	28.67	23.44	34.33	-	3.31
12	Монгол-шавагт, холимог сөөгт (145-243/ЦХ-I-1-4; Н-V-3-1)	10-19	4-8	41.56	17.78	35.33	24.33	-	4.292




Зураг 6. Мандал Ресурс ХХК-ны уурхайн тусгай зөвшөөрлийн талбайн ургамалжлын зураг

Хүснэгт 4. Мандал Ресурс ХХК-ын уурхайн тусгай зөвшөөрлийн талбайн ургамалжлын судалгааны талбайн хэмжээ, га

ID	Бүлгэмдэл	Талбай, га
1	Монгол өвс-боролзой-тостот, Монгол-харгана-тэсэгт, Боролзой-шивэлзэгт (60-63-70 /У-VI-1-3; У-VI-1-6; У-VI-2-3)	4.76
2	Холимог сөөгт (76/У-VII-2-3)	15.16
3	Монгол өвс-боролзой-шавагт, Монгол өвс-бударганат хотирт (59-65/У-VI-1-2; У-VI-1-8)	31.44
4	Монгол өвс-баглуурт, Монгол өвс-боролзойт, Монгол өвс-тэсэг-хотирт (66-60-64/У-VI-1-9; У-VI-1-3; У-VI-1-7)	7.85
5	Холимог сөөгт (243/Н-V-3-1)	10.87
6	Монгол баглуур, Монгол боролз (66-68/У-VI-1-9; У-VI-2-1)	42.98
7	Монгол -тэсэг, Монгол-баглуурт (64-66/У-VI-1-7; У-VI-1-9)	16.19
8	Хармагт (238/Н-IV-3-1)	19.50
9	Монгол өвс-шавагт, Монгол өвс-баглуур-тост-хотирт (62-66a/У-VI-1-5; У-VI-1-9)	52.84
10	Монгол -шаваг-сэдэргэнэ-холимог сөөгт (145 а/ЦХ -I-1-4)	162.75
11	Таана-бударгана, Монгол-баглуурт (148-149/ЦХ-I-1-7; ЦХ-I-1-8)	23.24
12	Монгол-шавагт, холимог сөөгт (145-243/ЦХ-I-1-4; Н-V-3-1)	142.48
0	Эвдэрсэн газар (Зам, халцгай, ухагдсан)	28.62
1	Ашиглагдсан газар (Кемп, үйлдвэр, тэсрэх бодис агуулах)	21.89
	Нийт	580.56

2.2.2. Ургамлын мониторинг бичиглэл

М 1. Монгол өвс –боролзой-тостот, Монгол-харгана-тэсэгт, Боролзой-шивэлзэт (60-63-70 /У-VI-1-3; У-VI-1-6; У-VI-2-3) бүлгэмдэлд 100м² талбайд (1 –р бичиглэл) Сайрын хялгана (*Stipa glareosa* P.Smirn.), Пеллитын шивэлз (*Ptilagrostis Pelloitii* (Danguy) Grub.), Төлөгчдүү боролзой (*Ajania acheleoides* (Turcz.) Poljak.), Орог тэсэг (*Eurotia ceratoides* (L.) С.А.Мей), харганаас Нарийн навчит харгана (*Caragana stenophylla* Pojark.), Коржинскийн харгана (*Caragana Korshinskii* Kom.) зонхилж, үетэнээс Саман ерхөг (*Agropyron cristatum* (L.) P.B.), сонгиноос Таана буюу багалгар сонгино (*Allium polyrrhizum* Turcz. ex RgL.), Хөмөл (*Allium mongolicum* Rgl.), нэг талтанаас Говийн хэрээн нүд (*Asparagus gobicus* Ivanova.ex Grub.), Нарийн цахилдаг (*Iris tenuifolia* Pall.), чулуусаг алаг өвснөөс Цөлийн тайр (*Gypsophila desertorum* (Bge.) Fenzl.), Бууралдуу янгиц (*Ptilotrichum canescens* С.А. Мей.), Зузаан навчит багдай (*Dontostemon crassifolius* Bge.), Өтлүүн багдай (*Dontostemon senilis* Maxim.), Шар хотир (*Zygophyllum xanthoxylon* (Bge.) Maxim.), Розовын хотир (*Zygophyllum Rosowii* Bge.), Бүнгийн хавраг (*Ferula Bungeania* Kitag.), Нарийн бэрмэг (*Limonium tenellum* (Turcz.) Ktze.), Амманы сэдэргэнэ (*Convolvulus Ammanii* Desr.), Сөөгөн сэдэргэнэ (*Convolvulus fruticosus* Pall.), Арзгар согсоот (*Heteropappus hispidus* (Thunbg.) Less.), Монгол шар далан (*Tugarinovia mongolica* Iljin.), Монгол чоногоно (*Jurinea mongolica* Maxim.), Хуурамч дэрвэгэр хависгана (*Scorzonera pseudodivaricata* Lipsch.), Монгол хависгана (*Scorzonera mongolica* Maxim.), Данхар хависгана (*Scorzonera capito* Maxim.), буурцагтнаас Хувьсанги хунчир (*Astragalus variabilis* Bge.ex Maxim.), Хөндийн хунчир (*Astragalus vallestria* R.Kam.), Өргөст ортууз (*Oxytropis aciphylla* Ldb.), шарилжнаас Хуурайсаг шарилж (*Artemisia xerophytica* Krasch.), Шар шарилж (*Artemisia xanthochloa* Krasch.), заримдаг сөөгөнцөрөөс Монгол азар (*Calligonum mongolicum* Turcz.), Бор бударгана (*Salsola passerina* Bge.), Ахар навчит баглуур (*Anabasis brevifolia* С.А.Мей.), Дагуур хүж өвс (*Haplophyllum dahuricum* (L.) G. Don.), Зүүнгарын улаанбударгана (*Reaumuria soongorica* (Pall.) Maxim.), Монгол догар (*Caryopteris mongolica* Bge.), Төв азийн лавай (*Asterothamnus centrali-asiaticus* Новорокр.), Говийн тост (*Brachanthemum gobicum* Krasch.), цөөн настнаас Ногоон хоног будаа (*Setaria viridis* (L.) P.B.), Гейманын бөөдий (*Aristida Heymannii* Rgl.), Умардын Огтонын сүүл (*Enneapogon borealis* (Griseb.) Honda.), Бага хургалж (*Eragrostis minor* Host.), Монгол хамхуул (*Corispermum mongolicum* Iljin), Өргөст бударгана (*Salsola pestifera* Nels.), Шивүүрт цулихир (*Agriophyllum pungens* (Vahl) Link ex.A. Dietr.), Зэлэн зангуу (*Tribulus terrestris* L.), Ямаан шарилж (*Artemisia scoparia* Waldst. et Kit.), Гмелиний тайжийн жинс (*Echinops Gmelinii* Turcz.) зэрэг 15 овог, 38 төрөл, 49 зүйл ургамал ургасан, 1м²-д 6 -10 орчим зүйл тааралдаж байв. Ургамлын бүрхэц 25.44%, түүнээс олшрогч цөөн наст ургамал 0.33%, нийт бүрхцэд хайрга чулуу 33.11%, халцгай газар 41.44% байна.



Зураг 7. Ургамалжлын мониторинг бичиглэл 1. Монгол өвс –боролзойт бүлгэмдэл
N 44°22'33.00''; E 104°03'21.6''; h 1116; 2024.08.24.

Хүснэгт 5. Монгол өвс –боролзой-тостот, Монгол-харгана-тэсэгт, Боролзой-шивэлзэт ургамлан нөмрөгийн төлөв байдлын бичиглэл

Монгол өвс – боролзойт	Үзүүлэлт							
	Ургамлын бүрхэц, %	Зүйлийн тоо		Олшрогч ургамлын бүрхэц, %	Халцга й газар, %	Хайрга, чулуу, %	Хагд , %	Урга ц/га
		1 м ² талбайд	1 м ² талбайд					
Давталт 1	15	6	10	0	55	30	-	-
Давталт 2	22	7	15	0	41	37	-	2.27
Давталт 3	29	8	20	0	32	39	-	2.31
Давталт 4	29	8	21	2	52	19	-	2.14
Давталт 5	33	10	30	0	48	19	-	2.28
Давталт 6	22	7	23	0	38	40	-	2.52
Давталт 7	26	8	25	0	27	47	-	-
Давталт 8	11	6	10	1	38	51	-	-
Давталт 9	42	9	29	0	42	16	-	-
Дундаж	25.44	6-10	10-30 (49)	0.33	41.44	33.11	-	2.304

Монгол өвс –боролзой-тостот, Монгол-харгана-тэсэгт, Боролзой-шивэлзэт бүлгэмдлийн га –ийн ургац 2.304 цн, үүнээс үетэн 0.38 цн, алаг өвс 0.322, боролзой, шаваг, тост 1.602 цн байна.

Хүснэгт 6. Монгол өвс –боролзой-тостот, Монгол-харгана-тэсэгт, Боролзой-шивэлзэт бүлгэмдлийн ургацын бичиглэл

Ургамлын бүлэг	Давталт					Бүгд	Дундаж	Ургац, ц/га
	1	2	3	4	5			
Үетэн	3.1	3.5	4.1	3.8	4.5	19.0	3.8	0.38
Алаг өвс	2.5	3.1	2.8	3.6	4.1	16.1	3.22	0.322
Боролзой, шаваг, тост	17.1	16.5	14.5	15.4	16.6	80.1	16.02	1.602
Нийт	22.7	23.1	21.4	22.8	25.2	115.2	23.04	2.304

М2. Холимог сөөгт (76/У-VII-2-3) бүлгэмдэлд 100м² талбайд (2 –р бичиглэл) Төлөгчдүү боролзой (*Ajania acheleoides* (Turcz.) Poljak.), Орог тэсэг (*Eurotia ceratoides* (L.) С.А.Мей), харганаас Нарийн навчит харгана (*Caragana stenophylla* Rojark.), Коржинскийн харгана (*Caragana Korshinskii* Kom.), Бариулт бүйлээс (*Amygdalus pedunculata* Pall.), Заг (*Haloxylon ammodendron* (С.А.Мей.) Вге.), Ахар навчит баглуур (*Anabasis brevifolia* С.А.Мей.), Монгол азар (*Calligonum mongolicum* Turcz.), Бор бударгана (*Salsola passerina* Вге.), Дагуур хүж өвс (*Haplophyllum dahuricum* (L.) G. Don.), Зүүнгарын улаанбударгана (*Reaumuria soongorica* (Pall.) Maxim.), Монгол догар (*Caryopteris mongolica* Вге.), Төв азийн лавай (*Asterothamnus centrali-asiaticus* Novopokr.), Говийн тост (*Brachanthemum gobicum* Krasch.), Шар хотир (*Zygophyllum xanthoxylon* (Вге.) Maxim.), Сөөгөн сэдэргэнэ (*Convolvulus fruticosus* Pall.), Хуурайсаг шарилж (*Artemisia xerophytica* Krasch.), Шар шарилж (*Artemisia xanthochloa* Krasch.), зонхилж, үетэнээс Сайрын хялгана (*Stipa glareosa* P.Smirn.), Пеллитын шивэлз (*Ptilagrostis Pelloitii* (Danguy) Grub.), Дэрвээн хазаар өвс (*Cleistogenes squarrosa* (Trin.) Keng.), сонгиноос Таана буюу багалгар сонгино (*Allium polyrrhizum* Turcz. ex RgL.), Хөмөл (*Allium mongolicum* Rgl.), нэг талтанаас Говийн хэрээн нүд (*Asparagus gobicus* Ivanova.ex Grub.), Нарийн цахилдаг (*Iris tenuifolia* Pall.), чулуусаг алаг өвснөөс Цөлийн тайр (*Gypsophila desertorum* (Вге.) Fenzl.), Бууралдуу янгиц (*Ptilotrichum canescens* С.А. Мей.), Зузаан навчит багдай (*Dontostemon crassifolius* Вге.), Өтлүүн багдай (*Dontostemon senilis* Maxim.), Хуурамч дэрвэгэр хависгана (*Scorzonera pseudodivaricata* Lipsch.), Монгол хависгана (*Scorzonera mongolica* Maxim.), Данхар хависгана (*Scorzonera capito* Maxim.), буурцагтнаас Өргөст ортууз (*Oxytropis aciphylla* Ldb.), цөөн настнаас Ногоон хоног будаа (*Setaria viridis* (L.) P.B.), Гейманын бөөдий (*Aristida Heymannii* Rgl.), Умардын Огтонын сүүл (*Enneapogon borealis* (Griseb.) Honda.), Бага хургалж (*Eragrostis minor* Host.), Монгол хамхуул (*Corispermum mongolicum* Iljin), Өргөст бударгана (*Salsola pestifera* Nels.), Шивүүрт цулихир (*Agriophyllum pungens* (Vahl) Link ex.A. Dietr.), Зэлэн зангуу (*Tribulus terrestris* L.), Ямаан шарилж (*Artemisia scoparia* Waldst. et Kit.), Гмелиний тайжийн жинс (*Echinops Gmelinii* Turcz.) зэрэг 15 овог, 38 төрөл, 40 зүйл ургамал ургасан, 1м²-д 5 -8 орчим зүйл тааралдаж байв. Ургамлын бүрхэц 20.44%, түүнээс олшрогч цөөн наст ургамал 5.44%, нийт бүрхцэд хайрга чулуу 30.33%, халцгай газар 49.22% байна (зураг 7, хүснэгт 7).

Хүснэгт 7. Холимог сөөгт ургамлан нөмрөгийн төлөв байдлын бичиглэл

Холимог сөөгт	Үзүүлэлт							Ургац ц/га
	Ургамлын бүрхэц, %	Зүйлийн тоо		Олшрогч ургамлын бүрхэц, %	Халцгай газар, %	Хайрга, чулуу, %	Хагд, %	
		1 м ² талбайд	1 м ² талбайд					
Давталт 1	28	8	20	13	12	60	-	1.81
Давталт 2	6	5	10	5	18	76	-	1.82
Давталт 3	33	8	25	5	8	59	-	1.81
Давталт 4	16	6	15	7	36	48	-	1.98
Давталт 5	19	7	13	5	34	47	-	5.01
Давталт 6	35	8	26	6	27	38		
Давталт 7	25	7	20	2	18	57		
Давталт 8	17	5	11	5	66	17		
Давталт 9	5	5	10	1	54	41		
Дундаж	20.44	5-8	10-26 (40)	5.44	30.33	49.22	-	2.486



Зураг 8. Ургамлын бичиглэл 2. Холимог сөөгт бүлгэмдэл N 44°22'39.98"; E 104°03'39.59"; h 1127; 2024.08.26.

Холимог сөөгт бүлгэмдлийн га –ийн ургац 2.486 цн, үүнээс үетэн 0.56 цн, хүж өвс 0.674 цн, бусад сөөг 0.63 цн, харгана 0.91 цн байна.

Хүснэгт 8. Холимог сөөгт бүлгэмдлийн ургацын бичиглэл

Ургамлын бүлэг	Давталт					Бүгд	Дундаж	Ургац, ц/га
	1	2	3	4	5			
Үетэн	4.8	5.5	6.1	6.5	2.1	25.0	5.6	0.56
Хүж өвс	6.2	7.1	6.5	7.5	0.0	27.3	6.74	0.674
Бусад сөөг	7.1	5.6	5.5	5.8	2.5	26.5	6.3	0.63
Харгана	0.0	0.0	0.0	0.0	45.5	45.5	9.1	0.91
Нийт	18.1	18.2	18.1	19.8	50.1	124.3	24.86	2.486

М3. Монгол өвс-боролзой-шавагт, Монгол өвс-бударганат хотирт (59-65/У-VI-1-2; У-VI-1-8) бүлгэмдлийн 100м² талбайд (3 –р бичиглэл) Сайрын хялгана (*Stipa glareosa* P.Smirn.), Төлөгчдүү боролзой (*Ajania acheleoides* (Turcz.) Poljak.), Ахар навчит баглуур (*Anabasis brevifolia* С.А.Мей.), Зүүнгарын улаанбударгана (*Reaumuria soongorica* (Pall.) Maxim.), Хуурайсаг шарилж (*Artemisia xerophytica* Krasch.), Шар хотир (*Zygophyllum xanthoxylon* (Bge.) Maxim.) зонхилж, сонгиноос Таана буюу багалгар сонгино (*Allium polyrrhizum* Turcz. ex Rgl.), Хөмөл (*Allium mongolicum* Rgl.), нэг талтанаас Говийн хэрээн нүд (*Asparagus gobicus* Ivanova.ex Grub.), чулуусаг алаг өвснөөс Намхан гишүүнэ (*Rheum nanum* Sievers.), Цөлийн тайр (*Gypsophila desertorum* (Bge.) Fenzl.), Олон наст Багдай (*Dontostemon perennis* С.А.Мей.), Амманы сэдэргэнэ (*Convolvulus Ammanii* Desr.), Монгол шар далан (*Tugarinovia mongolica* Iljin.), Хуурамч дэрвэгэр хависгана (*Scorzonera pseudodivaricata* Lipsch.), Монгол хависгана

(*Scorzonera mongolica* Maxim.), буурцагтнаас Хувьсанги хунчир (*Astragalus variabilis* Bge. ex Maxim.), Хөндийн хунчир (*Astragalus vallestris* R.Kam.), Грубовын хунчир (*Astragalus Grubovii* Sancz.), Өргөст ортууз (*Oxytropis aciphylla* Ldb.), заримдаг сөөгөнцөрөөс Сөөгөн сэдэргэнэ (*Convolvulus fruticosus* Pall.), Дагуур хүж өвс (*Haplophyllum dahuricum* (L.) G. Don.), Монгол догар (*Caryopteris mongolica* Bge.), Төв азийн лавай (*Asterothamnus centrali-asiaticus* Novopokr.), цөөн настнаас Ногоон хоног будаа (*Setaria viridis* (L.) P.B.), Гейманын бөөдий (*Aristida Heymannii* Rgl.), Бага хургалж (*Eragrostis minor* Host.), Умардын Огтонын сүүл (*Enneapogon borealis* (Griseb.) Honda.), Монгол хамхуул (*Corispermum mongolicum* Iljin), Өргөст бударгана (*Salsola pestifera* Nels.), Услиг манан-хамхаг (*Bassia dasyphylla* (Fisch. et Mey.) Ktze.), Саваан булган сүүл (*Chloris virgata* Sw.), Налчигар сүүт өвс (*Euphorbia humifusa* Willd.), Зэлэн зангуу (*Tribulus terrestris* L.), Гмелиний тайжийн жинс (*Echinops Gmelinii* Turcz.) зэрэг 17 овог, 30 төрөл, 35 зүйл ургамал ургасан, 1м²-д 6 -8 орчим зүйл тааралдаж байв. Ургамлын бүрхэц 29.2%, түүнээс олшрогч цөөн наст ургамал 0.4%, нийт бүрхцэд хайрга чулуу 45.8%, халцгай газар 25.0% байна.



Зураг 9. Ургамлын бичиглэл 3. Монгол өвс-боролзой-шавагт, Монгол өвс-бударганат хотирт бүлгэмдэл N 44°22'43.37''; E 104°04'03.57''; h 1137; 2024.08.28.

Хүснэгт 9. Монгол өвс-боролзой-шавагт, Монгол өвс-бударганат хотирт ургамлан нөмрөгийн төлөв байдлын бичиглэл

Монгол өвс-боролзой-шавагт, Монгол өвс-бударганат хотирт	Үзүүлэлт							
	Ургамлын бүрхэц, %	Зүйлийн тоо		Олшрогч ургамлын бүрхэц, %	Халцгай газар, %	Хайрга, чулуу, %	Хагд, %	Ургац ц/га
		1 м ² талбайд	1 м ² талбайд					
Давталт 1	36	8	25	2	25	39	-	3.65
Давталт 2	28	7	15	0	36	36	-	6.8
Давталт 3	22	6	20	0	38	40	-	3.0
Давталт 4	27	8	16	0	21	52	-	1.95
Давталт 5	33	8	35	0	5	62	-	3.13
Дундаж	29.2	12 -18	15-35	0.4	25.0	45.8	-	3.706

Монгол өвс-боролзой-шавагт, Монгол өвс-бударганат хотирт бүлгэмдлийн га –ийн ургац 3.706 цн, үүнээс үетэн 0.464 цн, таана 0.814 цн, шавяг боролзой 0.814 цн, хотир 1.31 цн, алаг өвс 0.276 цн байна.

Хүснэгт 10. Монгол өвс-боролзой-шавагт, Монгол өвс-бударганат хотирт бүлгэмдлийн ургацын бичиглэл

Ургамлын бүлэг	Давталт					Бүгд	Дундаж	Ургац, ц/га
	1	2	3	4	5			
Үетэн	6.5	0.0	7.6	10.1	8.8	33.0	6.6	0.66
Таана	10.5	1.5	8.2	6.3	5.8	32.3	6.46	0.464
Шеваг, боролзой	16.5	0.0	10.7	0.0	13.5	40.7	8.14	0.814
Хотир	0.0	65.5	0.0	0.0	0.0	65.5	13.1	0.131
Алаг өвс	3.0	1.0	3.5	3.1	3.2	13.8	2.76	0.276
Нийт	36.5	68.0	30.0	19.5	31.3	185.3	37.06	3.706

М4. Монгол өвс-баглуурт, Монгол өвс-боролзойт, Монгол өвс-тэсэг-хотирт (66-60-64/У-VI-1-9; У-VI-1-3; У-VI-1-7) бүлгэмдэлд 100м² талбайд (4 –р бичиглэл) Сайрын хялгана (*Stipa glareosa* P.Smirn.), Ахар навчит баглуур (*Anabasis brevifolia* С.А.Мей.), Төлөгчдүү боролзой (*Ajania acheleoides* (Turcz.) Poljak.), Орог тэсэг (*Eurotia ceratoides* (L.), Шар хотир (*Zygophyllum xanthoxylon* (Bge.) Maxim.) зонхилж, сонгиноос Таана буюу багалгар сонгино (*Allium polyrrhizum* Turcz. ex RgL.), Хөмөл (*Allium mongolicum* Rgl.), чулуусаг алаг өвснөөс Намхан гишүүнэ (*Rheum nanum* Sievers.), Цөлийн тайр (*Gypsophila desertorum* (Bge.) Fenzl.), Олон наст Багдай (*Dontostemon perennis* С.А.Мей.), Розовын хотир (*Zygophyllum Rosowii* Bge.), Бүнгийн хавраг (*Ferula Bungeana* Kitag.), Хуурамч дэрвэгэр хависгана (*Scorzonera pseudodivaricata* Lipsch.), Монгол хависгана (*Scorzonera mongolica* Maxim.), буурцагтнаас Хувьсанги хунчир (*Astragalus variabilis* Bge.ex Maxim.), Хөндийн хунчир (*Astragalus vallestis* R.Kam.), Грубовын хунчир (*Astragalus Grubovii* Sancz.), Туулайн хунчир (*Astragalus laguroides* Pall.), цөөн настнаас Бага хургалж (*Eragrostis minor* Host.), Гейманын бөөдий (*Aristida Heymannii* Rgl.), Умардын Огтонын сүүл (*Enneapogon borealis* (Griseb.) Honda.), Стефаны заан таваг (*Erodium Stephanianum* Willd.), Зэлэн зангуу (*Tribulus terrestris* L.), Гмелиний тайжийн жинс (*Echinops Gmelinii* Turcz.) зэрэг 11 овог, 17 төрөл, 23 зүйл ургамал ургасан, 1м²-д 5 -8 орчим зүйл тааралдаж байв. Ургамлын бүрхэц 38.1%, түүнээс олшрогч цөөн наст ургамал 21.11%, нийт бүрхцэд хайрга чулуу 42.11%, халцгай газар 21.33% байна.

Хүснэгт 11. Монгол өвс-баглуурт, Монгол өвс-боролзойт, Монгол өвс-тэсэг-хотирт уулын ургамал нөмрөгийн төлөв байдлын бичиглэл

Монгол өвс-баглуурт, Монгол өвс-боролзойт, Монгол өвс-тэсэг-хотирт	Үзүүлэлт							
	Ургамлын бүрхэц, %	Зүйлийн тоо		Олшрогч ургамлын бүрхэц, %	Халцгай газар, %	Хайрга, чулуу, %	Хагд, %	Ургац ц/га
		1 м ² талбайд	1 м ² талбайд					
Давталт 1	24	8	11	16	20	56	-	3.35
Давталт 2	48	5	20	45	13	39	-	3.03
Давталт 3	64	5	10	39	16	20	-	4.25
Давталт 4	34	7	23	20	24	42	-	2.76
Давталт 5	33	5	18	22	36	31	-	2.82
Давталт 6	30	6	21	29	17	53		
Давталт 7	46	8	23	7	26	28		
Давталт 8	37	6	22	5	27	36		
Давталт 9	13	5	10	7	13	74		
Дундаж	38.1	5-8	10-23	21.11	21.33	42.11	-	3.242



Зураг 10. Ургамлын бичиглэл 4. Монгол өвс-баглуурт, Монгол өвс-боролзойт, Монгол өвс-тэсэг-хотирт уулын бүлгэмдэл
N 44°22'44.46"; E 104°04'37.23"; h 1108; 2024.08.26.

Монгол өвс-баглуурт, Монгол өвс-боролзойт, Монгол өвс-тэсэг-хотирт уулын бүлгэмдлийн га –ийн ургац 3.242 цн, үүнээс үетэн, таана 0.706 цн, баглуур 0.994 цн, боролзой 0.292 цн, нэг настан 0.53 цн, тэсэг, хотир 0.72 цн байна.

Хүснэгт 12. Монгол өвс-баглуурт, Монгол өвс-боролзойт, Монгол өвс-тэсэг-хотирт уулын бүлгэмдлийн ургацын бичиглэл

Ургамлын бүлэг	Давталт					Бүгд	Дундаж	Ургац, ц/га
	1	2	3	4	5			
Үетэн, таана	8.5	9.1	0	10.2	7.5	35.3	7.06	0.706
Боролзой	3.5	2.8	1.2	4	3.1	14.6	2.92	0.292
Баглуур	15	12.9	0	9.2	12.6	49.7	9.94	0.994
Нэг настан	6.5	5.5	5.3	4.2	5	26.5	5.3	0.53
Тэсэг, хотир	0	0	36	0	0	36	7.2	0.72
Нийт	33.5	30.3	42.5	27.6	28.2	162.1	32.42	3.242

М5. Холимог сөөгт (243/ Н-V-3-1) нам хотосын бүлгэмдлийн 100м² талбайд (**5 –р бичиглэл**) Монгол бүйлээс (*Amygdalus mongolica* Maxim.), Монгол азар (*Calligonum mongolicum* Turcz.), Бор бударгана (*Salsola passerina* Bge.), Ахар навчит баглуур (*Anabasis brevifolia* С.А.Мей.), Нарийн навчит харгана (*Caragana stenophylla* Pojark.), Шар хотир (*Zygophyllum xanthoxylon* (Bge.) Maxim.), Сибирь хармаг (*Nitraria sibirica* Pall.), Төв азийн лавай (*Asterothamnus centrali-asiaticus* Novopokr.), Хуурайсаг шарилж (*Artemisia xerophytica* Krasch.), Шар шарилж (*Artemisia xanthochloa* Krasch.), сонгиноос Таана буюу багалгар сонгино (*Allium polyrrhizum* Turcz. ex Rgl.), Хөмөл (*Allium mongolicum* Rgl.), улалжаас Утсан навчит улалж (*Carex stenophylloides* V.Krecz.), алаг өвснөөс Цөлийн тайр (*Gypsophila desertorum* (Bge.) Fenzl.), Алтан бэрмэг (*Limonium aureum* (L.) Hill ex Ktze.), Хуурамч дэрвэгэр хависгана (*Scorzonera pseudodivariata* Lipsch.), Монгол чоногоно (*Jurinea mongolica* Maxim.), буурцагтнаас Хөндийн хунчир (*Astragalus vallestria* R.Kam.), Ганцнавчит хунчир (*Astragalus monophyllus* Bge.), цөөн настнаас Саваан булган сүүл (*Chloris virgata* Sw.), Баг хуш-хамхаг (*Halogeton glomeratus* (M.B.) С.А.Мей.), Үслиг манан-хамхаг (*Bassia dasyphylla* (Fisch. et Mey.) Ktze.), Гейманын бөөдий (*Aristida Heymannii* Rgl.), Бага хургалж (*Eragrostis minor* Host.), Сибирь шорной (*Atriplex sibirica* L.), Зэлэн зангуу (*Tribulus terrestris* L.), Харлаг үмхий өвс (*Peganum nigellastrum* Bge.), Стефаны заан таваг (*Erodium Stephanianum* Willd.), Толбот шар бэрээмэг (*Arnebia guttata* Bge.), Цацагт хөх бэрээмэг (*Arnebia fimbriata* Maxim.), Үсхий нохойн хэл (*Panzeria lanata* (L.) Bge.), модноос Одой хайлаас (*Ulmus pumila* L.) зэрэг 13 овог, 26 төрөл, 30 зүйл ургамал ургасан, 1м²-д 4 -8 орчим зүйл тааралдаж байв. Ургамлын бүрхэц 45.44%, түүнээс олшрогч цөөн наст ургамал 10.44%, нийт бүрхцэд хайрга чулуу 26.22%, халцгай газар 28.33% байна.



Зураг 11. Ургамлын бичиглэл 5. Холимог сөөгт нам хотосын бүлгэмдэл
N 44°22'45.48"; E 104°04'47.35"; h 1103; 2024.08.25.

Хүснэгт 13. Холимог сөөгт нам хотосын ургамлан нөмрөгийн төлөв байдлын бичиглэл

Холимог сөөгт	Ургамлын бүрхэц, %	Зүйлийн тоо		Олшрогч ургамлын бүрхэц, %	Халцгай газрын хэмжээ, %	Хайрга, чулууны хэмжээ, %	Хагдны хэмжээ, %	Ургац ц/га
	1 м ² талбайд,	1 м ² талбайд,	100 м ² талбайд					
Давталт 1	73	4	10	10	21	6	-	5.58
Давталт 2	15	8	15	14	20	65	-	3.46
Давталт 3	73	4	10	4	21	6	-	4.7
Давталт 4	56	5	14	10	37	7	-	6.59
Давталт 5	49	5	13	22	44	7	-	5.23
Давталт 6	13	6	12	7	21	66	-	-
Давталт 7	59	8	11	12	35	6	-	-
Давталт 8	14	7	14	9	28	58	-	-
Давталт 9	57	8	13	6	28	15	-	-
Дундаж	45.44	4-8	10 -15 (30)	10.44	28.33	45.11	-	5.112

Холимог сөөгт бүлгэмдлийн га –ийн ургац 5.112 цн, үүнээс холимог сөөг 2.946 цн, үетэн, таана 0.69 цн, нэг настан 1.476 цн байна.

Хүснэгт 14. Холимог сөөгт бүлгэмдлийн ургацын бичиглэл

Ургамлын бүлэг	Давталт					Бүгд	Дундаж	Ургац, ц/га
	1	2	3	4	5			
Холимог сөөг	45.0	0.0	40.2	35.6	26.5	147.3	29.46	2.946
Үетэн, таана	0.0	16.1	5.5	7.1	5.8	34.5	6.9	0.69
Нэг настан	10.8	18.5	1.3	23.2	20.0	73.8	14.76	1.476
Нийт	55.8	34.6	47.0	65.9	52.3	255.6	51.12	5.112

М6. Монгол баглуур, Монгол боролз (66-68/У-VI-1-9; У-VI-2-1) уулын бүлгэмдлийн 100м² талбайд (6 –р бичиглэл) үетэнээс Сайрын хялгана (*Stipa glareosa* P.Smirn.), Ахар навчит баглуур (*Anabasis brevifolia* С.А.Мей.), Төлөгчдүү боролзой (*Ajania acheleoides* (Turcz.) Poljak.) зонхилж, сонгиноос Таана буюу багалгар сонгино (*Allium polyrrhizum* Turcz. ex RgL.), чулуусаг алаг өвснөөс Цөлийн тайр (*Gypsophila desertorum* (Bge.) Fenzl.), Бууралдуу янгиц (*Ptilotrichum canescens* С.А. Мей.), Өтлүүн багдай (*Dontostemon senilis* Maxim.), Дэвүүрт хотир (*Zygophyllum pterocarpum* Bge.), Монгол хависгана (*Scorzonera mongolica* Maxim.), Хуурамч дэрвэгэр хависгана (*Scorzonera pseudodivaricata* Lipsch.), сөөгөөс Шар хотир (*Zygophyllum xanthoxylon* (Bge.) Maxim.), Монгол догар (*Caryopteris mongolica* Bge.), Орог тэсэг (*Eurotia ceratoides* (L.) С.А.Мей), Ямаан ангалзуур (*Lagochilus ilicifolius* Bge.), Дагуур хүж өвс (*Haplophyllum dahuricum* (L.) G. Don.), буурцагтнаас Хөндийн хунчир (*Astragalus vellestris*

R.Kam.), цөөн настнаас Ногоон хоног будаа (*Setaria viridis* (L.) P.B.), Бага хургалж (*Eragrostis minor* Host.), Гейманын бөөдий (*Aristida Heymannii* Rgl.), Умардын Огтонын сүүл (*Enneapogon borealis* (Griseb). Honda.), Монгол хамхуул (*Corispermum mongolicum* Iljin), Өргөст бударгана (*Salsola pestifera* Nels.), Гмелиний тайжийн жинс (*Echinops Gmelinii* Turcz.) зэрэг 11 овог, 21 төрөл, 22 зүйл ургамал ургасан, 1м²-д 5 -7 орчим зүйл тааралдаж байв. Ургамлын бүрхэц 23.0%, түүнээс олшрогч цөөн наст ургамал 15.44%, нийт бүрхцэд хайрга чулуу 64.22%, хагд 12.78%, халцгай газар 42.3% байна.



Зураг 12. Ургамлын бичиглэл 6. Монгол баглуур, Монгол боролз бүлгэмдэл N 44°22'28.72"; E 104°05'05.55"; h 1321; 2025.08.25.

Хүснэгт 15. Монгол баглуур, Монгол боролз ургамлан нөмрөгийн төлөв байдлын бичиглэл

Бүлгэмдэл	Үзүүлэлт							
	Ургамлын бүрхэц, %	Зүйлийн тоо		Олшрогч ургамлын бүрхэц, %	Халцгай газар, %	Хайрга, чулуу, %	Хагд, %	Ургац ц/га
Монгол-баглуур, Монгол боролз	1 м ² талбайд	1 м ² талбайд	100 м ² талбайд					
Давгалт 1	18	5	8	9	11	71	-	2.56
Давгалт 2	26	7	10	12	6	68	-	2.76
Давгалт 3	13	6	11	5	3	84	-	3.28
Давгалт 4	16	5	8	7	15	69	-	2.96
Давгалт 5	17	5	8	7	23	60	-	3.4
Давгалт 6	17	5	8	6	21	62	-	-
Давгалт 7	41	5	8	41	20	39	-	-
Давгалт 8	18	6	12	18	5	77	-	-
Давгалт 9	41	6	12	34	11	48	-	-
Дундаж	23.0	5-7	8 -12 (22)	15.44	12.78	64.22	-	2.992

Монгол баглуур, Монгол боролз бүлгэмдлийн га –ийн ургац 2.992 цн, үүнээс үетэн, таана 0.992 цн, алаг өвс 0.482 цн, баглуур, боролзой 1.0401 цн, Нэг настан 0.514 цн байна.

Хүснэгт 16. Монгол баглуур, Монгол боролз бүлгэмдлийн ургацын бичиглэл

Ургамлын бүлэг	Давгалт					Бүгд	Дундаж	Ургац, ц/га
	1	2	3	4	5			
Монгол, таана	7.2	5.5	8.3	10	18.6	49.6	9.92	0.992
Алаг өвс	5.5	6.3	4.2	5.6	2.5	24.1	4.82	0.482
Баглуур, боролзой	8.1	9.3	12	10.5	10.3	50.2	10.04	1.004
Нэг настан	4.8	6.5	8.3	3.5	2.6	25.7	5.14	0.514
Нийт	25.6	27.6	32.8	29.6	34	149.6	29.92	2.992

М7. Монгол -тэсэг, Монгол-баглуурт (64-66/У-VI-1-7; У-VI-1-9) бүлгэмдэлд 100м² талбайд (7 –р бичиглэл) Сайрын хялгана (*Stipa glareosa* P.Smirn.), Орог тэсэг (*Eurotia ceratoides* (L.) C.A.Meу), Ахар навчит баглуур (*Anabasis brevifolia* C.A.Meу.) зонхилж, сонгиноос Таана буюу багалгар сонгино (*Allium polyrrhizum* Turcz. ex RgL.), Хөмөл (*Allium mongolicum* Rgl.), нэг талтанаас Говийн хэрээн нүд (*Asparagus gobicus* Ivanova.ex Grub.), чулуусаг алаг өвснөөс Цөлийн тайр (*Gypsophila desertorum* (Bge.) Fenzl.), Бууралдуу янгиц (*Ptilotrichum canescens* C.A. Meу.), Өтлүүн багдай (*Dontostemon senilis* Maxim.), Монгол шар далан (*Tugarinovia mongolica* Iljin.), сөөгөөс Шар хотир (*Zygophyllum xanthoxylon* (Bge.) Maxim.), Монгол догар (*Caryopteris mongolica* Bge.), Төв азийн лавай (*Asterothamnus centrali-asiaticus* Novopokr.), Говийн тост (*Brachanthemum gobicum* Krasch.), цөөн настнаас Ногоон хоног будаа (*Setaria viridis* (L.) P.B.), Бага хургалж (*Eragrostis minor* Host.), Гейманын бөөдий (*Aristida Heymannii* Rgl.), Умардын Огтонын сүүл (*Enneapogon borealis* (Griseb.) Honda.), Монгол хамхуул (*Corispermum mongolicum* Iljin), Өргөст бударгана (*Salsola pestifera* Nels.), шарилжнаас Агь (*Artemisia frigida* Willd.), Шаргал шарилж (*Artemisia rutifolia* Steph. ex Spreng.), Ямаан шарилж (*Artemisia scoparia* Waldst. et Kit.), Гмелиний тайжийн жинс (*Echinops Gmelinii* Turcz.) зэрэг 8 овог, 18 төрөл, 21 зүйл ургамал ургасан, 1м²-д 5 -7 орчим зүйл тааралдаж байв. Ургамлын бүрхэц 37.33%, түүнээс олшрогч цөөн наст ургамал 25.89%, нийт бүрхэцэд хайрга чулуу 11.4%, халцгай газар 12.0% байна.

Хүснэгт 17. Монгол -тэсэг, Монгол-баглуурт ургамлан нөмрөгийн төлөв байдлын бичиглэл

Монгол - тэсэг, Монгол- баглуурт	Үзүүлэлт							
	Ургамл ын бүрхэц, %	Зүйлийн тоо		Олшрогч ургамлы н бүрхэц, %	Халцга й газар, %	Хайрга, чулуу, %	Хагд, %	Ургац ц/га
		1 м ² талбайд,	1 м ² талбайд,					
Давталт 1	53	7	11	47	21	26	-	2.05
Давталт 2	34	5	10	29	12	54	-	2.04
Давталт 3	60	6	11	49	8	32	-	6.07
Давталт 4	19	5	10	17	16	65	-	6.27
Давталт 5	15	6	11	10	7	78	-	2.58
Давталт 6	36	6	16	21	16	48	-	-
Давталт 7	33	6	14	10	2	65	-	-
Давталт 8	38	6	18	18	16	46	-	-
Давталт 9	48	7	21	32	10	42	-	-
Дундаж	37.33	5-7	10 -21	25.89	12.0	50.67	-	3.802



Зураг 13. Ургамлын бичиглэл 7. Монгол -тэсэг, Монгол-баглуурт бүлгэмдэл
N 44°21'48.35''; E 104°03'43.01''; h 1154; 2024.08.25.

Монгол -тэсэг, Монгол-баглуурт бүлгэмдлийн га –ийн ургац 3.802 цн, үүнээс үетэн 0.558 цн, алаг өвс 0.54, баглуур 0.422 цн, тэсэг 2.282 цн байна.

Хүснэгт 18. Монгол -тэсэг, Монгол-баглуурт бүлгэмдлийн ургацын бичиглэл

Ургамлын бүлэг	Давталт					Бүгд	Дундаж	Ургац, ц/га
	1	2	3	4	5			
Үетэн	7.5	8.1	2.5	2.0	17.8	27.9	5.58	0.558
Алаг өвс	8.5	7.5	1.5	2.1	7.4	27.0	5.4	0.54
Баглуур	4.5	4.8	1.2	0.0	10.6	21.1	4.22	0.422
Тэсэг	0.0	0.0	55.5	58.6	0.0	114.1	22.82	2.282
Нийт	20.5	20.4	60.7	62.7	25.8	190.1	38.02	3.802

M8. Хармагт (238/H-IV-3-1) бүлгэмдлийн 100м² талбайд (**8-р бичиглэл**) Сибирь хармаг (*Nitraria sibirica* Pall.) зонхилж, сонгиноос Таана буюу багалгар сонгино (*Allium polyrrhizum* Turcz. ex RgL.), буурцагнаас Өргөст ортууз (*Oxytropis aciphylla* Ldb.), цөөн настнаас Ногоон хоног будаа (*Setaria viridis* (L.) P.B.), Бага хургалж (*Eragrostis minor* Host.), Гейманын бөөдий (*Aristida Heymannii* Rgl.), Монгол хамхуул (*Corispermum mongolicum* Iljin), Өргөст бударгана (*Salsola pestifera* Nels.), Зэлэн зангуу (*Tribulus terrestris* L.), Харлаг үмхий өвс (*Peganum nigellastrum* Bge.) зэрэг 6 овог, 9 төрөл, 9 зүйл ургамал ургасан, 1м²-д 4 -6 орчим зүйл тааралдаж байв. Ургамлын бүрхэц 57.22%, түүнээс олшрогч цөөн наст ургамал 23.33%, нийт бүрхэцэд хайрга чулуу 3.78%, халцгай газар 57.22% байна.

Хүснэгт 19. Хармагт ургамлан нөмрөгийн төлөв байдлын бичиглэл

Хармагт	Үзүүлэлт							
	Ургамлын бүрхэц, %	Зүйлийн тоо		Олшрогч ургамлын бүрхэц, %	Халцгай газар, %	Хайрга, чулуу, %	Хагд, %	Ургац/га
		1 м ² талбайд	1 м ² талбайд					
Давталт 1	15	5	9	8	69	16	-	3.25
Давталт 2	55	4	9	49	44	1	-	8.51
Давталт 3	50	6	9	32	50	0	-	3.88
Давталт 4	37	6	9	11	63	0	-	8.82
Давталт 5	44	5	9	24	56	0	-	6.13
Давталт 6	19	4	9	14	67	14	-	-
Давталт 7	74	4	9	19	26	0	-	-
Давталт 8	45	6	9	41	55	0	-	-
Давталт 9	12	4	9	12	85	3	-	-
Дундаж	62.0	4-6	9	23.33	57.22	3.78	-	6.18



Зураг 14. Ургамлын бичиглэл 8. Хармагт бүлгэмдэл
N 44°22'07.48"; E 104°03'57.89"; h 1113; 2024.06.24.

Хармагт бүлгэмдлийн га –ийн ургац 6.18 цн, үүнээс хармаг 3.78 цн, нэг настан 2.338 цн байна.

Хүснэгт 20. Хармагт бүлгэмдлийн ургацын бичиглэл

Ургамлын бүлэг	Давталт					Бүгд	Дундаж	Ургац, ц/га
	1	2	3	4	5			
Хармаг	0	70.5	0	75	43.5	189	37.8	3.78
Нэг настан	32.5	14.6	38.8	13.2	17.8	116.9	23.38	2.338
Нийт	32.5	85.1	38.8	88.2	61.3	305.9	61.18	6.18

М9. Монгол өвс-шавагт, Монгол өвс-баглуур-тост-хотирт (62-66а/У-VI-1-5; У-VI-1-9) бүлгэмдлийн 100м² талбайд (9 –р бичиглэл) Сайрын хялгана (*Stipa glareosa* P.Smirn.), Хуурайсаг шарилж (*Artemisia xerophytica* Krasch.), Сөөгөн сэдэргэнэ (*Convolvulus fruticosus* Pall.), Говийн тост (*Brachanthemum gobicum* Krasch.), Шар хотир (*Zygophyllum xanthoxylon* (Bge.) Maxim.) зонхилж, Нарийн навчит харгана (*Caragana stenophylla* Pojark.), сонгиноос Таана буюу багалгар сонгино (*Allium polyrrhizum* Turcz. ex Rgl.), Хөмөл (*Allium mongolicum* Rgl.), чулуусаг алаг өвснөөс Цөлийн тайр (*Gypsophila desertorum* (Bge.) Fenzl.), Бууралдуу янгиц (*Ptilotrichum canescens* С.А. Мей.), Хуурамч дэрвэгэр хависгана (*Scorzonera pseudodivaricata* Lipsch.), Монгол хависгана (*Scorzonera mongolica* Maxim.), буурцагтнаас Өргөст ортууз (*Oxytropis aciphylla* Ldb.), цөөн настнаас Бага хургалж (*Eragrostis minor* Host.), Ногоон хоног будаа (*Setaria viridis* (L.) P.B.), Гейманын бөөдий (*Aristida Heymannii* Rgl.), Умардын Огтонын сүүл (*Enneapogon borealis* (Griseb.) Honda.), Монгол хамхуул (*Corispermum mongolicum* Iljin), Өргөст бударгана (*Salsola pestifera* Nels.), Зэлэн зангуу (*Tribulus terrestris* L.), Харлаг үмхий өвс (*Peganum nigellastrum* Bge.) зэрэг 10 овог, 18 төрөл, 20 зүйл ургамал ургасан, 1м²-д 5 -8 орчим зүйл тааралдаж байв. Ургамлын бүрхэц 20.22%, түүнээс олшрогч цөөн наст ургамал 7.44%, нийт бүрхэцэд хайрга чулуу 35.0%, халцгай газар 44.78% байна.



Зураг 15. Ургамлын бичиглэл 9. Монгол өвс-шавагт, Монгол өвс-баглуур-тост-хотирт бүлгэмдэл N 44°22'22.78''; E 104°04'00.79''; h 1112; 2024.09.26.

Хүснэгт 21. Монгол өвс-шавагт, Монгол өвс-баглуур-тост-хотирт ургамлан нөмрөгийн мониторинг бичиглэл

Монгол өвс-шавагт, Монгол өвс-баглуур-тост-хотирт	Үзүүлэлт							
	Ургамлын бүрхэц, %	Зүйлийн тоо		Олшрогч ургамлын бүрхэц, %	Халцгай газар, %	Хайрга, чулуу, %	Хагд, %	Ургац ц/га
		1 м ² талбайд	1 м ² талбайд					
Давталт 1	41	6	20	10	43	16	-	1.15
Давталт 2	11	6	14	5	42	47	-	3.0
Давталт 3	26	7	18	13	52	22	-	1.81
Давталт 4	10	8	14	1	43	47	-	4.13
Давталт 5	22	5	10	4	54	24	-	1.62

Давталт 6	24	7	16	9	53	23	-	-
Давталт 7	10	5	8	9	47	43	-	-
Давталт 8	14	6	11	10	41	45	-	-
Давталт 9	24	7	15	6	28	48	-	-
Дундаж	20.22	5-8	8-20	7.44	44.78	35.0	-	2.342

Монгол өвс-шавагт, Монгол өвс-баглуур-тост-хотирт бүлгэмдлийн га –ийн ургац 2.342 цн, үүнээс үетэн 0.314 цн, нэг настан 0.908 цн, Шеваг-баглуур-тост-хотир 0.112 цн байна.

Хүснэгт 22. Монгол өвс-шавагт, Монгол өвс-баглуур-тост-хотирт бүлгэмдлийн хашааны доторх ургацын бичиглэл

Ургамлын бүлэг	Давталт					Бүгд	Дундаж	Ургац, ц/га
	1	2	3	4	5			
Үетэн	4.5	0.0	0.0	5.8	5.4	15.7	3.14	0.314
Нэг наст	7.0	10.0	9.6	8.0	10.8	45.4	9.08	0.908
Шеваг-баглуур-тост-хотир	0.0	20.0	8.5	27.5	0.0	56.0	11.2	0.112
Нийт	11.5	30.0	18.1	41.3	16.2	237.5	117.1	2.342

М 10. Монгол -шаваг-сэдэргэнэ-холимог сөөгт (145 а/ЦХ -I-1-4) бүгэмдэлд 100м² талбайд (10 –р бичиглэл) Сайрын хялгана (*Stipa glareosa* P.Smirn.), Говийн хялгана (*Stipa gobica* Roshev.), Хуурайсаг шарилж (*Artemisia xerophytica* Krasch.), Сөөгөн сэдэргэнэ (*Convolvulus fruticosus* Pall.), үетнээс Гялгар дэрс (*Achnatherum splendens* (Trin.) Nevski.), Дэрвээн хазаар өвс (*Cleistogenes squarrosa* (Trin.) Keng.), улалжаас Ширэг улалж (*Carex duriuscula* C.A.Mey.), нэг талтанаас Говийн хэрээн нүд (*Asparagus gobicus* Ivanova.ex Grub.), Таана буюу багалгар сонгино (*Allium polyrrhizum* Turcz. ex RgL.), Хөмөл (*Allium mongolicum* Rgl.), буурцагнаас Цагаан хунчир (*Astragalus galactites* Pall.), алаг өвснөөс Цөлийн тайр (*Gypsophila desertorum* (Bge.) Fenzl.), Бууралдуу янгиц (*Ptilotrichum canescens* C.A. Mey.), Хуурамч дэрвэгэр хависгана (*Scorzonera pseudodivaricata* Lipsch.), нэг настнаас Бага хургалж (*Eragrostis minor* Host.), Үслиг манан-хамхаг (*Bassia dasyphylla* (Fisch.et Mey.) Ktze.), Харлаг үмхий өвс (*Peganum nigellastrum* Bge.), Стефаны заан таваг (*Erodium Stephanianum* Willd.) зэрэг 11 овог, 15 төрөл, 17 зүйл ургамал ургасан, 1м²-д 6-8 орчим зүйл тааралдаж байв. Ургамлын бүрхэц 40.00%, түүнээс олшрогч цөөн наст ургамал 15.89%, нийт бүрхэцэд хайрга чулуу 20.33%, халцгай газар 39.67% байна.

Хүснэгт 23. Монгол -шаваг-сэдэргэнэ-холимог сөөгт ургамлан нөмрөгийн төлөв байдлын бичиглэл

Монгол - шеваг-сэдэргэнэ-холимог сөөгт	Үзүүлэлт							
	Ургамлын бүрхэц, %	Зүйлийн тоо		Олшрогч ургамлын бүрхэц, %	Халцгай газар, %	Хайрга, чулуу, %	Хагд, %	Урга ц/га
		1 м ² талбайд	1 м ² талбайд					
Давталт 1	28	7	10	14	47	25	-	2.95
Давталт 2	42	8	12	21	37	21	-	5.56
Давталт 3	28	6	13	14	47	25	-	3.19
Давталт 4	42	8	11	21	39	19	-	4.71
Давталт 5	50	6	17	25	39	11	-	3.0
Давталт 6	34	6	11	18	38	28	-	-
Давталт 7	46	7	15	6	44	10	-	-
Давталт 8	42	8	16	12	53	5	-	-
Давталт 9	48	6	14	12	13	39	-	-
Дундаж	40.00	6-10	10-17	15.89	39.67	20.33	-	3.882



Зураг 16. Ургамлын бичиглэл 10. Монгол-шаваг-сэдэргэнэ-холимог сөөгт бүлгэмдэл N 44°22'1.96''; E 104°03'3.346''; h 1122; 2024.09.26.

Монгол-шаваг-сэдэргэнэ-холимог сөөгт бүлгэмдлийн га –ийн ургац 3.882 цн, үүнээс шаваг-сэдэргэнэ-холимог сөөг 1.334 цн, Монгол өвс 0.972 цн, нэг настан 1.576 цн байна (хүснэгт 24).

Хүснэгт 24. Монгол-шаваг-сэдэргэнэ-холимог сөөгт бүлгэмдлийн ургацын бичиглэл

Ургамлын бүлэг	Давталт					Бүгд	Дундаж	Ургац, ц/га
	1	2	3	4	5			
шаваг-сэдэргэнэ-холимог сөөг	0.0	36.6	0.0	30.1	0.0	66.7	13.34	1.334
Монгол өвс	10.0	9.0	11.8	8.0	9.8	48.6	9.72	0.972
Нэг настан	19.5	10.0	20.1	9.0	20.2	78.8	15.76	1.576
Нийт	29.5	55.6	31.9	47.1	30.0	194.1	38.82	3.882

M11. Таана-бударгана, Монгол-баглуурт (148-149/ЦХ-I-1-7; ЦХ-I-1-8) цөлийн хээрийн 100м² талбайд (9 –р бичиглэл) Таана буюу багалгар сонгино (*Allium polyrrhizum* Turcz. ex RgL.), Хөмөл (*Allium mongolicum* Rgl.), Сайрын хялгана (*Stipa glareosa* P.Smirn.), Говийн хялгана (*Stipa gobica* Roshev.), Бор бударгана (*Salsola passerina* Bge.), Ахар навчит баглуур (*Anabasis brevifolia* C.A.Mey.) зонхилж, алаг өвснөөс Намхан гишүүнэ (*Rheum nanum* Sievers.), Цөлийн тайр (*Gypsophila desertorum* (Bge.) Fenzl.), Олон наст Багдай (*Dontostemon perennis* C.A.Mey.), Розовын хотир (*Zygophyllum Rosowii* Bge.), хуурамч дэрвэгэр хависгана (*Scorzonera pseudodivariata* Lipsch.), сөөгөөс Шар хотир (*Zygophyllum xanthoxylon* (Bge.) Maxim.), нэг настнаас Бага хургалж (*Eragrostis minor* Host.), Үслиг манан-хамхаг (*Bassia dasyphylla* (Fisch. et Mey.) Ktze.), Гейманын бөөдий (*Aristida Heymannii* Rgl.), Умардын Огтонын сүүл (*Enneapogon borealis* (Griseb.) Honda.), Монгол хамхуул (*Corispermum mongolicum* Iljin), Өргөст бударгана (*Salsola pestifera* Nels.), Зэлэн зангуу (*Tribulus terrestris* L.), Харлаг үмхий өвс (*Peganum nigellastrum* Bge.), Стефаны заан таваг (*Erodium Stephanianum* Willd.) зэрэг 9 овог, 18 төрөл, 20 зүйл ургамал ургасан, 1м²-д 6 -10 орчим зүйл тааралдаж байв. Ургамлын бүрхэц 42.22%, түүнээс олшрогч цөөн наст ургамал 28.67%, нийт бүрхцэд хайрга чулуу 34.33%, халцгай газар 23.44% байна.



Зураг 17. Ургамлын бичиглэл 11. Таана-бударгана, Монгол-баглуурт бүлгэмдэл N 44°21'52.55'' E 104°04'42.5''; h 1148; 2024.08.25.

Хүснэгт 25. Таана-бударгана, Монгол-баглуурт ургамлан нөмрөгийн төлөв байдлын бичиглэл

Таана-бударгана, Монгол-баглуурт	Үзүүлэлт							
	Ургамлын бүрхэц, %	Зүйлийн тоо		Олшрогч ургамлын бүрхэц, %	Халцгай газар, %	Хайрга, чулуу, %	Хагд, %	Ургац ц/га
	1 м ² талбайд	1 м ² талбайд	100 м ² талбайд					
Давталт 1	44	8	10	28	27	29	-	2.7
Давталт 2	46	8	10	32	33	21	-	3.46
Давталт 3	25	8	9	21	33	42	-	2.98
Давталт 4	34	8	9	30	17	49	-	3.6
Давталт 5	26	10	9	21	22	52	-	3.81
Давталт 6	58	9	10	36	24	18	-	-
Давталт 7	70	6	9	35	20	10	-	-
Давталт 8	28	10	10	11	21	51	-	-
Давталт 9	49	9	12	44	14	37	-	-
Дундаж	42.22	6-10	9-12 (20)	28.67	23.44	34.33	-	3.31

Таана-бударгана, Монгол-баглуурт бүлгэмдлийн га –ийн ургац 3.31 цн, үүнээс үетэн, таана 0.588 цн, алаг өвс 0.172, нэг настан 0.81 цн, баглуур, бударгана 1.74 цн байна.

Хүснэгт 26. Таана-бударгана, Монгол-баглуурт бүлгэмдлийн ургацын бичиглэл

Ургамлын бүлэг	Давталт					Бүгд	Дундаж	Ургац, ц/га
	1	2	3	4	5			
Үетэн, таана	3.5	10.6	5.2	4.3	5.8	29.4	5.88	0.588
Алаг өвс	3	2.5	1.5	1.6	0	8.6	1.72	0.172
Нэг настан	10.5	10.5	2.6	4.6	12.3	40.5	8.1	0.81
Баглуур, бударгана	10	11	20.5	25.5	20	87	17.4	1.74
Нийт	27	34.6	29.8	36	38.1	165.5	33.1	3.31

М12. Монгол-шаваг-сэдэргэнэт, холимог сөөгт (145-243/ЦХ-I-1-4; Н-V-3-1) бүлгэмдлийн 100м² талбайд (12 –р бичиглэл) Сайрын хялгана (*Stipa glareosa* P.Smirn.), Хуурайсаг шарилж (*Artemisia xerophytica* Krasch.) зонхилж, сонгиноос Таана буюу багалгар сонгино (*Allium polyrrhizum* Turcz. ex Rgl.), Хөмөл (*Allium mongolicum* Rgl.), улалжаас Ширэг улалж (*Carex duriuscula* C.A.Mey), алаг өвснөөс Намхан гишүүнэ (*Rheum nanum* Sievers.), Цөлийн тайр (*Gypsophila desertorum* (Bge.) Fenzl.), Хуурамч дэрвэгэр хависгана (*Scorzonera pseudodivariata* Lipsch.), холимог сөөгөөс Шар хотир (*Zygophyllum xanthoxylon* (Bge.) Maxim.), Сөөгөн сэдэргэнэ (*Convolvulus fruticosus* Pall.), Зүүнгарын улаанбударгана (*Reaumuria soongorica* (Pall.) Maxim.), Заг (*Haloxylon ammodendron* (C.A.Mey.) Bge.), буурцагтнаас Өргөст ортууз (*Oxytropis aciphylla* Ldb.), цөөн настнаас Гейманын бөөдий (*Aristida Heymannii* Rgl.), Honda.), Бага хургалж (*Eragrostis minor* Host.), Өргөст бударгана (*Salsola pestifera* Nels.), Стефаны заан таваг (*Erodium Stephanianum* Willd.), Зэлэн зангуу (*Tribulus terrestris* L.), Харлаг үмхий өвс (*Peganum nigellastrum* Bge.) Гмелиний тайжийн жинс (*Echinops Gmelinii* Turcz.) зэрэг 9 овог, 18 төрөл, 19 зүйл ургамал ургасан, 1м²-д 4 -8 орчим зүйл тааралдаж байв. Ургамлын бүрхэц 25.44%, түүнээс олшрогч цөөн наст ургамал 0.33%, нийт бүрхцэд хайрга чулуу 33.11%, халцгай газар 41.44% байна.

Хүснэгт 27. Монгол-шаваг-сэдэргэнэт, холимог сөөгт ургамлан нөмрөгийн төлөв байдлын бичиглэл

Монгол-шаваг-сэдэргэнэт, холимог сөөгт	Үзүүлэлт							Ургац ц/га
	Ургамлын бүрхэц, %	Зүйлийн тоо		Олшрогч ургамлын бүрхэц, %	Халцгай газар, %	Хайрга, чулуу, %	Хагд, %	
		1 м ² талбайд	1 м ² талбайд					
Давталт 1	81	4	0	19	0	19	-	8.45
Давталт 2	17	5	15	6	45	38	-	4.3
Давталт 3	29	8	19	23	46	25	-	3.54
Давталт 4	25	5	13	16	46	29	-	3.23
Давталт 5	26	6	17	10	36	38	-	1.97
Давталт 6	54	7	18	25	29	17	-	-
Давталт 7	32	8	11	25	19	49	-	-
Давталт 8	52	7	13	30	33	15	-	-
Давталт 9	47	7	15	25	45	8	-	-
Дундаж	41.56	4-8	10-19	17.78	35.33	24.33	-	4.292



Зураг 18. Ургамлын бичиглэл 12. Монгол-шаваг-сэдэргэнэт, холимог сөөгт бүлгэмдэл N 44°22'07.95''; E 104°04'50.49''; h 1117; 2024.08.25.

Монгол-шаваг-сэдэргэнэт, холимог сөөгт бүлгэмдлийн га –ийн ургац 4.292 цн, үүнээс үетэн, таана 0.854 цн, шаваг 0.742, нэг настан 1.302 цн, холимог сөөг 1.4 цн байна.

Хүснэгт 28. Монгол-шаваг-сэдэргэнэт, холимог сөөгт бүлгэмдлийн ургацын бичиглэл

Ургамлын бүлэг	Давталт					Бүгд	Дундаж	Ургац, ц/га
	1	2	3	4	5			
Үетэн, таана	0	15.1	8.6	10	9	42.7	8.54	0.854
Шаваг	0	12.8	12.2	12.1	0	37.1	7.42	0.742
Холимог сөөг	70	0	0	0	0	70	14	1.4
Нэг настан	14.5	15.1	14.6	10.2	10.7	65.1	13.02	1.302
Нийт	84.5	43	35.4	32.3	19.7	214.9	42.98	4.292

2.3. Ургамлын аймаг ба ургамлын зүйлийн жагсаалт

Статус: Монголд байгаа завсарын унаган ургамал. **Биологийн онцлог:** 60 см –ээс хэтрэхгүй өндөр ургадаг, боровтор юмуу цайбар ногоон, хааяа шаравтар холтостой, сууриаасаа ихэд салаалсан ургамал. Навчис дэвүүрэрхүү, навчинцар нарийн юлдэрхүү хэлбэртэй, шовх оройтой, цэцэг шар, далбаа завь, сэлүүрээс бүтсэн бойтгорхуу хэлбэртэй, сэлүүр богинохон, цэцгийн шилбэ үен дээрээ голдуу жижигхэн, хос, унамтгай дагавар навчтай. **Амьдралын хэлбэр:** Сөөглөг ургамал. **Монгол дахь тархалт:** Ханг., Хянг., Дорн.-Монг., Дорн. говь., Ургах орчин: Элсэрхэг хээр, уул толгодын чулуурхаг шавранцар хажуугаар ургана. **Ашигт чанар:** Бог мал нэг настай мөчир, зөөлөн үзүүрийг нь жилийн турш сайн, өвөл арай бага иддэг. Цэцгийг ямаа идэж таргална. Тэмээ жилийн турш маш сайн иднэ.



Бүрхүүл үрт ургамлын хүрээ (*Angiospermae*)
Хос талт үрт ургамлын анги (*Dicotyledonae*)
Leguminosae Juss. - Буурцагтаны овог
Харганын төрөл (*Caragana* Lam.)
Зүйл: *Caragana korshinskii* Kom.- Коржинскийн харгана
Статус: Монголд байгаа завсарын унаган ургамал. **Биологийн онцлог:** Алтлаг шар холтостой, 1,5-3 м хүртэл өндөр иштэй, өдлөг нийлмэл навчтай, навчинцар 4-8 хос, шөвгөрдүү юмуу мохоовтор оройтой, цайвар саарал өнгөгтэй, бараг үл мэдэгдэм судалтай, бойтгорхуу шар цэцэгтэй, буурцаг гонзгойвтор юмуу юлдэрхүү. **Амьдралын хэлбэр:** Сөөглөг ургамал. **Монгол дахь тархалт:** Дорн. говь., Говь-Алт. **Ургах орчин:** Уулын хайрга, чулуутай хормой, бэсрэг уулс, толгодын хажуу, элсэрхэг хээр, элсэн дунд ургана. **Ашигт чанар:** Тэмээ сайн, ямаа, хонь дунд зэрэг иддэг.



Бүрхүүл үрт ургамлын хүрээ (*Angiospermae*)
Хос талт үрт ургамлын анги (*Dicotyledonae*)
Leguminosae Juss. - Буурцагтаны овог
Хунчирын төрөл (*Astragalus* L.)
Зүйл: *Astragalus monophyllus* Vge.-Ганцнавчит хунчир
Статус: Монголд байгаа завсарын унаган ургамал.
Биологийн онцлог: 5 см хүртэл өндөр ургадаг, ишгүй, модлог голлосон үндэстэй, үндэс орчимдоо байрладаг ганц навчтай, хааяа анхны навч гурвалсан, өргөн зуувгар, ширүүн налархай үсэрхэг, цэцэг бойтгорхуу, цагаан, буурцаг гонзгойдуу зуувгар, ноосорхог сэгсгэр үсэрхэг. **Амьдралын хэлбэр:** Олон наст өвслөг ургамал. **Монгол дахь тархалт:** Хөвс., Хэнт., Ханг., Монг.-Даг., Монг.-Алт., Дорн. говь., **Өмнөговь дахь тархалт:** Даланзадгад, Цогт-Овоо, Ханбогдын Номгон уул, Булан сухайт. **Ургах орчин:** Үйрмэг хайрга шавартай цөлийн хээр, элс хайргатай дэнж, говийн хөндийн хавтгай ёроолоор ургана. **Ашигт чанар:** Бог мал ногоон үед нь дунд зэрэг иддэг.

МОНГОЛД БАЙГАА ЗАВСАРЫН УНАГАН (СУБЭНДЕМИК) УРГАМАЛ

Zygophyllaceae R. Br. -Хотирын овог



Бүрхүүл үрт ургамлын хүрээ (*Angiospermae*)
Хос талт үрт ургамлын анги (*Dicotyledonae*)
Zygophyllaceae R. Br. -Хотирын овог
Үмхий өвсний төрөл (*Peganum* L.)
Зүйл: *Peganum nigellastrum* Bge. -Харлаг үмхий өвс
Статус: Монголд байгаа завсарын унаган ургамал.
Биологийн онцлог: 10-20 см өндөр, цөөн салаархаг, навчис хошоод юмуу гурвантаа сарвуулаг цуулбар, хурж салбантай, цэцэг цагаан ганц нэг, цоморлиг 5-7 шугаман салбанцартай.
Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал.
Монгол дахь тархалт: Дунд Халх., Дорн. Монг., Их н., Олон н., Дорн. говь., Говь-Алт., Алаш. **Ургах орчин:** Элсэрхэг цөл, цөлөрхөг хээрээр ургана. **Ашигт чанар:** Ногоон үед нь мал идэхгүй, өвөл адуу, тэмээ, бог мал тааруу иддэг. Газар дээрх биеийг Монгол уламжлалт эмнэлэгт хэрэглэнэ.

Umbelliferae Juss. - Шүхэртэний овог



Бүрхүүл үрт ургамлын хүрээ (*Angiospermae*)
Хос талт үрт ургамлын анги (*Dicotyledonae*)
Umbelliferae Juss. - Шүхэртэний овог
Хаврагын төрөл (*Ferula* L.)
Зүйл: *Ferula Bungeana* Kitag. - Бүнгийн хавраг
Статус: Монголд байгаа завсарын унаган ургамал.
Биологийн онцлог: Голлосон том махлаг үндэстэй, 15-30 см өндөр ургадаг дэрвэгэр салаатай, үндэс орчмын навчис хатуу, илтэс нь гурвалжиндуу, гурвантаа цуулбар өдлөг салбантай, нийлмэл шүхэр баг цэцэгтэй. **Амьдралын хэлбэр:** Олон наст өвслөг ургамал. **Тархалт:** Дунд. Халх., Дорн-Монг., Их н., Олон н., Дорн. говь., Говь-Алт., Алаш., **Ургах орчин:** Элсэрхэг хайргархаг цөлжүү бэл хормой, байц хаданд, элсэрхэг хээрт ургана.
Ашигт чанар: Үндэсийг Монгол уламжлалт эмнэлэгт хэрэглэнэ

Labiaceae Lindl.- Уруул цэцэгтэний овог



Бүрхүүл үрт ургамлын хүрээ (*Angiospermae*)
Хос талт үрт ургамлын анги (*Dicotyledonae*)
Уруул цэцэгтэний овог (*Labiaceae* Lindl.)
Ангалзуурын төрөл (*Lagochilus* Bge.)
Зүйл: *Lagochilus ilicifolius* Bge. – Ямаан ангалзуур
Статус: Монголд байгаа завсарын унаган ургамал.
Биологийн онцлог: Модожсон хатуу үндэстэй, хатуу дэрвэгэр навчтай, навчны үзүүр, цоморлигийн шүд сийрэгдүү шөвгөр өргөстэй, заримдаг сөөгөнцөр. Цэцэг 2 уруултай, дэлбэ цагаан юмуу шаргал.
Амьдралын хэлбэр: Заримдаг сөөгөнцөр ургамал.
Монгол дахь тархалт: Ханг., Монг.-Алт., Дунд. Халх, Их н., Олон н., Дорн. говь, Говь Алт., Алт. өвөр., Алаш.
Ургах орчин: Элсэрхэг, хайргархаг цөлөрхөг хээр, хад чулуутай хажуу, хайргархаг дэнж, сайрын хөвөө, оёорт ургана.
Ашигт чанар: Зун намар бог мал сайн, адуу бага зэрэг, хавар тэмээ, бог мал дунд зэрэг иддэг. Газар дээрх биеийг Монгол уламжлалт эмнэлэгт хэрэглэнэ.

МОНГОЛД БАЙГАА ЗАВСАРЫН УНАГАН (СУБЭНДЕМИК) УРГАМАЛ

Asteraceae Dumort. -Голгэсэртэний овог



Хүрээ: Бүрхүүл үрт ургамлын (*Angiospermae*)
Анги: Хос талт үрт ургамлын (*Dicotyledonae*)
Овог: Голгэсэртэний (*Asteraceae Dumort.*)
Төрөл: Шарилж (*Artemisia L.*)
Зүйл: *Artemisia xerophytica* Krasch.-Хуурайсаг шарилж
Цагаан шавга
Статус: Элбэг
Биологийн онцлог: 30-40 см өндөр ургадаг, модожсон, олон салаалсан найлзууртай, навч гурвантаа юмуу хошоод гурвантаа цуулбар, сагс 4-5 мм өргөн, сийрэг пирамид залаанд нэгддэг, дэлбэ ба цэцгийн суудал өтгөн торгомсог үслэгтэй ногоон саарал ургамал. Амьдралын хэлбэр: Заримдаг сөөгөнцөр. **Тархалт:** Ховд., Монг. Алт., Дунд. Халх., Их н., Олон н., Дор.говь., Говь – Алт., Алт. –өвөр., Алаш. Ургах орчин: Элсэрхэг үйрмэг чулуутай цөлд ургана. Ашигт чанар: Бог мал, тэмээ зун сайн идэж тарга авдаг.











Хүрээ: Бүрхүүл үрт ургамлын (*Angiospermae*)
Анги: Хос талт үрт ургамлын (*Dicotyledonae*)
Овог: Голгэсэртэний (*Asteraceae Dumort.*)
Төрөл: Шарилж (*Artemisia L.*)
Зүйл: *Artemisia sphaerocephala* Krasch.-Бөндгөр шарилж
Статус: Элбэг
Биологийн онцлог: Иш саваархуу, голдуу бараг угаасаа салаалдаг, доод хэсэгтээ модожсон, иш ба мөчир шаравтар цайвар, үндэсний систем хүчирхэг, модожсон, нягт дэгнүүл үүсгэдэг, навч хошоод гурвантаа өдлөг цуулбар, нүцгэн, урт бариултай, сагс өргөн зууван, бөхөгөр шилбэтэй. **Амьдралын хэлбэр:** Заримдаг сөөгөнцөр. **Тархалт:** Их н., Дорн. говь., Говь – Алт., Алт. өвөр., Алаш. Гурвантэс. Ашигт чанар: **Голдуу тэмээ жилийн дөрвөн улиралд дунд зэрэг иддэг.** Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: **Чулуурхаг цайвар бор хөрсөнд.**



Хүрээ: Бүрхүүл үрт ургамлын (*Angiospermae*)
Анги: Хос талт үрт ургамлын (*Dicotyledonae*)
Овог: Голгэсэртэний (*Asteraceae Dumort.*)
Төрөл: Хависсгана (*Scorzonera L.*)
Зүйл: *Scorzonera capito* Maxim.-Данхар хависгана
Статус: Монголд байгаа завсарын унаган ургамал
Биологийн онцлог: 3-10 см хүртэл өндөр ургадаг, цөөн гонзгой навчтай, үндэс орчмын навч өргөн юлдэнээс зууван хэлбэртэй, бүхэл ургамал орооцолдсон ноосорхог үсэрхэг, сагс нэг, хааяа 2, шар хэлэрхүү цэцэгтэй.
Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал.
Тархалт: Дунд. Халх., Олон н., Дор.говь., Говь – Алт., Алт.-өвөр., Алаш., Өмнөговь дахь тархац: Ханбогд сумын Номгон уул,
Ургах орчин: Уул толгодын хад, үйрмэг чулуутай ба чулуурхаг хажууд ургана. Ашигт чанар: Хонь, ямаа, янгир намар, өвөл сайн иднэ..
Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: **Чулуурхаг бор хөрсөнд.**

Хавсралт 3. Мандал Ресурс ХХК-ын талбайд бүртгэсэн элбэг зүйл ургамал, 2024




Gramineae Juss. - Үетэний овог	
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>) Нэг талт үрт ургамлын анги (<i>Monocotyledonae</i>) <i>Gramineae</i> Juss. - Үетэний овог Дэрсний төрөл (<i>Achnatherum</i> P. B.) Зүйл: <i>Achnatherum splendens</i> (Trin.) Nevski-Гялгар дэрс Статус: Элбэг Биологийн онцлог: Нягт том дэгнүүлтэй, иш 3 үетэй, 50-250 см эгц шулуун, навч шугамархуу, доод гадаргуу нь гөлгөр, хэлхэн 1-7 мм урт, сийрэгдүү саглагар залаа баг цэцэгтэй, түрүүхэйдээ нэг цэцэгтэй, цэцгийн доод хайрс 5-11 мм урт сортой. Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал. Монгол дахь тархалт: Ургамал газар зүйн бүх тойрогт. Ургах орчин: Марзлаг элс, хужирлаг тойром, гол горхи, булаг шандны хөвөө, хотос цайдамд ургана. Ашигт чанар: Жилийн дөрвөн улиралд таван хошуу мал, ялангуяа адуу, үхэр, тэмээ маш сайн иддэг.</p>
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>) Нэг талт үрт ургамлын анги (<i>Monocotyledonae</i>) <i>Gramineae</i> Juss. - Үетэний овог Хялганын төрөл (<i>Stipa</i> L.) Зүйл: <i>Stipa glareosa</i> P.Smirn.-Сайрын хялгана Статус: Элбэг ургамал. Биологийн онцлог: 10-15 см өндөр иштэй, сахлаг үндэстэй, жижиг шигүү бутар ургадаг, хуурайсаг ургамал. Навчны илтэсний ар нь сийрэг өргөсөнцөрийн улмаас ширүүн, шивээний сор 4,5-7 см урт, нэг нугархай, доод ба дээд нугархай нь бүхэлдээ 5 мм өдөрхүү урт үстэй. Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал. Монгол дахь тархалт: Ханг., Ховд., Монг.-Алт., Дунд. Халх., Их.н., Олон н., Дорн. говь., Говь-Алт., Алт. өвөр., Зүүнгар., Алаш. Ургах орчин: Хайргархаг ба элсэрхэг тэгш тал, уул толгодын чулуурхаг хажуу, бэл хормойгоор ургана. Ашигт чанар: Жилийн дөрвөн улиралд таван хошуу мал маш сайн иднэ.</p>
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>) Нэг талт үрт ургамлын анги (<i>Monocotyledonae</i>) <i>Gramineae</i> Juss. - Үетэний овог Хазаар өвсний төрөл (<i>Cleistogenes</i> Keng.) Зүйл: <i>Cleistogenes squarrosa</i> (Trin.)Keng.-Дэрвээн хазаар өвс Статус: Элбэг Биологийн онцлог: Элсэн дугтуй бүхий сахлаг үндэстэй, жижиг сийрэг бутар ургадаг, иш 5-10 үетэй, 15-30 см өндөр, навч хавтгай шугаман, юлдэрхүү, ширүүн, залаа баг цэцэг нь 5-7 см, 3-10 мм өргөн, түрүүхэй 2-4 цэцэгтэй, бор ногоон өнгөтэй. Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал. Монгол дахь тархалт: Хэнт., Ханг., Монг.-Даг., Хянг., Ховд., Монг. Алт., Дунд. Халх., Дорн.Монг., Их н., Олон н., Дорн. говь., Говь-Алт. Ургах орчин: Уулын чулуурхайг хайргархаг хажуу, хээр талаар ургана. Ашигт чанар: Тэмээнээс бусад мал зундаа сайн иддэг.</p>
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>) Нэг талт үрт ургамлын анги (<i>Monocotyledonae</i>) <i>Gramineae</i> Juss. - Үетэний овог Ерхөгийн төрөл (<i>Agropyron</i> Gaertn.) Зүйл: <i>Agropyron cristatum</i> (L.) P.B.-Саман ерхөг Статус: Элбэг Биологийн онцлог: Сахлаг үндэсний системтэй, иш 25-75 см өндөр, сийрэг дэгнүүлтэй, ишиндээ 2-3 үетэй, навчис цөөн, нарийн шугаман, ихэвчлэн ишний уг орчимд байрладаг, навчны өвөр тал сийрэг зөөлөн үстэй, ардаа үсгүй, сам хэлбэрийн нийлмэл түрүү баг цэцэгтэй, нэг түрүүхэйдээ 3-7 цэцэгтэй, түрүү, түрүүхэй, цэцгийн доод хайрс ноосорхог үсжилттэй, амуу жимстэй. Монгол дахь тархалт: Хөвс., Хэнт., Ханг., Монг. Даг., Хянг., Ховд., Монг. Алт., Дунд. Халх., Дорн.Монг., Их.н., Олон.н., Дорн говь., Говь-Алт.,</p>

	<p>Зүүнгар., Алт.Өвөр. Ургах орчин:Тэгш тал, хуурай нуга, элс, чулуурхаг хажуу, эргийн хайрга, байц хадны ёроолоор ургана. Ашигт чанар: Адуу, бог мал хавар маш сайн, бүх төрлийн мал бусад улиралд сайн иднэ.</p>
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>) Нэг талт үрт ургамлын анги (<i>Monocotyledonae</i>) <i>Gramineae</i> Juss. -Үетэний овог Хургалжийн төрөл (<i>Eragrostis</i> Wolf.) Зүйл: <i>Eragrostis minor</i> Host-Бага хургалж Статус: Элбэг Биологийн онцлог: Сахлаг үндэстэй, газар налсан 10-30 см өндөр, нумраа юмуу өндиймөл иштэй, навч хавтгай шугаман, ирмэгээрээ дагасан урт сормостой, залаа баг цэцэг нь сийрэг, саравгар, түрүүхэй 5-15 цэцэгтэй, ногоон өнгөтэй. Амьдралын хэлбэр: Нэг наст өвслөг ургамал. Монгол дахь тархалт: Хөвс., Хэнт., Ханг., Монг. Даг., Ховд., Монг. Алт., Дунд. Халх., Дорн.Монг., Их н., Олон н., Дорн. говь., Говь-Алт., Алт.өвөр., Зүүнгар., Алаш. Өмнөговь дахь тархалт: Их уул, Ургах орчин: Уулын чулуурхайг хайргархаг хажууд ургана. Ашигт чанар: Тэмээ зун, намар дунд, хавар өвөлдөө бага, бусад мал зундаа дунд иддэг.</p>
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>) Нэг талт үрт ургамлын анги (<i>Monocotyledonae</i>) <i>Gramineae</i> Juss. -Үетэний овог Оготнын сүүлийн төрөл (<i>Enneapogon</i> Desv. ex P.B.) Зүйл: <i>Enneapogon borealis</i> (Griseb). Honda.-Умардын огтонын сүүл Статус: Элбэг Биологийн онцлог: Жижигхэн, 5-15 см өндөр, бут үүсгэн ургадаг, навч хуйларсан хатуу, түрүүрхүү залаа баг цэцэг нягт, өтгөн, зууван хэлбэртэй, саарал өнгөтэй, түрүүхэй нэг цэцэгтэй, цэцгийн доод хайрс үзүүртээ 9 сортой. Тэдгээр нь хайрснаасаа 1,5-2 дахин урт. Амьдралын хэлбэр: Нэг наст өвслөг ургамал. Монгол дахь тархалт: Ховд., Монг.Алт., Дунд. Халх., Дорн. Монг., Их.н., Дорн.говь., Говь-Алт., Алт-өвөр., Алаш. Ургах орчин: Бутармаг чулуут цөл, уул толгодын хормой, элсэрхэг, хайргархаг ба ус урсдаг сайрын оёор, эргийн хайрганд ургана. Ашигт чанар: Үхрээс бусад мал зун сайн, өвөл дунд зэрэг иднэ.</p>
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>) Нэг талт үрт ургамлын анги (<i>Monocotyledonae</i>) <i>Gramineae</i> Juss. -Үетэний овог Бөөдийн төрөл (<i>Aristida</i> L.) Зүйл: <i>Aristida Heymannii</i> Rgl.-Гейманын бөөдий Статус: Элбэг Биологийн онцлог: 10-20 см өндөр бут үүсгэн ургадаг, сахлаг үндэстэй, шугаман навчтай, нарийхан сийрэг залаа баг цэцэгтэй, түрүүхий нарийн шугамархуу, 1,5 см урт 2 салаа саравгар сортой. Амьдралын хэлбэр: Нэг наст өвслөг ургамал. Монгол дахь тархалт: Их н, Олон н., Дорн. говь., Говь-Алт., Алт-өвөр., Алаш. Ургах орчин: Уул гүвээний үйрмэг чулуут ба элсэрхэг хажуу, хормой, элсэрхэг хайргархаг цөлд ургана. Ашигт чанар: Бог мал, тэмээ зун, намар, өвөлдөө сайн иднэ.</p>
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>) Нэг талт үрт ургамлын анги (<i>Monocotyledonae</i>) <i>Gramineae</i> Juss. -Үетэний овог Булган сүүлийн төрөл (<i>Chloris</i> Sw.) Зүйл: <i>Chloris virgata</i> Sw.-Саваан булган сүүл Статус: Элбэг Биологийн онцлог: Өндиймөл иштэй, 10-20 см өндөр ургадаг ургамал. Навч шугаман юлдэрхүү, хавтгай түнтгэр угларгатай, баг цэцэг өтгөн, сарвуулаг, 4 см хүртэл урт, 4-10 түрүүрхүү салаа мөчиртэй. Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал. Монгол дахь тархалт: Дунд. Халх., Дорн. Монг., Их.н., Олон н., Дорн.говь., Говь-Алт., Алт-өвөр., Алаш.</p>

	<p>Өмнөговь дахь тархалт: Онгийн голын хөндий. Ургах орчин: Элсэрхэг хайргархаг эрэг ургана. Ашигт чанар: Зун, хавар бог мал сайн, намар тааруухан иддэг.</p>
<p>Cyperaceae Juss. – Улалжийн овог</p>	
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>) Нэг талт үрт ургамлын анги (<i>Monocotyledonae</i>) <i>Cyperaceae</i> Juss. - Улалжийн овог Улалжийн төрөл (<i>Carex</i> L.) Зүйл: <i>Carex duriuscula</i> С.А.Мей.-Ширэг улалж Статус: Элбэг Биологийн онцлог: Урт нарийхан үндэслэг иштэй, өтгөн багц найлзуур үсгэдэг, түрүүнцэр нарийн, уутанцар өргөн өндгөрхүү, шадар хайрс цайвар хүрэн. Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал. Монгол дахь тархалт: Хөвс., Хэнт, Ханг., Монг.-Даг., Ховд., Монг.-Алт., Дунд. Халх., Дорн. Монг., Их н., Олон н., Дорн.говь., Говь –Алт. Ургах орчин: Элсэрхэг газар, хээржүү хажууд ургана. Ашигт чанар: Зун, намар адуу, бог мал маш сайн, үхэр сайн, тэмээ дунд зэрэг иддэг. Хөрс хучигч ургамал.</p>
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>) Нэг талт үрт ургамлын анги (<i>Monocotyledonae</i>) <i>Cyperaceae</i> Juss. - Улалжийн овог Улалжийн төрөл (<i>Carex</i> L.) Зүйл: <i>Carex stenophylloides</i> V.Krecz.-Утсан навчит улалж Статус: Элбэг Биологийн онцлог: Урт нарийхан үндэслэг иштэй, навчис нарийхан, өтгөн багц найлзуур үсгэдэг, түрүүнцэр нарийн, уутанцар өргөн өндгөрхүү бөгөөд ажжим нарийссан шонтонтой, судалтай, шадар хайрс бор хүрэн. Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал. Монгол дахь тархалт: Монг.-Алт., Дунд. Халх., Дорн. Монг., Их н., Олон н., Дорн.говь., Говь –Алт., Алт-Өвөр., Алаш. Ургах орчин: элсэрхэг цөл, уулын хээр, нам дор газрын марзлаг нугад ургана. Ашигт чанар: Зун, өвөл бог мал сайн, адуу дунд зэрэг иддэг.</p>
<p>Polygonaceae Juss. – Тарнын овог</p>	
	<p>Хүрээ: Бүрхүүл үрт ургамлын (<i>Angiospermae</i>) Анги: Хос талт үрт ургамлын (<i>Dicotyledonae</i>) <i>Polygonaceae</i> Juss. – Тарнын овог Эмгэн шилбийн төрөл (<i>Atraphaxis</i> L.) Зүйл: <i>Atraphaxis frutescens</i> (L.) К.Коч-Сөөгөн эмгэн шилбэ Статус: Элбэг Биологийн онцлог: Мөчрийн үзүүр өргөс хатгуургүй баг цэцэг юмуу навчаар төгсдөг, 0,5-1,5 м өндөр ургадаг, навчис нарийхан юлдэрхүүгээс гонзгой, тонгоруу өндгөрхүү, цувраа, хатуу арьслаг, цэцэг 5 саланги ягаан дэлбэтэй, гурван талт самранцар жимстэй. Амьдралын хэлбэр: Сөөглөг ургамал. Тархалт: Ханг., Хянг., Ховд., Монг. –Алт., Дорн. монг., Говь-Алт., Алаш. Ургах орчин: Элсэрхэг хээр, сайрын зах, оёор, хайрга, уулын чулуут хажууд ургана. Ашигт чанар: Протейн ихтэй тул зун, намартаа тэмээ маш сайн, хонь, ямаа дунд зэрэг иддэг.</p>
	<p>Хүрээ: Бүрхүүл үрт ургамлын (<i>Angiospermae</i>) Анги: Хос талт үрт ургамлын (<i>Dicotyledonae</i>) <i>Polygonaceae</i> Juss. - Тарнын овог Гишүүний төрөл (<i>Rheum</i> L.) Зүйл: <i>Rheum nanum</i> Sievers.-Намхан гишүүнэ Статус: Элбэг Биологийн онцлог: Том бүдүүн үндэстэй, иш навчгүй, улаан хүрэн бамбай баг цэцэгтэй, үндэс орчмын навч дэвсээ, дугариг, богино бариултай, тод гүргэр судалтай, гурвалжин самранцар жимстэй. Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал. Тархалт: Монг. –Алт., Их н., Олон н., Дор. Говь., Зүүнгар., Алт. Өвөр., Алаш. Ургах орчин: Хотос хөндийн элс хайрган хөрстэй ёроол, дов толгодын хайргархаг чулуурхаг хажуу, бэл хормой, асга, байц цохионд ургана. Ашигт чанар: Үндэсийг мазаалай иддэг, үндсэндээ цардуул ихтэй тул</p>

	<p>орон нутагт гурил хийж хүнсэнд хэрэглэдэг. Үндэсийг монгол уламжлалт эмнэлэгт хэрэглэнэ.</p>
<p>Chenopodiaceae Vent. - Луулийн овог</p>	
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (Angiospermae) Хос талт үрт ургамлын анги (Dicotyledonae) Chenopodiaceae Vent. - Луулийн овог Цулихирын төрөл (Agriophyllum M. B.) Зүйл: Agriophyllum pungens (Vahl) Link ex.A. Dietr.-Шивүүрт цулихир Статус: Элбэг ургамал. Биологийн онцлог: Хатуу өргөс хатгууртай, юлдэрхүү, үзүүртээ хурц өргөслөг навчтай, навч нь 3 тод тууш судалтай, толгойрхуу баг цэцэг навчны өвөрт байрладаг, цэцгийн дагавар шөвгөрхүү өргөстэй, шадар эрхтэн 1-3 хальсархаг навчинцараас тогтдог элсний ургамал. Амьдралын хэлбэр: Нэг наст өвслөг ургамал. Тархалт: Ховд., Дунд. Халх., Дорн. Монг., Их н., Олон н., Дорн. говь., Говь-Алт., Алт.-өвөр., Алаш. Ургах орчин: Тогтворгүй болон нүүнги элсэн манхан, сэрвэн, элсэн довцог, сондуулд ургана. Ашигт чанар: Тэмээ 4 улирлын турш сайн иддэг, үр нь уураг, эслэг, тослог ихтэй тул Монголчууд эртнээс тэжээллэг чанартай, сульхирын гурил хийж хүнсэнд хэрэглэдэг</p>
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (Angiospermae) Хос талт үрт ургамлын анги (Dicotyledonae) Chenopodiaceae Vent. - Луулийн овог Шорнойн төрөл (Atriplex L.) Зүйл: Atriplex sibirica L.-Сибирь шорной Статус: Элбэг Биологийн онцлог: 15-60 см өндөр, эгц босоо юмуу дэлхээ иштэй, саарал ногоон нэг наст ургамал. Навчис гурвалжин юмуу гурвалжин өндгөрхүү, жигд биш ухмал, том том шүдлэг захтай, навчны суганд бөөгнөрсөн, богинохон түрүүрхүү баг цэцэгтэй. Үр жимс дагавар цэцгэндээ ороолттой. Амьдралын хэлбэр: Нэг наст өвслөг ургамал. Тархалт: Хэнт., Ханг., Монг.-Даг., Монг. Алт., Дунд. Халх, Ховд., Дорн.-Монг., Их н., Олон н., Дорн. Говь., Говь Алт., Дорн. Говь., Зүүнгар., Алт. Өвөр., Алаш. Ургах орчин: Шавартай болон элсэрхэг хужир марцтай хотгор, тойром бүрд, сайр садрага, дэрстэй хөндий дагаж ургана. Ашигт чанар: Ногоон үед нь тэмээ тааруу иддэг. Ногоон шорной идсэн тэмээний гэдэс дүүрч их идвэл үхэх аюултай.</p>
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (Angiospermae) Хос талт үрт ургамлын анги (Dicotyledonae) Chenopodiaceae Vent. - Луулийн овог Манан хамхагын төрөл (Bassia All.) Зүйл: Bassia dasyphylla (Fisch.et Mey.) Ktze.- Үслиг манан-хамхаг Биологийн онцлог: Үзүүрхүү салаалсан дөрвөг дэргийн салаалсан бөөрөнхий бут үүсгэдэг. 8-50 см өндөр иштэй, туждаа цайвар үсээр хучигдмал. Навчис мухар оройтой, махлаг, шулуун булархуу. Шадар эрхтний илтэс үслэг, жимслэхээрээ таван хошуу шиг шовх сэртэнтэй. Амьдралын хэлбэр: Нэг наст ургамал. Тархалт: Монг.-Даг., Хянг., Ховд., Монг. Алт., Дунд, Олон н., Их н., Дорн говь., Говь Алт., Зүүнгар, Алт.өвөр, Алаш.. Ургах орчин: Шорвогжсон элс, элсэн хурдас, элсэрхэг ба хайргархаг бэл хормой, элсэрхэг хээр, тэгш талд ургана. Ашигт чанар:Тэмээ хавар зун тааруу иддэг.</p>
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (Angiospermae) Хос талт үрт ургамлын анги (Dicotyledonae) Chenopodiaceae Vent. - Луулийн овог Тэсэгийн төрөл (Eurotia Adans.) Зүйл: Eurotia ceratoides (L.) C.A.Mey-Орог тэсэг Статус: Элбэг Биологийн онцлог: Сууриасаа эхрлэн өтгөн салаалсан, нэг наст найлзуур өтгөн эсгийлэг үсээр хужигдсан, навчис сууриадаа шаантгархуу юмуу дугуй, юлдэрхүү хэлбэртэй, мөчрийн үзүүрт байрлах түрүүрхүү баг цэцэг нь сэгсгэр урт зөөлөн цайвар үслэгтэй, үр жимс урт багц үстэй. Амьдралын хэлбэр: Заримдаг сөөг. Тархалт: Хөвс., Ханг., Монг.-Даг., Ховд., Монг.-Алт., Дунд.</p>

	<p>Халх., Их н., Олон н., Дорн. говь., Говь-Алт., Алт.-өвөр., Алаш. Ургах орчин: Элс хайргархаг тэгш талаар ургадаг сөөгөрхөг цөлийн шинж бүрдүүлэгч ургамал. Ашигт чанар: Жилийн дөрвөн улирлын турш бүх төрлийн мал иддэг, сайн чанартай тэжээлийн ургамал.</p>
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>) Хос талт үрт ургамлын анги (<i>Dicotyledonae</i>) <i>Chenopodiaceae</i> Vent. - Луулийн овог Баглуурын төрөл (<i>Anabasis</i> L.) Зүйл: <i>Anabasis brevifolia</i> С.А.Мей.-Ахар навчит баглуур Статус: Элбэг Биологийн онцлог: Модожсон, дээд хэсгээрээ салаалсан иштэй, бутархуу жижигхэн дэгнүүл үүсгэдэг ургамал, бүх навчис булцгар бөөрөхий бөгөөд унамтгай, өргөс хатгууртай, ишний дээд ба дунд хэсгийн навчис 100 мм хүртэл урт, доош нугарсан, хамгийн доод навчис хайрсархуу, ишээдээ налсан, цэцэг нь навчнб өвөрт 1-3-араа байрласан, шадар эрхтэн жимслэх үедээ хурц улаан шар өнгийн далбантай болдог. Амьдралын хэлбэр: Заримдаг сөөгөнцөр. Тархалт: Ховд., Монг.-Алт., Их н., Олон н., Дорн.-Говь., Говь-Алт., Зүүнгар, Алт.өвөр, Алаш. Ургах орчин: Хайргархаг тэгш тал., сайрын ёроол, уул толгодын хээрийн бутарамхай чулуурхаг хажууд Ашигт чанар: Тэмээ жилийн турш сайн иддэг. Бусад мал их идвэл хортой.</p>
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>) Хос талт үрт ургамлын анги (<i>Dicotyledonae</i>) <i>Chenopodiaceae</i> Vent. - Луулийн овог Бударганын төрөл (<i>Salsola</i> L.) <i>Salsola pestifera</i> Nels.-Өргөст бударгана Статус: Элбэг. Биологийн онцлог: 5-80 см өндөр, эгц босоо ширүүвтэр иштэй, навчис шугаман бортгорхуу, үзүүртээ өргөстэй, цэцгүүд иш мөчрийн үзүүрний навчны суганд гурав гурваараа байрлаж түрүү баг цэцэг үүсгэдэг, цэцгийн дагавар шөбгөрхүү урт өргөслөг, шадар эрхтэний навчинцар хальсархаг, далавч нь улаан ягаан. Амьдралын хэлбэр: Нэг наст өвслөг ургамал. Тархалт: Хэнт., Ханг., Монг. –Даг., Ховд., Монг.-Алт., Дунд.Халх, Дорн.-Монг., Их н., Олон н., Дорн.-Говь., Говь-Алт., Зүүнгар., Алт.-өвөр., Алаш. Ургах орчин: Уулын чулуурхаг бэл, сайр садрагын ёроол, дэрсэн шугуй, ургсууриан газар ургана. Ашигт чанар: Адуу, үхэр хавар, намар тааруу, хонь ямаа ногоон үед нь тааруу, өвөл, хавар эрт сайн иддэг. Тэмээ жилийн турш сайнаас онц сайн иддэг.</p>
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>) Хос талт үрт ургамлын анги (<i>Dicotyledonae</i>) <i>Chenopodiaceae</i> Vent. - Луулийн овог Хамхуулын төрөл (<i>Corispermum</i> L.) Зүйл: <i>Halogeton glomeratus</i> (М.В.)С.А.Мей.-Баг хуш-хамхаг Статус: Элбэг Биологийн онцлог: Зайдасархуу махлаг навчистай, цагаан юмуу ягаавтар улаан иштэй, дэлгэмэл, хааяа марцлаг элстэй хөрсөнд 20 см хүртэл ургадаг, жижигхэн ургамал. Амьдралын хэлбэр: Нэг наст өвслөг ургамал. Тархалт: Их н., Олон н., Зүүнгар., Алт. өвөр., Дорн. говь. Ургах орчин: Цөлийн хайргархаг чулуурхаг бэл, хормой, тогтворгүй элс, сайрын ёроол, сийрэг дэрсэн шугуй, довон ба сэвсгэр марцанд ургана. Ашигт чанар: Тэмээ, бог мал тааруухан иднэ.</p>
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>) Хос талт үрт ургамлын анги (<i>Dicotyledonae</i>) <i>Chenopodiaceae</i> Vent. - Луулийн овог Загын төрөл (<i>Haloxylon</i> Bge.) Зүйл: <i>Haloxylon ammodendron</i> (С.А.Мей.) Bge.-Зайсангийн заг Статус: Заган ой үүсгэдэг. Биологийн онцлог: 4 м хүртэл өндөр ургадаг, мөчир нь ногоон үеүдтэй, навчис бүр мөсөн үгүйрсэн юмуу найлзуурын үеийн ирмэгээр богинохон төвгөр үлдвэртэй, цэцэглэх мөчир салаа нь зөвхөн урд жилийн найлзуур дээр үүсдэг, цэцгийн шадар эрхтэн 5 навчинцартай, жимслэх үед өргөн далавч ургуулдаг. Амьдралын хэлбэр: Тагдгар мод. Монгол дахь тархалт: Их н.,</p>


	<p>Олон н., Дорн. говь., Говь-Алт., Зүүнгар., Алт.-өвөр., Алаш. Ургах орчин: Нүүдэг элс, сондог, элсэрхэг хайргархаг хооллойд ургана. Ашигт чанар:Залуу найлзуурыг жилийн турш тэмээ сайн, унасан найлзуур, жимсийг хонь, ямаа намар орой, өвөлдөө сайн иддэг.</p>
Cruciferae Juss.- Тоонолжин цэцэгтэний овог	
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>) Хос талт үрт ургамлын анги (<i>Dicotyledonae</i>) Овог: <i>Cruciferae Juss.- Тоонолжин цэцэгтэний овог</i> Янгицын төрөл (<i>Ptilotrichum C. A. Mey.</i>) Зүйл: <i>Ptilotrichum canescens C.A. Mey.-Бууралдуу янгиц</i> Статус: Элбэг Биологийн онцлог: 3-10 см өндөр ургадаг, навчис шугаман гонзгой, мохоо, 4 юмуу өдлөг цацрагт үсжилттэй, цацаг баг цэцэг өтгөн, богинохон, тал бөмбөлөг хэлбэртэй, дэлбэ 4 гишүүнт, цагаан. Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал. Тархалт: Хөвс., Хэнт., Ханг., Монг.-Даг., Ховд., Монг. Алт., Дунд. Халх., Дорн. Монг., Олон н., Дор.говь., Говь – Алт., Алт. өвөр., Алаш.. Ургах орчин: Цөлөрхөг хээрийн чулуурхаг ба хайргат хажуу, элсэрхэг хээр талд ургана. Ашигт чанар: Бог мал зун, намар дунд зэрэг, адуу маш бага иддэг.</p>
Rosaceae Juss. -Сарнайн овог	
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>) Хос талт үрт ургамлын анги (<i>Dicotyledonae</i>) <i>Rosaceae Juss. -Сарнайн овог</i> Бүйлэсний төрөл (<i>Amygdalus L.</i>) Зүйл: <i>Amygdalus pedunculata Pall.-Барилт бүйлэс</i> Статус: Элбэг ургамал Биологийн онцлог: Өргөсгүй мөчиртэй, 0,5-1,5 м хүртэл өндөр ургадаг, навчис гонзгойдуу тонгоруу өндгөрхүү юмуу зууван хэлбэртэй, хөрөөн шүдлэгтэй, сийрэг тачир үсэрхэг, цэцэг тод ягаан, суумал, навчлахын өмнө дэлгэрдэг, хатуу яст жимсгэнэ жимстэй, урт бариултай, гадуураа өтгөн тачир үсэрхэг. Амьдралын хэлбэр: Сөөг. Монгол дахь тархалт: Хэнт., Ханг., Монг.-Даг., Ховд., Монг.-Алт., Дунд.Халх., Дорн. Монг., Их н., Олон н., Дорн. говь., Говь –Алт., Зүүнгар., Алаш., Алт. өвөр. Ургах орчин: Уул толгодын чулуурхаг хажуу, байц хад, ам хавцал, элсэрхэг хээр, сайр садрагаар ургана. Ашигт чанар: Зун, хавартаа навч цэцгээр нь бог мал сайн, бод мал тааруу идээшлэнэ. Адуу, үхэр огт хөндөхгүй.</p>
Leguminosae Juss. - Буурцагтаны овог	
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>) Хос талт үрт ургамлын анги (<i>Dicotyledonae</i>) <i>Leguminosae Juss. - Буурцагтаны овог</i> Хунчирын төрөл (<i>Astragalus L.</i>) Зүйл: <i>Astragalus laguroides Pall.-Туулайн хунчир</i> Статус: Элбэг Биологийн онцлог: Ишгүй дэвсмэл, өндиймөл ургамал, навчинцар 4-8 хос, юлдэрхүү зуувгар, ширүүн үсэрхэг саарал мөнгөлөг өнгөтэй. Цэцэг бойтгорхуу, хондон улаан юмуу нил хөх өнгөтэй, цацаг толгойрхуу, буурцаг 7-8 мм урт. Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал. Монгол дахь тархалт: Хэнт., Ханг., Монг. -Даг., ховд., Монг. Алт., Дунд Халх., Их н., Олон н., Говь-Алт., Дорн. говь., Алаш. Ургах орчин: Уулын хайргархаг чулуурхаг хажуу, бэл, сайрын ирмэг, чулуу асга, нураг, хад чулуу болон элсэрхэг хээрт ургана. Ашигт чанар: Ногоон үед нь бог мал дунд зэрэг, адуу үхэр муу иддэг</p>

Geraniaceae Juss. - Шимтэглэйн овог



Бүрхүүл үрт ургамлын хүрээ (*Angiospermae*)
Хос талт үрт ургамлын анги (*Dicotyledonae*)
Geraniaceae Juss. - Шимтэглэйн овог
Заан тавагын төрөл (*Erodium L.*)
Зүйл: *Erodium tibetanicum Edgew.- Төвд заантаваг*
Статус: Элбэг
Биологийн онцлог: Дэвсмэл иштэй, өтгөн налархай үслэгтэй, өдлөг цуулбар навчтай, навчны салбан хүрээрхүү, мохоо, салбанлаг, цайвар ягаан жижигхэн цэцэгтэй, дэвсгэр навчтай, бяцхан саарал ургамал. **Амьдралын хэлбэр:** Нэг наст өвслөг ургамал. **Монгол дахь тархалт:** Хэнт., Ханг., Монг.-Даг., Дунд.Халх., Дорн. Монг., Их н., Олон н., Дорн. говь., Говь –Алт., Зүүнгар., **Ургах орчин:** Уулын үйрмэг чулуутай чулуурхаг хажуу, хормой, сайрын осор, суумал нимгэн элсэнд ургана. **Ашигт чанар:** Бог мал, ялангуяа ямаа дуртай иддэг

Euphorbiaceae Juss. - Сүүтэний овог



Бүрхүүл үрт ургамлын хүрээ (*Angiospermae*)
Хос талт үрт ургамлын анги (*Dicotyledonae*)
Euphorbiaceae Juss. - Сүүтэний овог
Сүүтэний төрөл (*Euphorbia L.*)
Зүйл: *Euphorbia humifusa Willd.- Налчигар сүүт өвс*
Статус: Элбэг
Биологийн онцлог: Ацан салаатай, дэвсмэл нарийхан найлзууртай жижигхэн ургамал. Навчим 5-10 мм урт, ташуу өндгөрхүү, чагталсан, дагавар навчтай, циатий найлзуурын салаанд ганц нэгээр байрладаг. **Амьдралын хэлбэр:** Нэг наст өвслөг ургамал. **Монгол дахь тархалт:** Ханг., Монг. –Даг., Дунд. Халх., Дорн. –Монг., Дорн. говь., Олон н., Говь –Алт., Их н., Олон н., Алт. өвөр. Өмнөговь дахь тархалт: Баянзаг. **Ургах орчин:** Үйрмэг чулуутай элсэрхэг хуурай хажуу, бэл хормой, эргийн хуурай хайрга, сайрын оёорт ургана. **Ашигт чанар:** Бог мал зундаа муу иддэг. Хөрсний бүтэц, бүрэлдэхүүн: Цайвар бор хөрсөнд.

Zygophyllaceae R. Br. -Хотирын овог



Бүрхүүл үрт ургамлын хүрээ (*Angiospermae*)
Хос талт үрт ургамлын анги (*Dicotyledonae*)
Zygophyllaceae R. Br. -Хотирын овог
Хармагын төрөл (*Nitraria L.*)
Зүйл: *Nitraria sibirica Pall.- Сибирь хармаг*
Статус: Элбэг ургамал
Биологийн онцлог: 50 см хүртэл өндөр задгай саравгар сөөг. 1 м хүртэлх урт дэвсмэл мөчиртэй, марзлаг элсэн дээр 1 м хүртэл өндөр довон үүсгэдэг, махлаг юлдэрхүү навчтай, өтгөн улаан өнгийн өндгөрхүү юмуу бөөрөнхий шүүслэг яст жимстэй. **Амьдралын хэлбэр:** Олон наст саравгар сөөглөг ургамал. **Монгол дахь тархалт:** Монг.-Алт., Дунд. Халх., Дорн. Монг., их н., Олон н., Дорн. говь., Говь-Алт., Зүүнгар., Алт. -өвөр., Алаш. **Ургах орчин:** Марзлаг овгор элс, хужир мараа, тойрмын зах, дэрс, сайрын элсэрхэг хөвөөгөөр ургана. **Ашигт чанар:** Тэмээ, Бог мал навч жимс, залуу мөчрийг дунд зэрэг иддэг. Жимсийг хүнсэнд болон Монгол уламжлалт эмнэлэгт хэрэглэнэ.



Бүрхүүл үрт ургамлын хүрээ (*Angiospermae*)
Хос талт үрт ургамлын анги (*Dicotyledonae*)
Zygophyllaceae R. Br. -Хотирын овог
Хотирын төрөл (*Zygophyllum L.*)
Зүйл: *Zygophyllum Rosovii Bge.- Розовын хотир*
Статус: Элбэг ургамал.
Биологийн онцлог: Дэвсмэл иштэй, нэг хос өндгөрхүү, шовхдуу, хэлтгий талтай навчинцартай, навчны тэнхлэгийн үзүүрт сүлд унамтгай цагаан сэртэнтэй, хонхорцог далбангүй, 18-25 см урт, 3-4 мм голчтой. **Амьдралын хэлбэр:** Олон наст өвслөг ургамал. **Монгол дахь тархалт:** Ханг., Монг. –Алт., Их н., Олон н., Дорн. говь., Говь-Алт., Зүүнгар, Алт. -өвөр., Алаш. **Ургах орчин:** Үйрмэг чулуутай цөл, уул толгодын бэл хормой, чулуурхаг хажуу, хад асга, улаан шавар, элсэн чулуу, булгийн марзлаг эрэг, дэрсэнд

	ургана. Ашигт чанар: Адуу, үхэр хавраас зун хүртэл тааруу, бусад мал дунд зэрэг иддэг.
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (Angiospermae) Хос талт үрт ургамлын анги (Dicotyledonae) Zygophyllaceae R. Br. -Хотирын овог Хотирын төрөл (Zygophyllum L.) Зүйл: Zygophyllum pterocarpum Bge.- Дэвүүрт хотир Статус: Элбэг Биологийн онцлог: Газар зулж ургадаг, дэлхээ иштэй, 2-3 хос навчинцартай, зууван навчинцартай, дагавар навч өвслөг ногоон, хонхорцог нарийхан далбанлаг зууван хэлбэртэй. Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал. Монгол дахь тархалт: Монг.-Алт., Их н., Олон н., Дорн. говь., Говь-Алт., Зүүнгар, Алт. -өвөр., Алаш. Ургах орчин: Чулуурхаг ба хадтай хуурай хажуу, толгодын хормой, сайрын элсэрхэг хайрган оёор, нураг, улаан шавар, элсэн чулуунд ургана. Ашигт чанар: Бог мал, тэмээ дунд зэрэг иддэг.</p>
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (Angiospermae) Хос талт үрт ургамлын анги (Dicotyledonae) Zygophyllaceae R. Br. -Хотирын овог Зангууны төрөл (Tribulus L.) Зүйл: Tribulus terrestris L.- Зэлэн буюу нохойн зангуу Статус: Элбэг ургамал Биологийн онцлог: Салаархаг, дэвсмэл, 50 см хүртэл урт ургадаг, навчис 6-8 хос өдлөг, дээд тал нүцгэн, доороо ишний адил урт үсэрхэг, навчны өвөрт 5 гишүүнт шар цэцэгтэй, 2-4 хурц хатуу өргөстэй жимстэй. Амьдралын хэлбэр: Олон наст навтгар сөөглөг ургамал. Монгол дахь тархалт: Ханг., Дунд. Халх., Дорн. Монг., Их н., Олон н., Дорн. говь., Говь-Алт., Зүүнгар, Алт. -өвөр., Алаш. Ургах орчин: Чулуурхаг болон үйрмэг чулуут, марзлаг бэл хормой, элс, сайрын элсэн оёор, булагын марзлаг эрэг, тойромд ургана. Ашигт чанар: Ногоон үед нь мал дунд зэрэг иддэг. Өргөстэй зангуу нь малын хоолой, ялангуяа тэмээнд гэмтэл учруулдаг хөнөөлт ургамал. Үрийг Монгол уламжлалт эмнэлэгт хэрэглэнэ.</p>
Plumbaginaceae Juss. - Хорголжингийн овог	
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (Angiospermae) Хос талт үрт ургамлын анги (Dicotyledonae) Plumbaginaceae Juss. - Хорголжингийн овог Бэрмэгийн төрөл (Limonium Mill.) Зүйл: Limonium tenellum (Turcz.) Ktze.- Нарийн бэрмэг Статус: Элбэг Биологийн онцлог: 5-30 см өндөр ургадаг, эгц босоо, үл мэдэг тахиралдсан, нарийхан гоолиг иштэй, навч дэвсээ, шугаман хүрээрхүү, баг цэцэг сийрэг, цэцнш цэнхэр ягаан. Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал. Монгол дахь тархалт: Дунд. Халх., Олон н., Дорн. говь., Говь-Алт., Алт. - өвөр., Алаш. Ургах орчин: Цөлийн үйрмэг чулуут болон чулуурхаг хажуу, бэл хормой, хайрга чулуутай цөлөрхөг хээр, асга хаданд ургана. Ашигт чанар: Бог мал зундаа тааруухан иддэг.</p>
Boraginaceae Juss. - Ноцоргонын овог	
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (Angiospermae) Хос талт үрт ургамлын анги (Dicotyledonae) Boraginaceae Juss. - Ноцоргонын овог Бэрэмэгийн төрөл (Arnebia Forsk.) Зүйл: Arnebia fimbriata Maxim. - Цацагт ба хөх бэрэмэг Статус: Элбэг Биологийн онцлог: 10-30 см өндөр, сууриасаа салаархаг, өтгөн үсэрхэг саарал ургамал. Дэлбэ цагаан, хөх ягаан, цайвар ягаан, хадаасархуу, нарийн хоолойтой, салбан нь захаараа богино цацаглаг, долгионтсон. Амьдралын хэлбэр: Хоёр наст өвслөг ургамал. Монгол дахь тархалт: Олон н., Дор.говь., Говь – Алт., Алаш., Алт. өвөр. Ургах орчин: Үйрмэг чулуут, чулуурхаг бэл хормой, хад асга, элсэрхэг хайрган оёороор ургана. Ашигт чанар: Тэмээ зун дунд зэрэг, бог мал тааруу иддэг.</p>

Convolvulaceae Juss. - Сэдэргэнийн овог



Хүрээ: Бүрхүүл үрт ургамлын (*Angiospermae*)
Анги: Хос талт үрт ургамлын (*Dicotyledonae*)
Овог: *Convolvulaceae* Juss. - Сэдэргэнийн овог
Сэдэргэнийн төрөл (*Convolvulus* L.)
Зүйл: *Convolvulus fruticosus* Pall.- Сөөгөн сэдэргэнэ
Статус: Элбэг
Биологийн онцлог: Саравгар, хатуу өргөслөг, сийрэг мөчиртэй, цэцэг ягаан, юүлүүрэрхүү, ганц нэг, цоморлигийн навчинцар өтгөн үсэрхэг.
Амьдралын хэлбэр: Сөөг
Тархалт: Монг. Алт., Их н., Олон н., Дор.говь., Говь – Алт., Зүүнгар., Алт.-өвөр., Алаш., **Ургах орчин:** Дов толгод, үйрмэг чулуурхаг цөл, чулуурхаг хажуу, тойрмын захаар ургана. **Ашигт чанар:**Зундаа тэмээ дунд, бог мал бага иддэг.



Хүрээ: Бүрхүүл үрт ургамлын (*Angiospermae*)
Анги: Хос талт үрт ургамлын (*Dicotyledonae*)
Овог: *Convolvulaceae* Juss. - Сэдэргэнийн овог
Сэдэргэнийн төрөл (*Convolvulus* L.)
Зүйл: *Convolvulus Ammannii* Desr. – Амманы сэдэргэнэ
Статус:
Биологийн онцлог: Иш дэвсмэл юмуу өндиймөл, 2-10 см урт ургадаг, навчис шугамрхуу юлдэн хэлбэртэй, өтгөн налархай мөнгөлөг үсэрхэг, цэцэг цагаан, юмщ цайвар ягаан, юүлүүрэрхүү, мөчрийн үзүүрт ганц нэгээрээ байрладаг.**Амьдралын хэлбэр:** Олон наст өвслөг ургамал
Тархалт: Хэнт., Ханг., Монг.-Даг., Ховд., Монг. Алт., Дунд. Халх., Дор. Монг., Их н., Олон н., Дор.говь., Говь – Алт., Алаш. **Ургах орчин:** Үйрмэг чулуут болон чулуурхаг хажуу, цөлийн хээрээр ургана. **Ашигт чанар:** Бог мал зун сайн, намар дунд зэрэг иддэг. Газар дээрх биеийг Монгол уламжлалт эмнэлэгт хэрэглэнэ.

Labiaceae Lindl.- Уруул цэцэгтэний овог



Бүрхүүл үрт ургамлын хүрээ (*Angiospermae*)
Хос талт үрт ургамлын анги (*Dicotyledonae*)
Уруул цэцэгтэний овог (*Labiaceae* Lindl.)
Нохойн хэлийн төрөл (*Panzeria* Moench.)
Зүйл: *Panzeria lanata* (L.) Vge. - Үсхий нохойн хэл
Статус: Элбэг
Биологийн онцлог: Бүдүүн, голлосон, модожсон үндэслэг иштэй, олон наст ургамал. Олон тооны иштэй, 15-30 см өндөр, хэсэг хэсэг тунгалаг ноосорсон торгомсог үслэгээр өтгөн бүрхэгдсэн. Навч дугариг хэлбэртэй, тавчилсан цуулбар ба дахин өөрөө мохоо юлдэн салбанд хэрчигдсэн, нарийхан бариултай. Түүрүүрхүү хэлбэрийн өтгөн багцэцэгтэй. Дэлбэ шар өнгөтэй, дээд уруулдаа өтгөн торгомсог үслэгтэй. **Амьдралын хэлбэр:** Олон наст өвслөг ургамал. **Монгол дахь тархалт:** Хэнт., Ханг., Монг.-Даг, Ховд., Монг.-Алт., Дунд. Халх, Дорн.-Монг., Их н., Олон., Дорн. говь Говь Алт., Зүүнгар, Алаш. **Ургах орчин:** Хайрга чулуутай хээржүү хажуу, хадны ёроол, нуранги асга, хуурай ам хавцал, сайрын адаг ба элсэрхэг хээрт ургана. **Ашигт чанар:** Адуу, тэмээ, бог мал зундаа тааруухан иддэг. Газар дээрх биеийг Монгол уламжлалт эмнэлэгт хэрэглэнэ.

Asteraceae Dumort. -Голгэсэртэний овог	
	<p>Хүрээ: Бүрхүүл үрт ургамлын (<i>Angiospermae</i>) Анги: Хос талт үрт ургамлын (<i>Dicotyledonae</i>) Овог: Голгэсэртэний (<i>Asteraceae Dumort.</i>) Согсоолжийн төрөл (<i>Heterorappus Less.</i>) Зүйл: <i>Heterorappus hispidus (Thunbg.) Less.-Арзгар согсоолж</i> Статус: Элбэг Биологийн онцлог: Иш ногоон, 30-100 см өндөр ургадаг, урт шулуун сэрэвгэр үслэгтэй, навч уртавтар зууван, сагсны хэл цэцэг цагаан, ороолт навчинцар өвслөг. . Амьдралын хэлбэр: Хоёр наст өвслөг ургамал. Тархалт: Хэнт., Ханг., Монг.-Даг., Хянг., Ховд., Дунд. Халх., Дорн. Монг., Их н., Олон н., Говь – Алт., Алаш. Ургах орчин: Үйрмэг чулуу бай чулуутай хээржүү хажуу, хад чулуу, эргийн хайга, сайрын оёорт ургана. Ашигт чанар: Хонь, ямаа сайн иддэг, Адуу, үхэр дунд зэрэг иддэг.</p>
	<p>Хүрээ: Бүрхүүл үрт ургамлын (<i>Angiospermae</i>) Анги: Хос талт үрт ургамлын (<i>Dicotyledonae</i>) Овог: Голгэсэртэний (<i>Asteraceae Dumort.</i>) Төрөл: Шарилж (<i>Artemisia L.</i>) Зүйл: <i>Artemisia frigida Willd.-Агь</i> Статус: Элбэг Биологийн онцлог: Богино үндэслэг иштэй, өтгөн бутаар ургадаг, 10-40 см өндөр цайвар саарал хуурайсаг ургамал. Навчис налчгар торгомсог цайвар үслэгээр өвс хучигдмал, өдлөөг цуулбар, сагснууд нийлж унжгардуу цацаг баг цэцэгт нэгддэг. Амьдралын хэлбэр: Сөөгөнцөр. Тархалт: Хөвс., Хэнт., Ханг., Монг. –Даг., Ховд., Монг. Алт., Дунд. Халх., Дорн. Монг., Их н., Олон н., Говь – Алт., Дорн. говь. . Ургах орчин: Уул толгодын чулуурхаг ба хайргархаг хажуу, бэл хормой, хадархаг газар ургана. Ашигт чанар: Аль ч улиралд мал сайн иддэг, шимт чанар өндөр ургамал. Газар дээрх бие, үндэсийг Монгол уламжлалт эмнэлэгт хэрэглэнэ.</p>
	<p>Хүрээ: Бүрхүүл үрт ургамлын (<i>Angiospermae</i>) Анги: Хос талт үрт ургамлын (<i>Dicotyledonae</i>) Овог: Голгэсэртэний (<i>Asteraceae Dumort.</i>) Тайжинсийн төрөл (<i>Echinops L.</i>) Зүйл: <i>Echinops Gmelinii Turcz.-Гмелиний тайжинс</i> Статус: Элбэг Биологийн онцлог: Иш эгц босоо, үзүүрээдээ салаархаг, навч өдлөг хагалбар, ирмэгээрээ 5 мм урт зүүрхүү өргөс шивүүртэй, иш юмуу салааны үзүүрт нэг юмуу хэ хэдн цэнхэрдуу бөөрөнхий баг цэцэгтэй. Амьдралын хэлбэр: Нэг наст өвслөг ургамал. Тархалт: Ханг., Дунд. Халх., Дорн. Монг., Их н., Олон н., Дорн. говь., Говь – Алт., Зүүнгар, Алт. өвөр., Алаш. Ургах орчин: Элсэн хурдас, элсэн манхан, уул толгодын бэл хормой, сайр садрага дагасан элс, цөлийн хээрт ургана. Ашигт чанар: Адуу, тэмээ зундаа зөвхөн сагсыг иддэг. Үндэсийг Монгол уламжлалт эмнэлэгт хэрэглэнэ.</p>
	<p>Хүрээ: Бүрхүүл үрт ургамлын (<i>Angiospermae</i>) Анги: Хос талт үрт ургамлын (<i>Dicotyledonae</i>) Овог: Голгэсэртэний (<i>Asteraceae Dumort.</i>) Төрөл: Шарилж (<i>Artemisia L.</i>) Зүйл: <i>Artemisia scoparia Waldst. et Kit.-Ямаан шарилж</i> Статус: Элбэг Биологийн онцлог: 30-70 см өндөр ургадаг, иш ганц юмуу 2-5, дундаасаа дээш мөчирлөн салаалсан, хошоод өдлөг цуулбар, үзүүрийн салбанцар шугамархуу утаслаг нарийн, сагс өргөн зууван, жижигхэн, унжиж гудайдаг, цацгархуу залаа баг цэцэгт нэгддэг. Амьдралын хэлбэр: Нэг наст өвслөг ургамал. Тархалт: Ханг., Монг.-Даг., Хянг., Монг. Алт., Дунд. Халх., Дорн. Монг., Их н., Олон н., Говь – Алт., Дорн. говь., Зүүнгар., Алт. өвөр., Алаш. Ургах орчин: Уулын чулуурхаг хажуу, элсэрхэг хээрээр ургана. Ашигт чанар: Хонь, ямаа, тэмээ ногоон үед нь дунд зэрэг иддэг, хатсан үед нь сайн иддэг.</p>